



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ГАЗРЫН ТОСНЫ САЛБАРТ БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭГЭЭР ОЛБОРЛОЛТЫН
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ ПЕТРОЧАЙНА ДАЧИН ТАМСАГ ХХК-ИЙН
2014-2018 ОНЫ БАТЛАГДСАН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨСВИЙН ДАГУУ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ,
НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ӨРТӨГ НӨХСӨН БОЛОН НӨХӨГДӨХ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ,
ГАЗРЫН ТОСНЫ ЭКСПОРТ, БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН ТООЦОО,
ХУВААРИЛАЛТАД БАТАЛГААЖУУЛАЛТ ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

**ГЭРЭЭЛЭГЧИЙН 2014-2018 ОНД ТАЙЛАГНАСАН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫГ 8.9
САЯ АМ.ДОЛЛАРООР НЭМЭГДҮҮЛЭН 1,923.8 САЯ АМ.ДОЛЛАРООР, ӨРТӨГ
НӨХӨГДӨХ ЗАРДЛЫГ 58.8 САЯ АМ.ДОЛЛАРООР БУУРУУЛАН 1,299.0 САЯ
АМ.ДОЛЛАРООР ТУС ТУС БАТАЛГААЖУУЛЛАА**

Улаанбаатар хот
2022 он



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2022 оны 09 сарын 26 өдөр

Дугаар А/40

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт, 29.3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2020 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 05, тус тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 02 дугаар тогтоолын дагуу “Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн 2014-2018 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалт”-д баталгаажуулалт хийсэн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар өгсөн акт, албан шаардлагын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороод, Монгол Улсын Ерөнхий сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Ашигт малтмал, газрын тосны газарт тус тус хүргүүлэх ажлыг зохион байгуулахыг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч (Я.Сарансүх)-д даалгасугай.

3. Аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд (Л.Оюун-Эрдэнэ), Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд (Ж.Ганбаатар), Ашигт малтмал, газрын тосны газрын дарга (Л.Баярмандал)-д зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч (Я.Сарансүх)-д даалгасугай.

5. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг Аудитын хоёрдугаар газар (Ц.Наранчимэг)-т үүрэг болгосугай.

Д.ЗАНДАНБАТ

ТӨЛБӨРИЙН АКТ, АЛБАН ШААРДЛАГЫН ЖАГСААЛТ

д/д	Зөрчлийн утга	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Дугаар, огноо		Дүн /ам.доллар/
1	Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн Тосон Уул XIX, Тамсаг ХХI гэрээт талбайн талаар 1993, 1995 онд байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээг Газрын тосны тухай хуульд нийцүүлэн шинэчлээгүй байна.	Бүтээгдэхүүн хуваах гэрээг Газрын тосны тухай хуульд нийцүүлэн шинэчлэх	Албан шаардлага	980/A0110001 АХГ-2021/16- HAA-CA	0.00
2	Газрын тосны борлуулалтын орлогыг дутуу тайлагнасан, борлуулалттай холбогдон гарах зардлыг илүү тооцсон, мөн Тосон Уул XIX талбайд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр зэргээс шалтгаалан Монгол Улсын Засгийн газарт 30,438,708.94 ам.доллар буюу 66,727,588,846.38 төгрөгийг дутуу тооцож төвлөрүүлсэн байна.	Петрочайна Дачин Тамсаг ХХК-иас уг төлбөрийг нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх	Төлбөрийн акт	199/A0150053 АХГ-2021/16- HAA-CA	30,438,708.94
3	Газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон гэрээлэгч хооронд газрын тос экспортлох үйл ажиллагааны үед гарах технологийн хорогдлын хэмжээг харилцан тохиролцож баталгаажуулаагүйгээс талууд 2014-2018 онд борлуулсан газрын тосны хэмжээг 175,419.17 баррелиар, борлуулалтын орлогыг 8,298,497.07 ам.доллар буюу 20,791,315,800.15 төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.	Газрын тос экспортлох үйл ажиллагааны үед гарах технологийн хорогдлын хэмжээг бодит тооцоо судалгаанд үндэслэн тогтоож эрх зүйн актаар баталгаажуулах, хэрэгжилтийг хангах арга хэмжээг авах	Албан шаардлага	982/A0150053 АХГ-2021/16- HAA-CA	8,298,497.07
4	Бүтээгдэхүүн хуваах гэрээний зарим заалт, Монгол Улсын хууль тогтоомжтой нийцээгүй, БХГ-ээр зохицуулахаар заасан зарим заалт огт хэрэгжээгүй байна.	Газрын тос олборлох үйл ажиллагаанд Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөх, Нийгмийн даатгалын шимтгэл болон хувь хүний орлогын албан татвартай холбоотой тооцооллыг дахин хийж, холбогдох байгууллагуудаар баталгаажуулах	Албан шаардлага	983/A0150053 АХГ-2021/16- HAA-CA	0.00
Нийт дүн					38,737,206.01

Агуулга

Тайланг бэлтгэсэн:	Хүснэгтэн мэдээллийн жагсаалт	3
	Товчилсон үгийн жагсаалт	4
Үндэсний аудитын газрын	Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	5
Аудитын хоёрдугаар газар	Аудитын зорилт	5
	Аудитын хамрах хүрээ	5
Эс Эм Аудит ХХК	Аудитын арга зүй	5
Азуре Хүлүг Аудит ХХК	Үндсэн мэдээлэл	6
2022 оны 09 дүгээр сар	БҮЛЭГ 1. НИЙТ БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН 24.3 ХУВЬ БУЮУ 466.7 САЯ АМ.ДОЛЛАР МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАРТ, 63.4 ХУВЬ БУЮУ 1,219.5 САЯ АМ.ДОЛЛАР ГЭРЭЭЛЭГЧИД НОГДОЖ БАЙНА	7-18
	1.1 Гэрээлэгч экспортолсон газрын тосны хэмжээг 0.2 сая баррелиар, борлуулалтын орлогыг 8.9 сая ам.доллараар дутуу тайлагнасан байна	7-11
Тайланг УАГ-ын цахим сайтаас үзнэ үү. www.audit.mn	1.2 Гэрээлэгч 2014-2018 онд нийт 58.8 сая ам.долларын өртөг нөхөгдөх зардал илүү бүртгэж, тайлагнасан байна	11-15
<i>Аудитын тайлан дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261885, 261740 дугаарын утсаар харилцана уу.</i>	1.3. Нийт борлуулалтын орлогоос 237.6 сая ам.долларын борлуулалттай холбоотой зардлыг хасаж, үлдсэн хэсгийн 24.3 хувь буюу 466.7 сая ам.доллар МУЗГ-т, 63.4 хувь буюу 1,219.5 сая ам.доллар гэрээлэгчид тус тус ногдож байна	15-18
Хаяг:	БҮЛЭГ 2. ГАЗРЫН ТОСНЫ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА	18-27
<i>Үндэсний аудитын газар Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3 Засгийн газрын IY байр Улаанбаатар хот 15160 Монгол Улс</i>	2.1 Ашигт малтмал, газрын тосны газар нь гэрээлэгчийн хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтын тайлан мэдээг хүлээн авсан ч хянаж, нэгтгэх чиг үүргийг хэрэгжүүлээгүй байна	18-25
	2.2 Гэрээлэгчийн газрын тосны ашиглалтын үйл ажиллагааны анхдагч мэдээ, тайлан, материалыг хүлээн авах, жилийн ажлын төлөвлөгөө төсвийн гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй байна	25-27
	БҮЛЭГ 3. БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭГ ШИНЭЧИЛЖ, МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖИД НИЙЦҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА	27-35
	3.1 Гэрээний талууд зөвшилцөлд хүрээгүйгээс Бүтээгдэхүүн хуваах гэрээг шинэчлэх ажил зогсонги байдалтай байна	27-29
	3.2 Бүтээгдэхүүн хуваах гэрээг шинэчлээгүйгээс Газрын тосны тухай хууль болон бусад хууль тогтоомжтой нийцэхгүй байх үр дагавар үүсэж байна	29-35
	Холбогдох байгууллагын санал, хариу тайлбар	36-40
	Дүгнэлт	41-42
	Зөвлөмж	43
	Зөрчлийн нэгтгэл	44
	Хавсралт 1	45-48
	Хавсралт 2	49
	Хавсралт 3	50-51
	Хавсралт 4	51
	Хавсралт 5	52
	Хавсралт 6	53
	Хавсралт 7	54-56
	Хавсралт 8	57
	Хавсралт 9	58-60

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж буй Петрожайна Дачин Тамсаг ХХК-ийн 2014-2018 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийсэн аудитын тайлан

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1	Гэрээлэгчийн төлөвлөгөө, төсөв, өртөг нөхөгдөх зардал
Хүснэгт 2	Гэрээлэгчийн Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайн 2014-2018 онд борлуулсан тос, борлуулалтын орлого, хуваарилалт
Хүснэгт 3	Тосон Уул XIX талбайд олборлосон газрын тос
Хүснэгт 4	Тамсаг XXI талбайд олборлосон газрын тос
Хүснэгт 5	Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайд экспортолсон/борлуулсан газрын тос
Хүснэгт 6	Газрын тос борлуулахтай холбоотой гарсан зардал
Хүснэгт 7	Тээврийн зардал
Хүснэгт 8	Тосон Уул XIX талбайн 2014-2018 оны өртөг нөхөгдөх зардал
Хүснэгт 9	Тамсаг XXI талбайн 2014-2018 оны өртөг нөхөгдөх зардал
Хүснэгт 10	Өртөг нөхөгдөх боломжтой зардлын үлдэгдэл /1993 оноос 2018 он дуустал/
Хүснэгт 11	Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайн газрын тосны хуваалт /ам.доллароор/
Хүснэгт 12	Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайн газрын тосны хуваалт /хувиар/
Хүснэгт 13	МУЗГ-т ногдсон газрын тосны орлого төвлөрүүлэлт
Хүснэгт 14	Тосон Уул, Тамсагийн газрын тосны ордыг ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан бүтээн байгуулалтын ажлууд
Хүснэгт 15	Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайн 2014-2018 оны ажлын жилийн төлөвлөгөө, төсөв
Хүснэгт 16	Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайн 2014-2018 оны ажлын жилийн төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэл
Хүснэгт 17	Орд ашиглалтын зардлын нэгтгэл
Хүснэгт 18	Дэд бүтэц, гадаргуун байгууламжийн ажлууд, машин, туслах тоног төхөөрөмжийн зардлын нэгтгэл
Хүснэгт 19	Байгаль орчны хамгааллын ажлын зардлын нэгтгэл
Хүснэгт 20	Гэрээлэгчийн 2014-2018 оны хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэл
Хүснэгт 21	Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайн 2014-2018 онд хэрэгжүүлсэн ажлын жилийн төлөвлөгөө, төсвийн дагуу хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж буй Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн 2014-2018 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийсэн аудитын тайлан

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АМГТГ	Ашигт малтмал, газрын тосны газар
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БХГ	Бүтээгдэхүүн хуваах гэрээ
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ГИХГ	Гадаадын иргэн харьяатын газар
ГТГ	Газрын тосны газар /хуучнаар/
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
НББ	Нягтлан бодох бүртгэл
ОНБ	Олборлолтын нэгдсэн байгууламж
ХХЕГ	Хил хамгаалах ерөнхий газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ӨНЗ	Өртөг нөхөгдөх зардал
ЭБЭХЯ	Эрдэс баялаг, эрчим хүчний яам
DPR	Daily production report

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2020 оны 05, тус тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2021 оны 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2021 оны А/28 дугаар тушаалаар баталсан “Үндэсний аудитын газрын 2021 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-ний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3-т тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Газрын тосны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсгийг тус тус үндэслэн хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж буй Петрожайна Дачин Тамсаг ХХК /цаашид Гэрээлэгч гэх/-ийн Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайн 2014-2018 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтыг Монгол Улсын хууль тогтоомж, Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу үнэн зөв бүртгэж, тайлагнасан эсэхийг тулган баталгаажуулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

1. Гэрээлэгч нь батлагдсан хөтөлбөр, төсвийн дагуу хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтыг хууль тогтоомж болон Бүтээгдэхүүн хуваах гэрээний холбогдох заалтын дагуу гүйцэтгэж, тайлагнасан эсэх;
2. Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага холбогдох хууль тогтоомж болон Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан үүргээ биелүүлж, хяналт тавьсан эсэх;
3. Бүтээгдэхүүн хуваах гэрээ нь Газрын тосны тухай болон бусад хууль тогтоомжтой нийцсэн эсэх.

Аудитын хамрах хүрээ

Аудитад АМГТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Хууль, эрх зүйн хэлтэс, Газрын тосны ашиглалтын хэлтэс, Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр газрын тосны олборлолтын үйл ажиллагаа явуулж буй Петрожайна Дачин Тамсаг ХХК-ийн Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайн 2014-2018 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу олборлосон газрын тос, экспортын хэмжээ, бүтээн байгуулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардал, орлогын хуваарилалт, холбогдох тайлан, мэдээ, судалгаа, Дорнод аймгийн Халхгол, Матад сумдын нутаг дэвсгэрт байрлах Үйлдвэрлэлийн баазад хийсэн ажлын бодит гүйцэтгэлийг хамруулсан болно.

Аудитын арга зүй

Төрийн аудитын тухай, Газрын тосны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайн Бүтээгдэхүүн хуваах гэрээ, түүнтэй холбогдон гарсан протоколууд болон бусад хууль тогтоомжийн холбогдох зүйл, заалтуудыг шалгуур үзүүлэлт болгон АДБОУС 100, 400, 1805, 2805, 4000, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, аудитын заавар, аргачлалын дагуу аудитыг гүйцэтгэсэн.

Гэрээлэгчийн өртөг нөхөгдөх зардлын тайлан, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалт, жилийн ажлын төлөвлөгөө, хөтөлбөр, гүйцэтгэлийн болон санхүүгийн тайлангуудыг нягтлан бодох бүртгэл, анхан шатны баримттай тулган баталгаажуулах, холбогдох мэргэжилтнүүдээс шаардлагатай баримт, материал, лавлагаа тайлбар авах, гүйцэтгэлийг тулган шалгах, газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас зохих хяналтаа хэрэгжүүлсэн эсэх зэрэг аудитын горимыг гүйцэтгэн нотлох зүйл цуглуулж, дүн шинжилгээ хийн аудитын дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж буй Петроцайна Дачин Тамсаг ХХК-ийн 2014-2018 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийсэн аудитын тайлан

Үндсэн мэдээлэл

Петроцайна Дачин Тамсаг ХХК нь Дорнод аймгийн Халхгол, Матад сумын нутагт Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайд газрын тосны ашиглалт, олборлолтын үйл ажиллагааг явуулж, 1998-2021 онд нийт 66.7 сая баррель буюу 9.0 сая тонн газрын тос олборлож, 63.7 сая баррель буюу 8.6 сая тонн газрын тосыг БНХАУ-д экспортолсон байна.

Тус компани нь газрын тосны экспортын орлогын 90 гаруй хувийг бүрдүүлдэг бөгөөд Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар улсын төсөвт 277.5 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр баталсан байна.

Тодруулбал, Тосон Уул, Тамсагийн орд газраас 2022 онд нийт 5.8 сая баррель буюу 0.8 сая тонн түүхий тос олборлож, экспортлох төлөвлөгөөтэй ажиллаж байгаа ба 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн байдлаар 36,885 баррель буюу 5,052 тонн газрын тос олборлосон байна.

АМГТГ-аас ирүүлсэн мэдээллээр гэрээлэгч 2014-2018 онд Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд нийт 2,425.2 сая ам.долларын ажил хийхээр төлөвлөгөө, төсөв батлуулан, 1,234.3 сая ам.долларын гүйцэтгэл тайлагнасан байна.

Хүснэгт 1. Гэрээлэгчийн төлөвлөгөө, төсөв, өртөг нөхөгдөх зардал

/сая ам.доллар/

№	Он	Тосон-Уул XIX		Тамсаг XXI		Нийт	
		Төлөвлөгөө, төсөв	Хөрөнгө оруулалт-өртөг нөхөгдөх зардал	Төлөвлөгөө, төсөв	Хөрөнгө оруулалт-өртөг нөхөгдөх зардал	Төлөвлөгөө, төсөв	Хөрөнгө оруулалт-өртөг нөхөгдөх зардал
1	2014	288.1	170.5	347.5	189.3	635.6	359.8
2	2015	228.1	150.8	341.2	184.1	569.3	334.9
3	2016	195.0	75.2	286.7	77.6	481.7	152.8
4	2017	220.8	84.9	232.9	88.2	453.7	173.1
5	2018	124.6	107.0	160.3	106.6	284.9	213.6
	Дүн	1,056.6	588.4	1,368.6	645.9	2,425.2	1,234.3

Эх сурвалж: АМГТГ-ын 2021 оны 06 сарын 16-ны өдрийн 4/2497 тоот албан бичиг

Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайгаас 2014-2018 онд нийт 34.7 сая баррель тос олборлож, 1,675.8 сая ам.долларын борлуулалт хийснээс МУЗГ-т 427.1 сая ам.долларын ашигт газрын тос¹ ногдсон байна.

Хүснэгт 2. Гэрээлэгчийн Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайн 2014-2018 онд борлуулсан тос, борлуулалтын орлого, хуваарилалт

№	Талбайн нэр	Борлуулсан газрын тос /сая баррель/	Нийт борлуулалтын орлого /сая ам.доллар/	Борлуулалтын орлогын хуваарилалт /сая ам.доллар/			
				Роялти 7.5%	Өртөгт тос 40%	Гэрээлэгчид ногдох	МУЗГ-т ногдох
1	Тосон Уул XIX	18.6	918.6	-	367.4	330.7	220.5
2	Тамсаг XXI	16.1	757.2	56.8	344.8	238.5	206.6
	Дүн	34.7	1,675.8	56.8	712.2	569.2	427.1

Эх сурвалж: АМГТГ-ын 2021 оны 06 сарын 16-ны өдрийн 4/2497 тоот албан бичиг

Петроцайна Дачин Тамсаг ХХК-ийн газрын тостой холбогдсон үйл ажиллагааны талаарх бусад нэмэлт мэдээллийг [Хавсралт 1](#)-ээс үзнэ үү.

¹ Газрын тосны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.33. "ашигт газрын тос" гэж хүргэлтийн цэг дээр хэмжсэн нийт газрын тосноос энэ хуулийн 4.1.26, 4.1.32-т заасан газрын тосыг хасаад Засгийн газар болон гэрээлэгчийн хооронд хуваах газрын тосыг"

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж буй Петрожайна Дачин Тамсаг ХХК-ийн 2014-2018 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийсэн аудитын тайлан

БҮЛЭГ НЭГ. НИЙТ БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН 24.3 ХУВЬ БУЮУ 466.7 САЯ АМ.ДОЛЛАР МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАРТ, 63.4 ХУВЬ БУЮУ 1,219.5 САЯ АМ.ДОЛЛАР ГЭРЭЭЛЭГЧИД НОГДОЖ БАЙНА

1.1 Гэрээлэгч экспортолсон газрын тосны хэмжээг 0.2 сая баррелиар, борлуулалтын орлогыг 8.9 сая ам.доллараар дутуу тайлагнасан байна

Гэрээлэгч нь Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.3²-т заасны дагуу Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайд 2014-2018 онд олборлох газрын тосны төлөвлөгөөг батлуулж, мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.8³, 11.2.14⁴-т заасны дагуу газрын тосны экспорт, борлуулалтын орлогыг улирал бүрээр тайлагнаж, олборлолтын өдөр тутмын мэдээг цахим хэлбэрээр төрийн захиргааны байгууллагад хүргүүлсэн байна.

Олборлосон тос

Гэрээлэгч нь 2014-2018 онд Тосон Уул XIX талбайд 20.9 сая баррель газрын тос олборлохоор төлөвлөснөөс 19.9 сая баррелийг олборлож 95.4 хувийн, Тамсаг XXI талбайд 18.5 сая баррель газрын тос олборлохоор төлөвлөснөөс 16.5 сая баррель буюу 89.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 3. Тосон Уул XIX талбайд олборлосон газрын тос

/мянган баррель/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Аудитаар баталгаажуулсан	Гүйцэтгэлийн хувь	Зөрүү
1	2	3	4	5=4/2	6=4-2
2014 он	3,874.6	4,638.3	4,638.3	119.7	763.7
2015 он	4,864.3	4,926.6	4,926.6	101.3	62.3
2016 он	4,863.6	4,041.1	4,041.1	83.1	(822.5)
2017 он	4,007.9	3,388.5	3,388.5	84.5	(619.4)
2018 он	3,292.7	2,942.2	2,942.2	89.4	(350.6)
Нийт дүн	20,903.1	19,936.7	19,936.7	95.4	(966.4)

Эх сурвалж: 2014-2018 онд олборлосон хий, тос, усны тооцоог Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон Гэрээлэгч хооронд тооцоо нийлж баталгаажуулсан "Протокол"-ууд.

Хүснэгт 4. Тамсаг XXI талбайд олборлосон газрын тос

/мянган баррель/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Аудитаар баталгаажуулсан	Гүйцэтгэлийн хувь	Зөрүү
1	2	3	4	5=4/2	6=4-2
2014 он	2,325.1	2,328.2	2,328.2	100.1	3.2
2015 он	3,755.1	3,361.7	3,361.7	89.5	(393.4)
2016 он	4,875.1	3,842.6	3,842.6	78.8	(1,032.5)
2017 он	4,086.6	3,904.0	3,904.0	95.5	(182.6)
2018 он	3,507.1	3,107.3	3,107.3	88.6	(399.8)
Нийт дүн	18,549.0	16,543.7	16,543.7	89.2	(2,005.2)

Эх сурвалж: 2014-2018 онд олборлосон хий, тос, усны тооцоог Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон Гэрээлэгч хооронд тооцоо нийлж баталгаажуулсан "Протокол"-ууд.

Үүнээс олборлолтын тоног төхөөрөмжгүй шавхалтын цооногуудаас Тосон Уул XIX талбайд 2.2 сая, Тамсаг XXI талбайд 1.3 сая баррель тос олборлосон байна.

Газрын тос олборлолтын үйл ажиллагааны анхан шатны баримт бүрдүүлэлт, түүнд тавих хяналт хангалтгүй, өдөр тутмын (DPR) мэдээг тухай бүр ачилт хийсэн ажилтан, жолооч, хянасан мэргэжилтэн гарын үсэг зурж баталгаажуулаагүй, автомашины тоо, олборлолт хийсэн цооногийн тоо, ачсан шингэний хэмжээ, усны агууламжийн бүртгэл нь анхан шатны баримтаас

² "жилийн төлөвлөгөө, төсвийг төрийн захиргааны байгууллагаар батлуулж, хэрэгжүүлэх";

³ "гэрээлэгчийн тухайн жилийн хөрөнгө оруулалт, зардал, нөөц ашигласны төлбөр, олборлосон болон борлуулсан газрын тосны тайланг хянаж нэгтгэх";

⁴ "санхүүгийн тайлан, өртөг нөхөгдөх зардлын тайлан, газрын тос хуваах тооцоог энэ хуулийн 7.1.4-т заасан журмын дагуу үнэн зөв гаргаж, төрийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгөх";

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж буй Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн 2014-2018 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийсэн аудитын тайлан

зөрүүтэй байгаа зэрэг нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1⁵, 13.4⁶, 13.6⁷ дахь заалтыг зөрчсөн байна.

Мөн гэрээлэгч нь Тосон Уул XIX талбайд 2014 оны төлөвлөгөө, хөтөлбөрт батлагдаагүй 14 цооногоос 74,609.6, 2016 онд 8 цооногоос 89,174.0, 2017 он 39 цооногоос 243,963.8, 2018 онд 21 цооногоос 74,691.53 баррель газрын тос олборлосон нь Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.3⁸-т заасантай нийцээгүй байна.

Хийн бүтээгдэхүүн

БХГ-ний 9 дүгээр зүйл⁹-д хийн бүтээгдэхүүн хуваалтын талаар зохицуулсан бөгөөд хийг олборлох, борлуулах төслийг хэрэгжүүлэх нь эдийн засгийн хувьд үр ашигтай гэж үзэх нэг буюу хэд хэдэн зах зээл Монгол Улсад эсвэл хилийн чанадад байгаа эсэхийг тогтоохоор аль нэг талынхаа санал хүсэлтээр уулзалт хийх, уулзалтыг улиралд нэгээс цөөнгүй удаа зохион байгуулахаар заасан байна.

Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайн ТА-1, ТА-2 ил байгууламжаас нийт 92.5 сая м.куб хий ялгаснаас 56.2 сая м.кубийг халаах зууханд, 4.6 сая м.кубийг хийн генераторт ашиглаж, 31.7 сая м.куб хийг бамбардаж устгасан байна.

Хэдийгээр хийн бүтээгдэхүүний үр ашигтай нээлт илрээгүй боловч халаалт, эрчим хүчний эх үүсвэр болгон ашигласан 60.8 сая м.куб хийн эдийн засгийн үр ашиг, эрчим хүчний бодит хэмнэлт, өртөгт тосны хэмжээг бууруулах зэрэг боломжийг судалж тооцоолоогүй, нарийвчилсан зохицуулалтгүй байна.

Газрын тосны экспорт, борлуулалтын орлого

ГТГ, Гэрээлэгчийн хооронд байгуулсан 2011 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн протоколоор Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайгаас олборлосон, МУЗГ-т ногдох түүхий тосыг дэлхийн зах зээлийн үнэд нийцсэн боломжит өндөр үнээр хилийн чанад дахь худалдан авагч талд борлуулах эрх¹⁰-ийг Петрочайна Дачин Тамсаг ХХК-д олгосон байна.

Борлуулж буй түүхий тосны хэмжилт болон МУЗГ-т ногдох түүхий тосны борлуулалтын орлогыг тооцох талаар харилцан протокол¹¹-оор тохиролцож, гэрээлэгч 2014-2018 онд Хятадын үндэсний газрын тосны нэгдсэн корпорац /China national united oil corporation/-тай, 2014 онд Петрочайна олон улсын /Хонг Конг/ корпорац /PetroChina International /Hong Kong/ Corporation Limited/-тай тус тус газрын тос борлуулах 2-3 гэрээ байгуулж, хугацааг сунгаж ирсэн байна.

Гэрээлэгч 2014-2018 онд нийт 35.4 сая баррель тос экспортолж, 1,915.0 сая ам.долларын борлуулалтын орлого тайлагнаснаас Тосон Уул XIX талбайд 19.4 сая баррель, 1,065.0 сая ам.доллар, Тамсаг XXI талбайд 16.0 сая баррель, 850.0 сая ам.доллар байна.

Гэрээлэгч борлуулсан газрын тосны хэмжээг нийт 0.2 сая баррель буюу 8.9 сая ам.доллараар дутуу, 0.8 сая баррелиар илүү тайлагнасныг аудитаар залруулан, борлуулсан газрын тосны хэмжээг 34.8 сая баррелиар, борлуулалтын орлогыг 1,923.8 сая ам.доллараар баталгаажуулав. [/Хавсралт 2/](#)

⁵ “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”

⁶ “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”

⁷ “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”

⁸ “жилийн төлөвлөгөө, төсвийг төрийн захиргааны байгууллагаар батлуулж, хэрэгжүүлэх”;

⁹ Тосон Уул XIX талбайн талаар БХГ-ний Зүйл 9.Хийн бүтээгдэхүүн хуваалт. Тамсаг XXI талбайн талаар БХГ-ний 9 дүгээр зүйлд Хийн бүтээгдэхүүн хуваалт

¹⁰ Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн хооронд байгуулсан 2011 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн протоколын 2-д Монголын Засгийн Газарт ногдох түүхий тосыг шинж чанараас нь хамааруулан дэлхийн зах зээлийн үнэд нийцсэн боломжит өндөр үнээр хилийн чанад дахь худалдан авагч талд борлуулах эрхийг Петрочайна Дачин Тамсаг ХХК-д олгов.

¹¹ Газрын тосны газар болон Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн харилцан тохиролцсон 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 4 протоколууд. Үүнд: 1. БХГ-т Тосон Уул XIX талбайгаас олборлон “Тосон Уул XIX-Баянхошуу-СУ1 ОИБ” чиглэлээр экспортолж буй түүхий тосны хэмжилт болон МУЗГ-т ногдох түүхий тосны борлуулалтын орлого тооцох 2. БХГ-т Тосон Уул XIX талбайгаас олборлон “Тосон Уул XIX-Бичигт-Рашаант” чиглэлээр экспортолж буй түүхий тосны хэмжилт болон МУЗГ-т ногдох түүхий тосны борлуулалтын орлого тооцох 3. БХГ-т Тамсаг XXI талбайгаас олборлон “Тамсаг XXI-Баянхошуу-СУ1 ОИБ” чиглэлээр экспортолж буй түүхий тосны хэмжилт болон МУЗГ-т ногдох түүхий тосны борлуулалтын орлого тооцох 4. БХГ-т Тамсаг XXI талбайгаас олборлон “Тамсаг XXI-Бичигт-Рашаант” чиглэлээр экспортолж буй түүхий тосны хэмжилт болон МУЗГ-т ногдох түүхий тосны борлуулалтын орлого тооцох.

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж буй Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн 2014-2018 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийсэн аудитын тайлан

Хүснэгт 5. Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайд экспортлосон/борлуулсан газрын тос

/мянган баррель, ам.доллар/

Үзүүлэлт	Гэрээлэгч*		Аудитаар**					
			Нэмсэн		Хассан		Баталгаажуулсан	
	баррель	ам.доллар	баррель	ам.дол	баррель	ам.дол	баррель	ам.доллар
Тосон Уул XIX талбай								
2014 он	5,002.7	393,348.3	13.3	1,040.8	790.2		4,225.8	394,389.2
2015 он	4,413.6	199,185.0	29.3	1,322.5			4,442.9	200,507.5
2016 он	3,742.0	134,201.9	28.1	1,063.0			3,770.1	135,264.9
2017 он	3,323.3	158,754.8	20.2	959.4			3,343.5	159,714.2
2018 он	2,893.7	179,519.7	19.2	1,193.4			2,912.9	180,713.1
Дүн	19,375.3	1,065,009.8	110.0	5,579.1	790.2	0.0	18,695.2	1,070,588.9
Тамсаг XXI талбай								
2014 он	2,267.4	206,045.5		43.9	2.5		2,265.0	206,089.4
2015 он	3,207.5	140,939.7	14.1	527.5			3,221.5	141,467.2
2016 он	3,854.2	140,153.6	25.8	946.3			3,880.0	141,099.9
2017 он	3,795.3	181,660.2	25.0	896.8			3,820.3	182,557.0
2018 он	2,929.8	181,144.0	9.5	905.0			2,939.3	182,049.0
Дүн	16,054.2	849,943.0	74.3	3,319.5	2.5	0.0	16,126.0	853,262.5
Нийт дүн	35,429.5	1,914,952.8	184.4	8,898.6	792.6	0.0	34,821.2	1,923,851.4

Эх сурвалж: * Гэрээлэгчийн тайлагнаж газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлсэн 2014-2018 оны "Oil Sales and Oil shares for 2014-2018" тайлан.

** 2014-2018 оны олборлосон хий, тос, усны тооцоог Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон Гэрээлэгч хооронд тооцоо нийлж баталгаажуулсан Протокол.

Гэрээлэгчийн тайлагнасан борлуулсан газрын тос, борлуулалтын орлогод давтан тооцоолол хийж, газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай тооцоо нийлж баталгаажуулсан жилийн протоколтой тулган шалгахад газрын тосны хэмжээг 0.2 сая баррелиар, орлогыг 8.9 сая ам.доллараар дутуу тайлагнасан байна. Үүнд:

- Талууд газрын тос борлуулах үйл ажиллагаанд гарах технологийн хорогдлыг тооцож, баталгаажуулаагүйгээс 2014-2018 онд борлуулсан газрын тосны хэмжээ¹²-г 0.2 сая баррелиар буюу 8.3 сая ам.доллараар зөрүүтэй тайлагнасан;
- 2014 онд Тосон Уул XIX талбайд газрын тос хэмжилтийн явцад пүүний эвдрэл гарснаас шалтгаалан борлуулалтын орлогыг 0.6 сая ам.доллараар нэмж тооцохоор харилцан протокол¹³-оор тохиролцсоныг хэрэгжүүлээгүй.

Мөн Тамсаг XXI талбайгаас Тосон Уул XIX талбай хооронд 2014 онд зөөвөрлөсөн 0.8 сая баррель газрын тосны хэмжээг давхардуулан тайлагнасныг залрууллаа.

Газрын тос экспортлох үйл ажиллагааны үед гарах технологийн хорогдлын хэмжээг газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон гэрээлэгч хооронд харилцан тохиролцож баталгаажуулаагүй, технологийн хорогдол тооцох үндэслэлгүй байна.

Аудитаар гэрээний талуудад газрын тос экспортлох үйл ажиллагааны үед гарах технологийн хорогдлын хэмжээг бодит тооцоо судалгаанд үндэслэн тогтоож эрх зүйн актаар баталгаажуулах, хэрэгжилтийг хангах арга хэмжээг авч ажиллах албан шаардлага хүргүүлэв.

¹² Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон Гэрээлэгч хооронд 2014-2018 оны олборлосон хий, тос, усны хэмжээг тооцоо нийлж баталгаажуулсан Протоколууд.

¹³ МУЗГ-аас баталсан газрын тосны хайгуул, ашиглалтын БХГ-т Тосон Уул XIX талбайгаас 2014 онд олборлосон хий, тос, усны тооцоог ГТГ, Гэрээлэгч дараах байдлаар нийлж, баталгаажуулсан 2015 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн протоколын 9 дүгээр хавсралт.

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж буй Петроцайна Дачин Тамсаг ХХК-ийн 2014-2018 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийсэн аудитын тайлан

Үнэ тогтоолт

Газрын тосны үнийг борлуулалтын гэрээнүүдээр¹⁴ зохицуулж байгаа бөгөөд хүргэлтийн цэгийн газрын тосны үнэ нь Platt's Crude Oil Marketwire сэтгүүлд өдөр бүр нийтлэгддэг, нэг баррель ам.доллараар илэрхийлэгдсэн Дачин 33 маркийн дундаж спот үнийн сарын дундаж дүнгээс баррель тутамд 1.00 ам.долларыг хассан дүн байна.

Үүний дагуу Газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын зүгээс S&P Global Platts компаниас нийтэлсэн үнийн мэдээллийг албан ёсны эрхтэйгээр авч, борлуулалтын үнэд хяналт хэрэгжүүлсэн байна.

Газрын тосны нэг баррелийн борлуулалтын жилийн дундаж үнэ 2014 онд 93.09, 2015 онд 45.31, 2016 онд 36.40, 2017 онд 48.00, 2018 онд 62.79 ам.доллар байна.

Газрын тос борлуулахтай холбоотой гарсан зардал

МУЗГ-т ногдох түүхий тосны борлуулалтын орлого тооцох асуудлаар тохиролцсон ГТГ, Гэрээлэгчийн хооронд байгуулсан 2011 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн протокол, мөн 2013 онд байгуулсан протоколууд, 2014-2018 оны газрын тосны борлуулалтын гэрээнүүдэд борлуулалттай холбоотой дараах зардлын нэр төрөл, хувь хэмжээг нарийвчлан тусгажээ. Үүнд:

- дээж авалт, шинжилгээний зардал нэг баррель тутамд 0.02 ам.доллар байх;
- буулгалтын зардал нь баррель тутамд 0.224 ам.доллар байх;
- хэрэв газрын тосны усны агууламж 0.5 хувиас бага байвал усыг зайлуулахгүй бөгөөд Борлуулагч зөвхөн халаалтын төлбөрийг төлнө. Хэрэв газрын тосны усны агууламж 0.5 хувиас их буюу тэнцүү байвал зөвхөн ус зайлуулах төлбөрийг төлнө. Ус зайлуулах төлбөр нь баррель тутамд 1.484 ам.доллар, халаалтын зардал нь баррель тутамд 0.66 ам.доллар байх.

Харин тээврийн зардлыг тооцох, тайлагнах, хяналт тавих зохицуулалт хангалтгүй байна.

Гэрээлэгч 2014-2018 онд Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайгаас газрын тос борлуулахад нийт 30.6 сая ам.долларын борлуулалттай холбоотой зардал тооцож тайлагнасныг аудитаар 1.1 сая ам.доллараар бууруулж, 29.5 сая ам.доллараар баталгаажууллаа. /Хавсралт 3/

Хүснэгт 6. Газрын тос борлуулахтай холбоотой гарсан зардал 2014-2018 он

Үзүүлэлт	Тосон Уул XIX			Тамсаг XXI		
	Гэрээлэгч*	Аудит-аар хассан	Аудитаар баталгаажуулсан	Гэрээлэгч*	Аудит-аар хассан	Аудитаар баталгаажуулсан
I.Буулгалтын зардал	4,170.1		4,170.1	3,609.1		3,609.1
II.Хяналтын зардал	372.3		372.3	322.2		322.2
III.Халаалтын зардал	10,765.7		10,765.7	10,253.1		10,253.1
IV.Ус ялгалтын зардал	271.2	271.2	0.0	24.7	12.4	12.2
V.Банкны үйлчилгээний зардал	665.4	665.4	0.0	166.4	166.4	0.0
Дүн	16,244.7	936.6	15,308.2	14,375.5	178.8	14,196.6

Эх сурвалж: *Гэрээлэгчийн тайлагнаж газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлсэн 2014-2018 оны газрын тос борлуулалт ба хуваалтын тайлан /Oil Sales and Oil shares for 2014-2018/.

Аудитаар дараах үндэслэлээр 1.1 сая ам.долларын зардлыг хассан. Үүнд:

- Ус ялгалтын зардалд 2014 онд нийт 0.3 сая ам.долларыг тооцсон нь ГТГ, Гэрээлэгч хооронд экспортолж буй түүхий тосны хэмжилт болон МУЗГ-т ногдох түүхий тосны борлуулалтын орлого тооцохоор тохиролцсон 2013 оны протоколуудын 5¹⁵, 8¹⁶ дахь заалтыг зөрчсөн;

¹⁴ Хятадын үндэсний газрын тосны нэгдсэн корпорац, Петроцайна Дачин Тамсаг ХХК хооронд байгуулсан IN14COD011S, 14CBJR0011E дугаартай 2 гэрээ, Петроцайна олон улсын /Хонг Конг/ корпорац, Петроцайна Дачин Тамсаг ХХК хооронд байгуулсан 14CBJPRB001 дугаартай гэрээ.

¹⁵ Газрын тосны газар болон Петроцайна Дачин Тамсаг ХХК-ийн экспортолж буй түүхий тосны хэмжилт болон МУЗГ-т ногдох түүхий тосны борлуулалтын орлого тооцохоор харилцан тохиролцсон 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн Протоколуудын 5. D-ус ялгах зардал /Зөвхөн ачилтын цэг дээрх усны агууламж 0.5%-иас их болон тэнцүү үед энэ зардал тооцогдоно/

¹⁶ Дээрх протоколуудын 8.ачилтын цэг дээрх усны агууламж 0.5%-иас хэтэрсэн тохиолдолд тухайн ачилтыг экспортод гаргахгүй бөгөөд тухайн байгууламжуудад буцаан буулгана.

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж буй Петрожайна Дачин Тамсаг ХХК-ийн 2014-2018 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийсэн аудитын тайлан

- Банкны үйлчилгээний зардалд нийт 0.8 сая ам.долларыг тооцсон нь мөн дээрх протокол, гэрээнүүдэд тусгаагүй, анхан шатны баримтаар нотлогдоогүй.

Борлуулсан газрын тосыг хүргэлтийн цэг хүртэл тээвэрлүүлэхээр 7-9 компани¹⁷-тай гэрээ байгуулж, хугацааг жил бүр сунгасан байна.

Гэрээлэгч 2014-2018 онд нийт 208.5 сая ам.долларын тээврийн зардал тайлагнасныг аудитаар 0.4 сая ам.доллаароор бууруулж, 208.1 сая ам.доллаароор баталгаажуулав. [/Хавсралт 4/](#)

Хүснэгт 7. Тээврийн зардал 2014-2018 он

Он	Тосон Уул XIX			Тамсаг XXI			Нийт дүн		
	Гэрээлэгч*	Аудитаар хассан	Аудитаар баталгаажуулсан	Гэрээлэгч*	Аудитаар хассан	Аудитаар баталгаажуулсан	Гэрээлэгчийн тайлан	Аудитаар хассан	Аудитаар баталгаажуулсан
2014	31,820.9	-25.2	31,846.0	15,752.2	463.3	15,288.9	47,573.1	438.1	47,134.9
2015	32,248.3	-0.7	32,249.0	15,473.8		15,473.8	47,722.1	-0.7	47,722.8
2016	26,104.5		26,104.5	18,245.1		18,245.1	44,349.6		44,349.6
2017	21,508.1		21,508.1	16,392.3		16,392.3	37,900.4		37,900.4
2018	18,503.7		18,503.7	12,499.5		12,499.5	31,003.1		31,003.1
Дүн	130,185.5	-25.9	130,211.3	78,362.9	463.3	77,899.6	208,548.4	437.4	208,111.0

Эх сурвалж: *Гэрээлэгчийн тайлагнаж газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлсэн 2014-2018 оны газрын тос борлуулалт ба хуваалтын тайлан /Oil Sales and Oil shares for 2014-2018/.

Гэрээлэгч 0.4 сая ам.долларын тээврийн зардлыг анхан шатны баримтгүй бүртгэж тайлагнасныг Газрын тосны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.7¹⁸, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7¹⁹ заасныг үндэслэн аудитаар хасаж баталгаажууллаа.

Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон гэрээлэгч хооронд тээвэрлэгч компаниудыг сонгох, тээврийн зардал тооцох зэрэгт хяналт тавих аргачлалгүй, гүйцэтгэлийг хянаж, гэрээг дүгнээгүй, хоорондын тооцооны үлдэгдлийг тооцоо нийлж хэвшээгүй байна.

1.2. Гэрээлэгч 2014-2018 онд нийт 58.8 сая ам.долларын өртөг нөхөгдөх зардал илүү бүртгэж, тайлагнасан байна

Өртөг нөхөгдөх зардал

Газрын тосны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.31²⁰, 32 дугаар зүйлийн 32.1²¹, 32.2²², БХГ-ний 4 дүгээр зүйлд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахад шаардагдах бүх өртөг, зардлыг гэрээлэгч хариуцаж, бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан өртөгт газрын тосны хувиар нөхөн авахаар, мөн гэрээний "С" хавсралт буюу Тооцооны журамд гэрээлэгч болон хувь нийлүүлэгчийн нөхөн авах өртөг зардлын нэр төрлийг баталсан байна.

Гэрээлэгч 2014-2018 онд газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд 1,234.3 сая, эх компанийн зардал²³-д 123.4 сая нийт 1,357.8 сая ам.долларын ӨНЗ тайлагнаснаас Тосон Уул XIX талбайд 647.3 сая, Тамсаг XXI талбайд 710.5 сая ам.доллар байна.

¹⁷ Petroleum and natural gas transport of China corporation, DQE International, Great wall drilling company, Bohai drilling engineering company limited, Jilin Huayang Transportation Company Limited, New istan LLC, Petrotrans top LLC, Khan Khangamj, Adag Dulaan Petro LLC, Dornii Ikh Gegee LLC, East double bridge co.ltd, Mongolian international oil transportation LLC, Panjin Chenyu Energy co.LTD г.м.

¹⁸ Гэрээлэгчийн тайлагнасан өртөг нөхөгдөх зардал санхүүгийн баримтаар нотлогдоогүй тохиолдолд өртөг нөхөгдөх зардалд тооцогдохгүй.

¹⁹ Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.

²⁰ өртөг нөхөгдөх зардал" гэж хайгуул, бүтээн байгуулалт, үйл ажиллагаа, татан буулгалтын зардлын нийлбэрийг;

²¹ Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахад шаардагдах бүх зардлыг гэрээлэгч хариуцна.

²² Өртөг нөхөгдөх зардлыг төрийн аудитын байгууллагаар баталгаажуулж, бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан өртөгт газрын тосны хувиар нөхнө.

²³ Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайн талаар Бүтээгдэхүүн хуваах гэрээний С хавсралтын 2 дугаар зүйлийн О.Эх компанийн захиргааны нэмэгдэл зардал. 1.Гэрээний дагуу газрын тостой холбогдсон үйл ажиллагааны явцад Монгол улсын хилийн чанадад Гэрээлэгчийн эх компанийн (үүний дотор хувь нийлүүлэгч багтана) ажиллагсдын гүйцэтгэх ажил үйлчилгээ болон конторын ажилд хамаарах захиргааны нэмэгдэл зардал нь газрын тостой холбоотой Гэрээлэгчийн жилийн зардлын 10 хувь байна.

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж буй Петрожайна Дачин Тамсаг ХХК-ийн 2014-2018 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийсэн аудитын тайлан

Аудитаар Тосон Уул XIX талбайн ӨНЗ-ыг нийт 26.2 сая ам.доллараар бууруулж 621.1 сая, Тамсаг ХХI талбайн ӨНЗ-ыг 32.6 сая ам.доллараар бууруулж 677.9 сая, нийт 1,299.0 сая ам.доллараар баталгаажуулав. /Хавсралт 5/

Хүснэгт 8. Тосон Уул XIX талбайн 2014-2018 оны өртөг нөхөгдөх зардал

/мянган ам.доллар/

Он	Гэрээлэгчийн тайлагнасан*			Аудитаар хассан		Зал-руулга хийсэн	Аудитаар баталгаажуулсан		
	ӨНЗ	Эх компанийн зардал	Нийт ӨНЗ	ӨНЗ	Эх компани		ӨНЗ	Эх компанийн зардал	Нийт ӨНЗ
2014	170,533.2	17,053.3	187,586.5	2,014.9	201.5	1.3	168,519.6	16,852.0	185,371.5
2015	150,796.1	15,079.6	165,875.7	4,514.0	15,079.6	9.0	146,291.0		146,291.0
2016	75,229.7	7,523.0	82,752.7	830.0	83.0		74,399.7	7,440.0	81,839.6
2017	84,853.6	8,485.4	93,338.9	1,186.2	118.6		83,667.4	8,366.7	92,034.1
2018	107,023.6	10,702.4	117,726.0	1,961.5	196.1		105,062.1	10,506.2	115,568.3
Дүн	588,436.2	58,843.6	647,279.8	10,506.7	15,678.9	10.2	577,939.8	43,164.9	621,104.6

Эх сурвалж: *Гэрээлэгчийн тайлагнаж газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлсэн 2014-2018 оны өртөг нөхөгдөх зардлын тайлан /Recoverable cost, 2014-2018/.

Хүснэгт 9. Тамсаг ХХI талбайн 2014-2018 оны өртөг нөхөгдөх зардал

/мянган ам.доллар/

Он	Гэрээлэгчийн тайлагнасан*			Аудитаар хассан		Зал-руулга хийсэн	Аудитаар баталгаажуулсан		
	ӨНЗ	Эх компанийн зардал	Нийт ӨНЗ	ӨНЗ	Эх компани		ӨНЗ	Эх компанийн зардал	Нийт ӨНЗ
2014	189,308.8	18,930.9	208,239.7	4,760.2	476.0		184,548.6	18,454.9	203,003.5
2015	184,135.6	18,413.2	202,549.2	5,894.9	18,413.2	-9.0	178,231.7		178,231.7
2016	77,648.9	7,764.9	85,413.8	1,580.2	158.0		76,068.7	7,606.9	83,675.6
2017	88,211.6	8,821.2	97,032.7	750.7	75.1		87,460.8	8,746.1	96,206.9
2018	106,612.8	10,661.3	117,274.0	486.8	48.7		106,125.9	10,612.6	116,738.5
Дүн	645,917.7	64,591.4	710,509.5	13,473.0	19,171.0	-9.0	632,435.8	45,420.4	677,856.2

Эх сурвалж: *-Гэрээлэгчийн тайлагнаж газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлсэн 2014-2018 оны өртөг нөхөгдөх зардлын тайлан /Recoverable cost, 2014-2018/.

Гэрээлэгчийн тайлагнасан ӨНЗ-аас хассан нийт 58.8 сая ам.долларын ажил гүйлгээ нь БХГ, батлагдсан төлөвлөгөө, төсөв болон холбогдох хууль, журмын дараах зүйл заалтуудыг зөрчсөн байна. Үүнд:

- Хилийн чанад дахь эх компанийн удирдлагын зардлыг 2015 оны төлөвлөгөө, төсөвт батлаагүй байхад нийт 33.5 сая ам.долларын гүйцэтгэл тооцсон нь Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.3²⁴ заалттай;
- Мөн дээрх заалтыг зөрчин хөрөнгө оруулалтын болон үйл ажиллагааны зардлын төлөвлөгөө, төсөвт тусгагдаагүй болон батлагдсан төсвийг хэтрүүлсэн нийт 4.0 сая ам.долларын ажил гүйлгээг ӨНЗ-д тайлагнасан;
- Монгол дахь газрын тос олборлолтын үйл ажиллагаанд бус, хилийн чанадад ажиллагсдын цалинд нийт 3.4 сая ам.долларыг зарцуулсан нь БХГ болон борлуулалтын гэрээнд тусгагдаагүй зардал бөгөөд борлуулалттай холбоотой буулгалтын зардалтай давхардаж, БХГ-ний "С" хавсралтаар баталсан Тооцооны журмын 2 дугаар зүйлийн 2.1.а.1²⁵ дэх заалттай;

²⁴ жилийн төлөвлөгөө, төсвийг төрийн захиргааны байгууллагаар батлуулж, хэрэгжүүлэх;

²⁵ Тосон Уул XIX, Тамсаг ХХI талбайн талаар Бүтээгдэхүүн хуваах гэрээний "С" хавсралт дахь Тооцооны журмын 2 дугаар зүйлийн 2.1.Өртөг нөхөгдөх зардал. Газрын тостой холбогдон Гэрээлэгч болон хувь нийлүүлэгч дараах өртөг зардлыг нөхөж авна. Үүнд: а.Ажиллагсад. 1.Энэ гэрээний дагуу төрөл бүрийн үйл ажиллагаанд тогтмол буюу ажлын бүрэн цагаар ажиллахаар томилогдсон буюу

- Тайлант онуудад худалдан авсан үндсэн хөрөнгийн шинж чанартай 10.0 сая ам.долларын хөрөнгийг ашиглаж эхлээгүй, зарцуулаагүй байхад ӨНЗ-аар бүртгэсэн нь БХГ-ний "С" хавсралтын 2 дугаар зүйлийн 2.2²⁶, 2009-2010 оны ӨНЗ-д хийсэн аудитын протокол²⁷-д харилцан тохиролцсонтой;
- Тухайн ажил гүйлгээ гарсныг нотлох анхан шатны баримтын бүрдэл дутуу, баримтгүй нийт 3.5 сая ам.долларын зардлыг ӨНЗ-д бүртгэсэн нь Газрын тосны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.7²⁸, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7²⁹, 20 дугаар зүйлийн 20.1.4³⁰ заалттай;
- Төлөөлөгчийн, сургалтын урамшууллын төлбөр, төрийн болон төрийн бус байгууллагуудад хандив олгосон, бусад төрийн байгууллага, аж ахуйн нэгжид түлш шатахуун олгох зэргээр ӨНЗ-д хамаарахгүй нийт 2.3 сая ам.долларын зардал гаргасан нь Газрын тосны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.6³¹, 34.3³², 34.4³³ дэх заалттай;
- Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ дуусаагүй байхад зардалд бүртгэсэн, төлбөрийг гүйцэтгэлээс илүү олгосон, мөн бусад зардлыг илүү тооцсон зэргээр 0.8 сая ам.долларыг илүү тайлагнасан нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4³⁴, БХГ-ний "С" хавсралтын 2 дугаар зүйлийн 2.2 дахь заалттай тус тус нийцэхгүй байна.

Дээрх ӨНЗ-ыг илүү бүртгэж тайлагнасантай холбоотойгоор эх компанийн зардлыг 1.3 сая ам.доллараар илүү тайлагнасныг өртөг нөхөгдөх зардлаас хаслаа.

Эх компанийн захиргааны нэмэгдэл зардлыг газрын тостой холбогдон гарсан зардлын дүнгээс 10 хувиар тооцон нийт ӨНЗ-ыг нэмэгдүүлэн тооцож байгаа боловч ажил гүйлгээг анхан шатны баримтаар баталгаажуулан бүртгэх, хяналт тавих ажил хийгдээгүй байна.

Цаашид тус зардлыг анхан шатны баримтад үндэслэн ажил, гүйлгээ бүрээр бүртгэж, БХГ-д заасны дагуу³⁵ газрын тостой холбогдсон үйл ажиллагаатай холбогдуулан гэрээлэгчийн эх компаниас гүйцэтгэсэн /удирдлага, санхүү нягтлан бодох бүртгэл, бэлтгэн нийлүүлэх, компьютерын ажил, үйлчилгээ ба захиргааны г.м/ зардалд зарцуулсан эсэхийг хянах шаардлагатай байна.

Гэрээлэгчийн тайлагнасан өртөг нөхөгдөх зардлын тайланг тухай бүр хянаж, хүлээн аваагүйгээс нийт 5.9 сая ам.долларын зардлыг ангилал, нэр төрөл зөрүүтэй бүртгэн тайлагнасныг аудитаар залруулан баталгаажуулсан.

оролцсон ажиллагсдын цалин, хөлс болон дээрх үйл ажиллагаанд түр хугацаагаар буюу ажлын бүрэн бус цагаар ажиллахаар томилогдсон буюу оролцсон ажиллагсдын цалин хөлсний зохих хувь хэмжээ. Дээрхийг үл харгалзан тайлбарлах үүднээс, энэ зүйлийн 2.1.а.1-д заасан ажиллагсдын цалин, хөлсийг дээрх ажиллагсад нь Монгол дахь ийм үйл ажиллагаанд томилогдсон буюу оролцсон, эсвэл Монгол Улсаас ирэх, буцах хүрээнд л энэхүү 2.1.а.1-д заасны дагуу нөхөж авна.

²⁶ Тосон Уул XIX гэрээт талбайн талаар байгуулсан БХГ болон Тамсаг ХХИ гэрээт талбайн талаар байгуулсан БХГ-ний "С" хавсралтын 2.2. Тооцооны үндэс. Гэрээлэгч нь гэрээтэй холбогдох тооцооны дансыг өссөн дүнгээр хөтөлнө. Энд хэрэглэсэн "өссөн дүн" гэдэг нь тухайн зардлыг хэзээ төлснөөс үл шалтгаалан уг зардлыг цаг хугацаанд нь хамааруулан тооцохыг хэлж буй болно.

²⁷ 2001.09.02-ны өдрийн протоколын Аудитын зарчим хэсгийн 4 дэх заалт. Үндсэн хөрөнгийн шинжтэй бараа материалыг түүний ашиглалтын байдалд үндэслэн ӨНЗ-д оруулах ба хараахан ашиглаж эхлээгүй байгаа бараа материалыг дараа жилд нь өртөг нөхөх зардалд оруулна. Бусад бараа материалыг тухайн материалын худалдан авсан үнийн дүнгийн дагуу өртөг нөхөх зардалд оруулах ба тухайн жилд ашиглаагүй бараа материалыг агуулахын үлдэгдэлд оруулан тооцно.

²⁸ Гэрээлэгчийн тайлагнасан өртөг нөхөгдөх зардал санхүүгийн баримтаар нотлогдоогүй тохиолдолд өртөг нөхөгдөх зардалд тооцогдохгүй.

²⁹ Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.

³⁰ хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх;

³¹ Өртөг нөхөгдөх зардалд энэ хуулийн ... 34 дүгээр зүйлд заасан төлбөр хамаарахгүй.

³² Сургалтын урамшуулал, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэгийг төрийн захиргааны байгууллагад шилжүүлнэ.

³³ Орон нутгийг хөгжүүлэх урамшууллыг орон нутгийг хөгжүүлэх санд шилжүүлнэ.

³⁴ Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4.үнэн зөв байх;

³⁵ Тосон Уул XIX, Тамсаг ХХИ талбайн талаар Бүтээгдэхүүн хуваах гэрээний С хавсралтын 2 дугаар зүйлийн О.Эх компанийн захиргааны нэмэгдэл зардал. II. ... Газрын тостой холбогдсон үйл ажиллагаатай холбогдуулан гэрээлэгчийн эх компаниас гүйцэтгэж, улмаар дурдсан хувь хэмжээгээр нөхөн төлөгдөх ажил үйлчилгээний жишээнд удирдлага, санхүү, нягтлан бодох бүртгэл, бэлтгэн нийлүүлэх, компьютерийн ажил үйлчилгээ ба захиргаа орно.

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж буй Петрожайна Дачин Тамсаг ХХК-ийн 2014-2018 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийсэн аудитын тайлан

Өртөг нөхөгдөх зардлын 1993-2018 онд хуримтлагдсан үлдэгдэл

Газрын тосны тухай хуулийн 32.3³⁶, БХГ-ний 8.2³⁷-т гэрээлэгч нь гэрээт түүхий тосны 40 хувийн өртөгт тосыг авч зарцуулах бөгөөд нөхөж аваагүй үлдсэн бүх өртөг зардал нь дараа дараагийн хуанлийн саруудад бүрэн нөхөж дуустал шилжин тооцогдох, хэрэв БХГ дуусгавар болох үед ӨНЗ-аас нөхөгдөөгүй бол үлдсэн хэсгийг гэрээлэгчид олгохгүй байх³⁸ зохицуулалттай.

Газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас 2013 оныг дуусталх хугацааны нийт 1,476.0 сая ам.долларын ӨНЗ буюу ирээдүйд нөхөгдөх боломжтой зардлын дүнг баталгаажуулсан байна. Үүнд:

- Тосон Уул XIX талбайд 1993 оноос 1,481.2 сая ам.долларын ӨНЗ гарснаас 473.8 сая ам.долларын зардлыг өртөгт тосоор нөхөж, 1,007.3 сая;
- Тамсаг XXI талбайд 1995 оноос 502.3 сая ам.долларын ӨНЗ гарснаас 33.6 сая ам.долларын зардлыг өртөгт тосоор нөхөж, 468.6 сая ам.долларын үлдэгдэлтэй байна.

Аудитаар 2014-2018 оны ӨНЗ-ыг 1,299.0 сая, өртөгт тосыг 674.5 сая ам.доллаароор баталгаажуулснаар 2018 оны жилийн эцэст 2,100.4 сая ам.долларын нөхөгдөх боломжтой зардлын үлдэгдэл /1993-2018 он/-тэй байна. /Хавсралт 6/

Хүснэгт 10. Өртөг нөхөгдөх боломжтой зардлын үлдэгдэл 1993 оноос 2018 он дуусталх хугацаа

/мянган ам.доллар/

Он	Баталгаажуулсан ӨНЗ-ын дүн		Өртөгт тосоор нөхөгдсөн дүн*		Ирээдүйд нөхөгдөх боломжтой зардал			Тэмдэглэл
	XIX	XXI	XIX	XXI	XIX	XXI	Дүн	
XIX 1993-2013 XXI 1995-2013	1,481,197.5	502,284.9	473,851.8	33,649.4	1,007,345.7	468,635.6	1,475,981.3	ГТГ-аас баталгаа жуулсан
2014	185,371.5	203,003.5	143,891.0	75,517.7	41,480.6	127,485.7	168,966.3	Аудит аар баталгаа жуулсан
2015	146,291.0	178,231.7	65,875.8	49,296.3	80,415.3	128,935.4	209,350.6	
2016	81,839.6	83,675.6	42,343.2	47,774.9	39,496.4	35,900.7	75,397.0	
2017	92,034.1	96,206.9	54,083.0	65,118.0	37,951.1	31,088.9	69,040.1	
2018	115,568.3	116,738.5	63,834.8	66,759.5	51,733.5	49,979.1	101,712.6	
Дүн	2,102,302.2	1,180,141.1	843,879.5	338,115.9	1,258,422.6	842,025.3	2,100,447.9	

* тайлангийн 10 дугаар хүснэгтээс 2014-2018 оны өртөгт тосны тооцооллыг харна. Нийт борлуулалтын орлогын /борлуулалтын зардал хассан/ 40 хувиар тооцно.

Өмчийг эзэмших ба өмчлөх, эд хөрөнгийн тооллого

Газрын тосны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1³⁹, БХГ-ний 15 дугаар зүйлийн 15.1-д газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахад ашигласан, гэрээт талбай дээр байгаа, гэрээлэгч өртөг, зардлыг нь энэ гэрээний дагуу нөхөж авсан гэрээлэгчийн бүрэн эзэмшлийн бүх тоног төхөөрөмж, барилга байгууламж болон материал нь энэ гэрээ дуусгавар болсны дараа нэмэгдэл төлбөргүйгээр Монгол Улсын төрийн өмч болохоор заасан.

Үүнтэй холбоотойгоор БХГ-ээр газрын тосны үйл ажиллагааны зориулалттай материал, эд хөрөнгийн болон барилгын ажлын төслүүдэд Засгийн Газрын төлөөлөгч, гэрээлэгч эд хөрөнгийн

³⁶ Өртөгт газрын тосны хэмжээ нь тухайн жилд олборлосон нийт газрын тосноос нөөц ашигласны төлбөрт ногдох газрын тосыг хасаад үлдэх тосны 40 хүртэл хувь байх ба уламжлалт бус газрын тосны хувьд энэ хуульд заасан холбогдох журмын дагуу зохицуулна.

³⁷ Гэрээлэгч нь газрын тостой холбогдсон үйл ажиллагааны явцад гарсан өртөг зардлыг нөхөж авах зорилгоор энэхүү 8.2-ын дагуу хуанлийн сар тутам гэрээт түүхий тос /өртөгт тос/ болон гэрээт хийн дөчин /40/ хувийг авч зарцуулах эрхтэй. Түүнчлэн гэрээлэгчийн нөхөж аваагүй үлдсэн бүх өртөг зардал нь дараа дараагийн хуанлийн саруудад бүрэн нөхөж дуустал шилжин тооцогдож байна.

³⁸ Газрын тосны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.4-д "Бүтээгдэхүүн хуваах гэрээ дуусгавар болох үед өртөг нөхөгдөх зардлаас нөхөгдөөгүй үлдсэн хэсгийг гэрээлэгчид олгохгүй"

Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайн талаар Бүтээгдэхүүн хуваах гэрээний 15.1. Энэ гэрээнд өөрөөр заагаагүй бол газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахад ашигласан, гэрээт талбай дээр байгаа, гэрээлэгчийн өртөг зардлыг нь энэ гэрээний дагуу нөхөж авсан гэрээлэгчийн бүрэн эзэмшлийн бүх тоног төхөөрөмж, барилга байгууламж болон материал нь энэ гэрээ дуусгавар болсны дараа нэмэгдэл төлбөргүйгээр Монгол улсын төрийн өмч болно.

³⁹ Газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулах зорилгоор Монгол Улсын нутаг дэвсгэрт оруулж ирсэн гэрээлэгчийн техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, бараа материал, үл хөдлөх хөрөнгийг гэрээний хугацаа дуусгавар болохоос өмнө, эсхүл дуусгавар болсны дараа өмчлөх асуудлыг гэрээнд заасны дагуу шийдвэрлэнэ. 39.2.Энэ хуулийн 39.1-д заасан хөрөнгийг Засгийн газар шилжүүлэн авахаас татгалзсан тохиолдолд гэрээлэгч нь татан буулгалтыг өөрийн зардлаар гүйцэтгэнэ.

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж буй Петрожайна Дачин Тамсаг ХХК-ийн 2014-2018 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийсэн аудитын тайлан

тооллого хийж бүртгэл хөтлөх, Засгийн Газрын төлөөлөгч байлцаж чадахгүй бол гэрээлэгчийн тооллогын дүнгийн хувийг хүлээн авах⁴⁰-аар зохицуулсан.

Гэрээлэгч 2018 оны жилийн эцэст нийт 12,173.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 15,839.9 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэл бүртгэж тайлагнасан байна. Нийт үндсэн хөрөнгийн 36.0 хувийг барилга байгууламж, 30.8 хувийг машин тоног төхөөрөмж, 27.4 хувийг тээврийн хэрэгсэл, 5.8 хувийг бусад хөрөнгийн дүн эзэлж байна.

Гэрээлэгч 2014-2018 оны жилийн эцсийн хөрөнгө, материалын үлдэгдлийн бүртгэлийг газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлсэн ч, тухай бүр хянаж хүлээн аваагүйгээс дараах зөрчлүүд илэрсэн. Тухайлбал:

- Хөрөнгийн жилийн эцсийн тооллого хийх ажлын хэсэг байгуулаагүй, тооцоо бодсон акт үйлдээгүй, тооллогын бүртгэлийг зөвхөн санхүүгийн ажилтан гарын үсэг зурж баталгаажуулсан нь НББ-ийн тухай хуулийн 12 дугаар зүйл⁴¹, өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар⁴²-тай нийцээгүй;
- Үндсэн хөрөнгийн шинж чанартай 1.3 сая, бараа материалын шинж чанартай 3.4 сая ам.долларын худалдан авалтыг бүртгэлд тусгаагүй, эд хариуцагчаар дамжуулж зарцуулаагүй, зарим материалыг анхан шатны баримтаас зөрүүтэй дүнгээр бүртгэсэн;
- Улаанбаатар хотод байрлах төлөөлөгчийн газарт /оффист/ худалдан авсан хөрөнгө, бараа материалыг орлого авч, зарцуулалтын тайлан гаргадаггүй, шууд зардлаар бүртгэж байгаа зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2⁴³, 5.1.4⁴⁴, 6 дугаар зүйлийн 6.1⁴⁵ дэх заалттай нийцээгүй байна.

Газрын тосны салбарт БХГ-ээр үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсөв, түүний дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалт, мөн газрын тосны үйл ажиллагаа явуулахаар бэлтгэсэн материал, эд хөрөнгийн бүртгэл, тооцоог программчилж, нэгдсэн цахим систем бий болгон, газрын тосны болон төсөв санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас хяналтыг бүрэн хийж хэрэгжүүлэхгүй байна.

1.3. Нийт борлуулалтын орлогоос 237.6 сая ам.доллар /12.3%-ын газрын тос борлуулахтай холбоотой зардлыг хасаж, үлдэх хэсгийн 24.3 хувь буюу 466.7 сая ам.доллар МУЗГ-т, 63.4 хувь буюу 1,219.5 сая ам.доллар гэрээлэгчид тус тус ногдож, байна

Газрын тосны тухай хуулийн 31.1⁴⁶, 32.3⁴⁷, 33.1⁴⁸, 33.2⁴⁹ дугаар зүйл, БХГ-ний 8 дугаар зүйлд талуудын газрын тосны төлбөр ба бүтээгдэхүүн хуваалтын талаар зохицуулсан.

Тосон Уул XIX гэрээт талбайн талаар байгуулсан БХГ болон Тамсаг XXI гэрээт талбайн талаар байгуулсан БХГ-ний 8 дугаар зүйлд дараах зохицуулалтыг тусгасан. Үүнд:

БХГ-ний зүйл заалт	БХГ-ний заалтын утга
Тосон Уул XIX 8.1 дэх зүйл. Төлбөр /Роялти/	Бүтээгдэхүүний аливаа төлбөр нь ашигт тосны монголын ногдол хэсэгт багтах бөгөөд түүнийг МГТ компани Монголын Засгийн Газарт төлнө.

⁴⁰ Тосон Уул XIX гэрээт талбайн талаар байгуулсан БХГ болон Тамсаг XXI гэрээт талбайн талаар байгуулсан БХГ-ний "С" хавсралтын Гуравдугаар зүйл. Эд хөрөнгийн тооллого.

⁴¹ 12 дугаар зүйл.Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого

⁴² Санхүү, эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын хамтарсан 2002 оны 171/111,Санхүү, эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын хамтарсан 2004 оны 213/157 тоот тушаал /Сангийн сайдын 2017 оны 347 дүгээр тушаалаар хүчингүй болсон/

⁴³ тасралтгүй байх;

⁴⁴ үнэн зөв байх;

⁴⁵ Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө.

⁴⁶ Газрын тос, байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийн хэмжээ нь олборлосон түүхий тос, байгалийн хийн 5-15 хувь байна.

⁴⁷ Өртөгт газрын тосны хэмжээ нь тухайн жилд олборлосон нийт газрын тосноос нөөц ашигласны төлбөрт ногдох газрын тосыг хасаад үлдэх тосны 40 хүртэл хувь байх ба уламжлалт бус газрын тосны хувьд энэ хуульд заасан холбогдох журмын дагуу зохицуулна.

⁴⁸ Ашигт газрын тосыг Засгийн газар, гэрээлэгчтэй бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хуваана.

⁴⁹ Ашигт газрын тосны Засгийн газарт ногдох хэмжээг хоногт олборлох газрын тосны хэмжээтэй уялдуулан бүтээгдэхүүн хуваах гэрээнд тодорхойлон заана.

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж буй Петрожайна Дачин Тамсаг ХХК-ийн 2014-2018 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийсэн аудитын тайлан

Тамсаг XXI 8.1 дэх зүйл. Төлбөр /Роялти/	Газрын тосны үйлдвэрлэлийн долоо аравны таван /7.5/ хувийн төлбөрийг гэрээлэгч Монголын Засгийн газарт төлнө.
Тосон Уул XIX, Тамсаг XXI 8.2 дахь зүйл. Өртөгт тос	а.Гэрээлэгч нь газрын тостой холбогдсон үйл ажиллагааны явцад гарсан өртөг зардлыг нөхөж авах зорилгоор энэхүү 8.2-ын дагуу хуанлийн сар тутам гэрээт түүхий тос /өртөгт тос/ болон гэрээт хийн дөчин /40/ хувийг авч зарцуулах эрхтэй
Тосон Уул XIX, Тамсаг XXI 8.3 дахь зүйл. Ашигт тос /Хуваах тос/	а.Хуанлийн сард ногдох өртөгт тосны нийт хэмжээг хасаад үлдсэн бүх гэрээт түүхий тос /хуваах тос/-ыг МГТ компани болон гэрээлэгчийн хооронд тухайн хуанлийн сард гаргасан хуваах тосны өдрийн дундаж хэмжээнд тулгуурлан дор заасан харьцаагаар хуваана. Үүнд: а/1.Хуанлийн сарын хуваах тосны өдрийн дундаж хэмжээ нь 50000 баррелиас бага байвал: Монголын ЗГ-т 40 хувь, гэрээлэгчид 60 хувь нь ногдоно.

Гэрээлэгч 2014-2018 онд МУЗГ-т ногдох ашигт тос, роялтийг нийт 436.3 сая ам.доллараар тайлагнасныг аудитаар 30.4 сая ам.доллараар нэмэгдүүлэн 466.7 сая, гэрээлэгчид ногдох ашигт тос, өртөгт тосыг 1,239.5 сая ам.доллараар тооцож тайлагнасныг 20.0 сая ам.доллараар бууруулан 1,219.5 сая ам.доллараар тус тус баталгаажууллаа. /Хавсралт 7/

**Хүснэгт 11. Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайн
газрын тосны хуваалтын тооцоо
2014-2018 он**

/мянган ам.доллар/					
Д/д	Үзүүлэлт	Мөр дугаар	Гэрээлэгч	Аудитаар баталгаажуулсан	Зөрүү
1	Борлуулсан газрын тосны хэмжээ /мянган баррель/	А	35,429.5	34,821.2	(608.3)
2	Нэгж үнэ ам.дол /5 жилийн дундаж/	Б	57.12	57.12	0.00
3	Борлуулсан газрын тосны дүн	В	1,914,952.8	1,923,851.4	8,898.6
4	Борлуулалттай холбоотой зардал	Г	239,168.6	237,615.8	(1,552.8)
5	Борлуулалтын орлого	Д /В-Г/	1,675,784.2	1,686,235.6	10,451.5
6	Роялти	Е /Д*7.5%/	56,790.3	103,340.9	46,550.6
7	Өртөгт тос	Ё /Д*40%/	670,313.7	674,494.3	4,180.6
8	Ашигт газрын тос	Ж /Д-Е-Ё/	948,680.2	908,400.5	(40,279.7)
9	МУЗГ-т ногдох газрын тос	З /Ж*40%/	379,472.1	363,360.2	(16,111.9)
	Гэрээлэгчид ногдох газрын тос	И /Ж*60%/	569,208.1	545,040.2	(24,167.8)
	МУЗГ-т ногдох нийт дүн	Й /К+Л/	436,262.4	466,701.1	30,438.7
10	Роялти	К /Е/	56,790.3	103,340.9	46,550.6
	Бүтээгдэхүүн хуваалт	Л /З/	379,472.1	363,360.2	(16,111.9)
	Гэрээлэгчид ногдох нийт дүн	М /Н+О/	1,239,521.8	1,219,534.5	(19,987.2)
11	Өртөгт тос	Н /Ё/	670,313.7	674,494.3	4,180.6
	Бүтээгдэхүүн хуваах	О /И/	569,208.1	545,040.2	(24,167.8)

Газрын тосны борлуулалтын орлогын 12.3 хувь нь борлуулалттай холбоотой зардалд тооцогдож, 24.3 хувь МУЗГ-т, 63.4 хувь гэрээлэгчид тус тус ногдож байна.

**Хүснэгт 12. Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайн
газрын тосны хуваалтын тооцоо /хувиар/
2014-2018 он**

/мянган ам.доллар/						
Үзүүлэлт	Гэрээлэгчийн тайлагнасан		Аудитаар баталгаажуулсан		Аудитаар орсон өөрчлөлт	
	дүн	хувь	дүн	хувь	дүн	хувь
Газрын тосны борлуулалтын орлого	1,914,952.8	100	1,923,851.4	100	8,898.6	0.5
Газрын тос борлуулахтай холбогдон гарсан зардал	239,168.6	12.5	237,615.8	12.3	(1,552.8)	(0.6)
МУЗГ-т хуваасан ашигт тос, роялти	436,262.4	22.8	466,701.1	24.3	30,438.7	7.0
Гэрээлэгчид хуваасан ашигт тос, өртөгт тос	1,239,521.8	64.7	1,219,534.5	63.4	(19,987.2)	(1.6)

Тосон Уул XIX талбайд байгалийн дахин сэргээгдэхгүй нөөц баялгийг ашигласны төлбөр /роялти/ тооцож аваагүй нь БХГ байгуулах үед мөрдөж байсан БНМАУ-ын Газрын тосны тухай

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж буй Петрожайна Дачин Тамсаг ХХК-ийн 2014-2018 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийсэн аудитын тайлан

хуулийн 9.1⁵⁰, 10.1⁵¹ дүгээр зүйл, БХГ-ний 2.2⁵² дахь заалтыг зөрчсөн тул аудитаар 2014-2018 онд нийт 46.2 сая ам.долларын роялтийг нөхөн тооцож баталгаажуулсан.

Түүнчлэн аудитаар борлуулалтын орлогыг нэмэгдүүлж, борлуулалттай холбоотой гарсан зардлыг бууруулсан зэргээс шалтгаалан роялтийг 0.6 сая, өртөгт тосыг 4.2 сая ам.доллараар нэмэгдүүлж, МУЗГ-т хуваасан ашигт тосыг 16.1 сая, гэрээлэгчид ногдох ашигт тосыг 24.2 сая ам.доллараар бууруулан баталгаажууллаа.

Аудитаар 2014-2018 онд Тосон Уул XIX талбайд роялти нөхөн тооцоолсон, орлого нэмэгдүүлж, газрын тос борлуулахтай холбоотой зардал бууруулсан зэргээс шалтгаалан гэрээлэгчээс Монгол Улсын Засгийн газарт 30.4 сая ам.долларыг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Газрын тосны орлого төвлөрүүлэлт

Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайгаас олборлож буй түүхий тосыг борлуулах асуудлаар ГТГ, Гэрээлэгч хооронд тохиролцсон 2011 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн протоколын 4 дүгээр заалт⁵³-д талууд түүхий тосны борлуулалтын орлогыг сар бүр тооцоо нийлэн, МУЗГ-т ногдох орлогыг дараа сарын 25-ны өдрийн дотор шилжүүлж байхаар зохицуулсан.

Гэрээлэгч 2013 оны жилийн эцсийн байдлаар газрын тосны орлогоос 13.8 сая ам.доллар дутуу, 2014-2018 онд 436.3 сая ам.долларын борлуулалтын орлого төвлөрүүлэхээр тайлагнаснаас 6.5 сая ам.долларыг дутуу төвлөрүүлсэн байна.

Аудитаар Тосон-Уул XIX талбайд роялти нөхөн тооцсон, борлуулалтын орлого нэмэгдүүлж, борлуулалттай холбогдон гарсан зардлыг бууруулсан зэргээс шалтгаалан нийт 466.7 сая ам.долларыг улсын төсөвт төвлөрүүлэхээр баталгаажууллаа.

Хүснэгт 13. МУЗГ-т ногдсон орлого төвлөрүүлэлтийн тооцоо Тосон Уул XIX, Тамсаг XXI талбай

/мянган ам.доллар/

2014-2018 он	Жилийн эхний үлдэгдэл тооцоо	Төлбөл зохих*	Улсын төсвийн дансанд төвлөрүүлсэн	Жилийн эцсийн үлдэгдэл тооцоо
2013.12.31	-	-	-	13,775.9
2014.12.31	13,775.9	150,932.8	144,611.4	20,097.3
2015.12.31	19,935.2	79,589.8	76,415.3	23,271.8
2016.12.31	23,109.8	62,621.3	57,626.6	28,266.5
2017.12.31	28,106.7	82,902.6	77,977.7	33,191.4
2018.12.31	33,032.2	90,654.6	86,874.1	36,971.8
Нийт дүн	13,775.9	466,701.1	443,505.2	36,971.8

*Аудитаар баталгаажуулсан МУЗГ-т ногдох ашигт тос, роялти.

Гэрээлэгч МУЗГ-т ногдох орлогыг 2014 онд Төрийн банкин дахь улсын төсвийн орлогын 240025626105 тоот дансанд, 2015 оноос Улаанбаатар хотын банкин дахь улсын төсвийн орлогын 2601027100 тоот дансанд, 2018 оны 5 дугаар сараас эхлэн Төрийн сан дахь 100900000752 тоот дансанд тус тус төвлөрүүлсэн байна. /Хавсралт 8/

ҮАГ-ын Нийцлийн аудитын газар /хуучин нэрээр/-аас "Газрын тосны тухай хуулийн хэрэгжилт, хуулийн төлбөр тооцооны байдал"-д хийсэн аудитаар 2015 оны 3 дугаар сарын 10-ны өдөр "БХГ-ний дагуу Монгол Улсад төлөх газрын тосны орлогоос 2013-2014 онд Нэмэгдсэн өртгийн

⁵⁰ Гэрээлэгч нь газрын тос олборлосны төлбөрийг улсад төлнө. Төлбөрийн хэмжээг Монгол Улсын Засгийн газар тогтооно...

⁵¹ Гэрээлэгч нь газрын тос олборлосны төлбөр болон зардлаа нөхөх хэсгийг нийт олборлолтоос хасаад үлдсэн бүтээгдэхүүнийг газрын тосны хэрэг эрхлэх байгууллагатай хуваана. ...

⁵² Тосон Уул XIX гэрээт талбайн талаар байгуулсан БХГ-ний 2 дугаар зүйл. Тодорхойлолтууд. "Төлбөр /роялти/" гэж Монгол улсын Газрын хэвлийн хууль болон Газрын тосны тухай хуулийн дагуу байгалийн дахин сэргээгдэхгүй нөөц баялгийг ашигласны төлбөрийг хэлнэ. Энэ төлбөрийг олборлосон нийт бүтээгдэхүүнд ногдуулж, өртөгт тосыг хуваарилахаас өмнө төлнө.

⁵³ Газрын тосны газар, Петрожайна Дачин Тамсаг ХХК-ийн хооронд байгуулсан 2011.06.24-ний өдрийн протоколын 4.Талууд түүхий тос борлуулалтын орлогыг сар бүр тооцоо нийлэн, Петрожайна Дачин Тамсаг ХХК Засгийн газарт ногдох орлогыг дараа сарын 25-ны өдрийн дотор Газрын тосны газрын дансанд шилжүүлнэ.

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж буй Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн 2014-2018 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийсэн аудитын тайлан

албан татвар, Гаалийн татварт төлсөн төлбөрөө суутгаж, дутуу шилжүүлсэн нь БНМАУ-ын Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журмын 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалтыг зөрчсөн"-ийг тогтоож 1.0 сая ам.долларын төлбөрийн акт тавьсны дагуу ҮАГ-ын Төрийн сангийн 900000601 тоот дансанд 2015 онд шилжүүлсэн байна.

Гэрээлэгч газрын тосны орлогыг Улаанбаатар хотын банкин дахь 2601027100 тоот дансанд шилжүүлэхдээ 2016 оны 3 дугаар сараас эхлэн нийт 1,357.00 ам.долларын банкны үйлчилгээний шимтгэлийг төлөөгүй, улсын төсвийн орлогыг дутуу төвлөрүүлсэн байна.

Газрын тосны орлого төвлөрүүлэлтэд сар бүр хяналт хэрэгжүүлээгүй, орлогыг тохиролцсон хугацаанд төвлөрүүлээгүйгээс 2013 оны жилийн эцсийн 13.8 сая ам.долларын үлдэгдлийг 7-18 сарын дараа төвлөрүүлсэн, 2018 оны жилийн эцсээр 6.5 сая ам.долларын төвлөрүүлээгүй үлдэгдэл /гэрээлэгчийн тайлангаар/-тэй, үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайгаас олборлож буй түүхий тосыг борлуулах асуудлаар ГТГ, Гэрээлэгч хооронд тохиролцсон 2011 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн протоколын 4-т "талууд түүхий тосны борлуулалтын орлогыг сар бүр тооцоо нийлэн, МУЗГ-т ногдох орлогыг дараа сарын 25-ны өдрийн дотор шилжүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

БҮЛЭГ.2 ГАЗРЫН ТОСНЫ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

2.1. АМГТГ нь гэрээлэгчийн хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтын тайлан мэдээг хүлээн авсан ч хянаж, нэгтгэх чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна

Тосон Уул, Тамсагийн БХГ-ний нийт хугацаанд хэрэгжүүлэх "Газрын тосны орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө"-г Засгийн газрын 1991 оны 204 дүгээр тогтоолоор баталсан "БНМАУ-ын Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журам"-ын 15 дугаар зүйлийн 15.1, 15.3-д заасны дагуу ГТГ-ын Хайгуул, ашиглалтын техникийн зөвлөлөөр хэлэлцүүлж, тус газрын даргын 2012 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 125 дугаар тушаалаар баталсан байна.

Тус төлөвлөгөөг газрын тосны орд ашиглах төслийн агуулга, зорилго, газрын тосны зах зээлийн төлөв байдал ба бүтээгдэхүүний зах зээлийн шинжилгээ, газрын тосны ордын тодорхойлолт, өрөмдлөгийн аргачлал, газрын тосны олборлолтын технологи, гадаргуун ил байгууламж, Тамсагийн сав газрын гидрогеологийн судалгаа, хүрээлэн буй орчны хамгаалал, эдийн засгийн үр ашгийн тооцоо зэрэг үзүүлэлтүүдээр талбай тус бүрээр боловсруулж батлуулсан байна.

Тосон Уул XIX талбайн газрын тосны ордын ашиглалтын хугацаанд буюу 2039 он хүртэл 20.2 сая тонн, Тамсаг XXI талбайгаас 2041 он хүртэл нийт 21.0 сая тонн түүхий тос олборлож, дараах хөрөнгө оруулалт, дэд бүтцийн ажлыг гүйцэтгэхээр төлөвлөжээ.

Хүснэгт 14. Тосон Уул, Тамсагийн газрын тосны ордыг ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан бүтээн байгуулалтын ажлууд

№	Тосон Уул XIX талбай 2039 он хүртэл		Тамсаг XXI талбай 2041 он хүртэл	
	Хэмжих нэгж	Гүйцэтгэхээр төлөвлөсөн ажлууд	Хэмжих нэгж	Гүйцэтгэхээр төлөвлөсөн ажлууд
1	1638 цооног	1171 газрын тосны олборлолтын цооног 467 ус шахалтын цооног	1136 цооног	842 газрын тосны олборлолтын цооног 294 ус шахалтын цооног өрөмдөх
2	57 цооног	Усны эх үүсвэрийн цооног	38 цооног	Усны эх үүсвэрийн цооног
3	ТА-1-15 ТА-1-23	Цуглуулах, дамжуулах станц	100 кВольт 100 км	Тосон Уул XIX Тамсаг XXI талбайн хооронд цахилгаан дамжуулах агаарын шугам
4	210.7 км	Баянхошуу хилийн боомтын чиглэлд хатуу хучилттай авто зам	60 км	ТА-2 олборлолтын ил байгууламжаас Тосон Уул XIX, Баянхошуу боомтын чиглэлийн автозамд нийлэх хатуу хучилттай авто зам
5	1 ш	Гүний усыг цэвэршүүлэх	4 ш	4000 кВаттын дизель генератор
6	17 ш	500 кВаттын хийн цахилгаан үүсгүүр	4 ш	500 кВаттын хийн цахилгаан үүсгүүр, хог хаягдлыг боловсруулах байгууламж

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж буй Петрожайна Дачин Тамсаг ХХК-ийн 2014-2018 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийсэн аудитын тайлан

7	-	Ажилчдын амьдрах, ажиллах үйлдвэрийн суурин	-	Ажилчдын амьдрах, ажиллах үйлдвэрийн суурин, ус зайлуулах, гал түймэртэй тэмцэх байгууламж
8	20.2 сая тонн	2039 он хүртэл газрын тос олборлох	21.0 сая тонн	2041 он хүртэл газрын тос олборлох
9	3.7 тэрбум ам.доллар	БХГ-ний хугацааны нийт хөрөнгө оруулалт	2.9 тэрбум ам.доллар	БХГ-ний хугацааны нийт хөрөнгө оруулалт
10	2026 онд хөрөнгө оруулалтын зардлаа нөхнө	1 баррель газрын тосыг 100 ам.доллараар тооцож, өгөөжийн дотоод түвшин 11.7 хувь байвал, гэрээлэгч өртөгт тос болон ашигт тосны өөрт ногдох хэсгээр нөхнө.	2028 онд хөрөнгө оруулалтын зардлаа нөхнө	1 баррель газрын тосыг 100 ам.доллараар тооцож, өгөөжийн дотоод түвшин 13.2 хувь байвал, гэрээлэгч өртөгт тос болон ашигт тосны өөрт ногдох хэсгээр нөхнө.
11	2039 он хүртэл	Гэрээлэгчид ногдох орлого 10.1 тэрбум ам.доллар буюу цэвэр ашиг 3.9 тэрбум ам.доллар, МУЗГ-т ногдох орлого 3.3 тэрбум ам.доллар, хөрөнгө оруулалтын өнөөгийн цэвэр үнэ 103.5 сая ам.доллар	2041 он хүртэл	Гэрээлэгчид ногдох орлого 10.1 тэрбум ам.доллар буюу цэвэр ашиг 4.6 тэрбум ам.доллар, МУЗГ-т ногдох орлого 4.1 тэрбум ам.доллар, хөрөнгө оруулалтын өнөөгийн цэвэр үнэ 201.2 сая ам.доллар

Эх сурвалж: Петрожайна Дачин Тамсаг ХХК-ийн "Газрын тосны орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө"

Тус төлөвлөгөөнд 1 баррель тос олборлох зардлыг Тосон Уулын ордын хувьд 16.5 ам.доллар, Тамсагийн ордын хувьд 16.3 ам.доллараар, түүхий тосны үнийг 100 ам.доллар/баррель байхаар тооцсон. Гэвч 2015 оноос эхлэн түүхий тосны зах зээлийн үнийн уналт, орон нутгийн эсэргүүцэл, халдварт өвчин зэргээс шалтгаалан түүхий тосны экспорт буурсан, гаднаас туслан гүйцэтгэгч ажиллах хүч орж ирээгүйгээс технологийн ажлуудыг төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэж чадахгүй байдалд хүрсэн, цахилгаан эрчим хүчний хязгаарлагдмал байдлаас хамааран ордыг эдийн засгийн үр ашигтай ашиглах боломж буурч, газрын тосны олборлолт багасаж эхэлсэн байна.

Иймээс Гэрээлэгч Тосон Уул болон Тамсагийн "Ордыг ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө"-г Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан "Газрын тосны орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тавих шаардлага" журмын дагуу шинэчлэн боловсруулж, хүлээлгэн өгөхөөр 2016 оноос хойш жил бүр протоколоор тохиролцож байгаа боловч хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Газрын тосны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3⁵⁴-т заасны дагуу Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь газрын тосны ордыг ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөнд үндэслэн гэрээлэгчийн тухайн жилийн ажлын нарийвчилсан төлөвлөгөө, төсвийг батлах, гүйцэтгэлд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Тосон Уул XIX, Тамсаг ХХI талбайн 2014-2018 оны төсвийг анх 2,167.3 сая ам.доллараар баталж, 255.8 сая ам.долларын нэмэлт өөрчлөлт оруулан, нийт 2,423.1 сая ам.доллараар баталсан байна.

Хүснэгт 15. Тосон Уул XIX, Тамсаг ХХI талбайн 2014-2018 оны ажлын жилийн төлөвлөгөө, төсөв

/мянган ам.доллар/

Он	Тосон Уул XIX төсөв			Тамсаг ХХI төсөв		
	Анх баталсан	Нэмэлт	Жилийн дүн	Анх баталсан	Нэмэлт	Жилийн дүн
2014	218,642.6	69,268.0	287,910.6	327,618.6	19,752.7	347,371.3
2015	194,082.3	33,848.6	227,931.0	316,465.5	24,561.4	341,026.9
2016	173,768.7	21,027.3	194,796.0	250,890.8	35,642.4	286,533.2
2017	210,116.8	10,550.1	220,666.9	231,017.7	1,730.1	232,747.8
2018	116,484.9	7,728.6	124,213.5	128,198.0	31,656.7	159,854.7
Дүн	913,095.4	142,422.6	1,055,518.0	1,254,190.5	113,343.3	1,367,533.8

Эх сурвалж: Газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас хянаж баталсан Гэрээлэгчийн Тосон Уул XIX, Тамсаг ХХI талбайн 2014-2018 оны ажлын жилийн төлөвлөгөө, төсөв.

⁵⁴ Газрын тос ... ашиглалтын ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг батлах, түүний гүйцэтгэлд хяналт тавих.

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж буй Петроочайна Дачин Тамсаг ХХК-ийн 2014-2018 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийсэн аудитын тайлан

Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайн 2014-2018 оны төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэлийг 53.6 хувиар баталгаажуулсан бөгөөд Тосон Уул XIX талбайн гүйцэтгэл 621.1 сая ам.доллар буюу 58.8 хувь, Тамсаг XXI талбайн гүйцэтгэл 677.8 сая ам.доллар буюу 49.6 хувь байна.

Хүснэгт 16. Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайн 2014-2018 оны ажлын жилийн төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэл

/мянган ам.доллар/

Д/д	Ажлын жилийн төлөвлөгөө, төсвийн чиглэл	Тосон Уул XIX				Тамсаг XXI			
		Жилийн төсөв	Гэрээлэгчийн тайлагнасан гүйцэтгэл	Аудитаар баталгаажуулсан гүйцэтгэл	Хувь	Жилийн төсөв	Гэрээлэгчийн тайлагнасан гүйцэтгэл	Аудитаар баталгаажуулсан гүйцэтгэл	Хувь
1	Ашиглалтын талбайн түрээс	304.8	310.9	310.9	102	242.3	316.4	316.4	130.6
2	Орд ашиглалт	565,643.7	350,334.0	337,914.6	59.7	614,117.9	338,514.6	326,784.2	53.2
3	Дэд бүтэц	212,390.9	86,544.7	86,908.3	40.9	478,992.7	183,281.6	180,157.0	37.6
4	Машин, туслах тоног төхөөрөмж	4,163.5	2,506.1	1,230.9	29.6	7,080.2	5,349.2	2,732.4	38.6
5	Байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээх	6,137.0	3,539.0	3,163.2	51.5	5,491.0	4,116.7	3,680.0	67.0
6	Ашиглалтын дагалдах ажлууд	4,997.0	4,518.5	3,958.5	79.2	2,176.4	2,149.3	2,149.3	98.8
7	Бусад /СУ, ОНХС, ТДС/*	-	875.0	0.0			875.0	0.0	
8	Үйл ажиллагааны зардал	186,645.8	150,295.9	144,453.4	77.4	166,114.3	120,220.9	116,614.6	70.2
9	Эх компанийн зардал /10%/	75,235.2	59,804.9	43,164.9	57.4	93,318.9	65,394.9	45,420.4	48.7
Нийт дүн		1,055,518.0	658,729.1	621,104.6	58.8	1,367,533.8	720,218.5	677,856.2	49.6

Эх сурвалж: Газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас хянаж баталсан Гэрээлэгчийн Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайн 2014-2018 оны ажлын жилийн төлөвлөгөө, төсөв, Гэрээлэгчийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө төсвийн гүйцэтгэлийн тайлангууд

*СУ-Сургалтын урамшуулал, ОНХС-Орон нутгийн хөгжлийн сан, ТДС-Төлөвлөгчийг дэмжих сан.

Төлөвлөгөө, төсвийн санал, төсвийн төслийн тооцоолол зэрэг баримт материалыг гэрээлэгч болон төрийн захиргааны байгууллага нь архивын нэгж болгон хадгалаагүй тул зардлыг нэмэгдүүлсэн болон бууруулсан үндэслэл тодорхойгүй байна.

Газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас ӨНЗ-ын тайлан /recoverable costs/, төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэлийн тайлан /implementation of work program and expenditures in contract/-г тухай бүр хянаж хүлээн аваагүйгээс өртөг нөхөгдөхгүй зардлыг ӨНЗ-д тооцсон, гүйцэтгэлийг 80.0 сая ам.доллараар илүү тайлагнасан байна.

Мөн гэрээлэгчийн жилийн ажлын гүйцэтгэлийг өдөр тутмын мэдээ, ажил эхэлсэн дууссан мэдэгдлийн хүрээнд хянаж, гэрээлэгчийн жилийн ажлыг дүгнэх, харьцуулах, дүн шинжилгээ хийх, төлөвлөгөө төсөв, гүйцэтгэлийг хянаж, нэгтгэх үндсэн чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Орд ашиглалт, дэд бүтэц, машин, туслах тоног төхөөрөмж, байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээх чиглэлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр, арга хэмжээний гүйцэтгэл 29.6-67.0 хувьтай байгаа нь төлөвлөгөө, төсвийг бодитой төлөвлөх, хэрэгжилтийг хангах болон түүнд тавих хяналт хангалтгүй байгааг харуулж байна.

Орд ашиглалт

Орд ашиглалтын зардалд цооногийн өрөмдлөг, цементац, шаврын судалгаа, каротаж, перфораци, шингэн хагалбар, цооногийн үйлчилгээ, туршилт зэрэг ажлууд багтдаг бөгөөд нийт 1,179.8 сая ам.долларын төсөв баталснаас, 526.1 сая ам.доллар буюу 44.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж буй Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн 2014-2018 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийсэн аудитын тайлан

Хүснэгт 17. Орд ашиглалтын зардлын нэгтгэл

/мянган ам.доллар/

№	Ажлын хөтөлбөр	Батлагдсан төлөвлөгөө	Аудитаар баталгаажуулсан гүйцэтгэл	Зөрүү	
				Дүн	Хувь
1	Цооног өрөмдлөгийн ажлууд	500,752.3	302,562.3	198,190.0	60.4
2	Цооногийн цементаци	37,620.0	19,947.7	17,672.3	53.0
3	Шаврын судалгаа	40,133.1	21,060.4	19,072.7	52.5
4	Цооногийн каротаж	30,838.8	15,593.3	15,245.5	50.6
5	Цооногийн перфораци, шингэн хагалбар	333,698.9	103,691.0	230,007.9	31.1
6	Цооногийн ашиглалтын инженерийн болон материалын зардал	169,926.4	48,094.6	121,831.9	28.3
7	Цооногийн үйлчилгээ, ашиглалтын цооногийн каротаж болон туршилт	31,342.6	5,362.1	25,980.5	17.1
8	Судалгаа	8,002.7	2,422.5	5,580.2	30.3
9	Бусад	27,446.8	7,325.2	20,121.7	26.7
	Дүн	1,179,761.7	526,059.0	653,702.6	44.6

Эх сурвалж: Газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас хянаж баталсан Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайн 2014-2018 оны ажлын жилийн төлөвлөгөө, төсөв, гэрээлэгчийн гүйцэтгэсэн тайлагнал.

Аудитаар дараах зөрчлүүдийг илрүүлж, өртөг нөхөгдөх зардлаас хаслаа. Тухайлбал:

- Орд ашиглалтын гэрээт ажлын гүйцэтгэл хангалтгүй, холбогдох анхан шатны баримтын бүрдэл дутуу, гэрээний хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй /Тосон Уул XIX талбайн 2014 онд 2.6 сая ам.доллар, 2015 онд 2.6 сая ам.доллар, Тамсаг XXI талбайн 2014 онд 9.2 сая ам.доллар, 2015 онд 2.0 сая ам.доллар/;
- Өрмийн ажлын гэрээний цооногийн байгаль хамгааллын ажлын зардалд багтсан цооногийн талбайг нөхөн сэргээх нийт 1.3 сая ам.долларын зардал гарсан нь баримтаар нотлогдоогүй /Тосон Уул XIX талбайн 2014 онд 0.3 сая ам.доллар, 2015 онд 0.2 сая ам.доллар, Тамсаг XXI талбайн 2014 онд 0.3 ам.доллар, 2015 онд 0.4 сая ам.доллар/;
- Тосон Уул XIX талбайн DQYT-2014-YTGC-187, DQYT-2014-YTGC-266 өрмийн ажлын гэрээний 8 цооногийн өвлийн улирлын нэмэгдлийг 18 хоногоор хэтрүүлэн тооцоолж, 0.36 сая ам.долларыг гүйцэтгэгчид илүү шилжүүлсэн;
- Тосон Уул XIX талбайн 2015 оны DQYT-2015-YTGC-377 дугаар гэрээний T19-380-xt237 дугаартай налуу ашиглалтын цооногийн (2501-2900m) өрөмдлөгийн ажлын хөлс 0.3 сая ам.долларыг 2016 оны өртөг нөхөх зардалд давхардуулан оруулсан;
- Тамсаг XXI талбайн 2015 оны цооногийн үйлчилгээний зардалд 3.4 сая ам.долларын материалыг худалдан авч зарцуулсан боловч бараа материалын тайлангаар орлого, зарлагыг дамжуулж бүртгээгүй;
- Гэрээний чанарын баталгааны дараа онд олгох төлбөрийг тайлант хугацаанд гэрээний заалт зөрчин гүйцэтгэгч компанид шилжүүлсэн /Тосон Уул XIX талбайн 2014 оны орд ашиглалттай холбоотой 19 гэрээний 9.0 сая ам.доллар, Тамсаг XXI талбайн 2014 оны орд ашиглалтын үйл ажиллагаатай холбоотой байгуулсан худалдан авах болон ажил гүйцэтгүүлэх 25 гэрээний 2015 онд шилжүүлэх 8.6 сая ам.доллар/;
- Хийсэн ажлын гүйцэтгэлийн холбогдох анхан шатны баримтын бүрдэл дутуу /Тосон Уул XIX талбай 2014-2015 оны 25 гэрээний нийт 5.2 сая ам.доллар, Тамсаг XXI талбайн 2014-2015 оны нийт 12 гэрээний 3.1 сая ам.доллар/ байна.

Дэд бүтэц, гадаргуун байгууламжийн ажлууд, машин, туслах тоног төхөөрөмж

Тус чиглэлийн зардалд олборлолтыг нэмэгдүүлэх дэд бүтэц, автозам, туслах төслүүд, судалгааны ажлууд багтдаг бөгөөд нийт 664.1 сая ам.долларыг төлөвлөснөөс, 250.7 сая ам.доллар буюу 37.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 18. Дэд бүтэц, гадаргуун байгууламжийн ажлууд, машин, туслах тоног төхөөрөмжийн зардлын нэгтгэл

/мянган ам.доллар/

№	Ажлын хөтөлбөр	Батлагдсан төлөвлөгөө	Аудитаар баталгаажуулсан	Зөрүү	
				Дүн	Хувь
	Дэд бүтэц, гадаргуун байгууламжийн ажлууд				
1	Олборлолтыг нэмэгдүүлэх дэд бүтцийн ажлууд	251,426.2	141,810.3	109,615.9	56.4
2	Автозамын ажлууд	313,534.5	103,851.0	209,683.5	33.1
3	Туслах төслүүд	85,935.2	2,301.2	83,634.0	2.7
4	Судалгааны ажил	2,559.8	371.3	2,188.5	14.5
	Машин, туслах тоног төхөөрөмж				
1	Машин, туслах тоног төхөөрөмж	10,638.8	2,407.5	8,231.3	22.6
	Дүн	664,094.4	250,741.2	413,353.2	37.7

Эх сурвалж: Газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас хянаж баталсан Гэрээлэгчийн Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайн 2014-2018 оны ажлын жилийн төлөвлөгөө, төсөв, гэрээлэгчийн гүйцэтгэсэн тайлагнал.

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж буй Петрожайна Дачин Тамсаг ХХК-ийн 2014-2018 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийсэн аудитын тайлан

Аудитаар дараах зөрчлүүдийг илрүүлж өртөг нөхөгдөх зардлаас хаслаа. Тухайлбал:

- Гэрээлэгчийн Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайн 110 кв-ын 93.7 км цахилгаан шугам татах ажлын үнийг 0.2 сая ам.доллараар нэмж, нэмэлт гэрээ байгуулсан боловч 2015 оны төсөв, хөрөнгө оруулалтын зардлын төсөвт өөрчлөлт, тодотгол хийж баталгаажуулсан баримтгүй;
- Тамсаг XXI талбайн 2015 оны судалгаа шинжилгээний зардалд БНХАУ-ын хилээс Тамсаг XXI талбай хүртэлх 35кв-ын 23 км цахилгаан дамжуулах шугам барих ажлыг тооцоо судалгаагүй эхлүүлэн, нийт 0.04 сая ам.долларын зураг төсөв боловсруулах гэрээ хийж үргүй зардал гаргасан. Тус гэрээний гүйцэтгэлийг нотлох анхан шатны баримт хангалтгүй бөгөөд төсөвт өртгийн задаргаа болон гэрээ дүгнэсэн баримтгүй, техникийн нөхцөлөө баталгаажуулаагүй;
- Тамсаг XXI талбайн 2014 онд импортоор орж ирсэн тоног төхөөрөмжийн жагсаалтад байхгүй, нэгжийн үнэ тохирохгүй нийт 0.9 сая ам.долларын тоног төхөөрөмжүүд байна. Үүнд: Үйлдвэрлэлийн баазын контейнерын угсрах 13 нэр төрлийн 0.8 сая ам.долларын зөөврийн контейнер, 14-ММ-660.661 гэрээтэй 4 нэр төрлийн 0.02 сая ам.долларын тоног төхөөрөмж, GUOMAO/14-ММ-755 гэрээтэй 2 нэр төрлийн 0.08 сая ам.долларын тоног төхөөрөмж;
- Цооногийн үйлчилгээний материалын зардлыг материалын бодит гүйцэтгэлээр бус тухайн жилийн худалдан авалтын дүнгээр 10.0 сая ам.долларын зардал хүлээн зөвшөөрсөн /Тосон Уул XIX талбайн 2014 онд 0.5 сая ам.доллар, 2015 онд 2.7 сая ам.доллар, Тамсаг XXI талбайн 2014 онд 2.5 ам.доллар, 2015 онд 4.3 сая ам.доллар/.

Байгаль орчны хамгааллын ажлууд

Байгаль орчны хамгааллын зардалд жил тутам 5-12 нэр төрлийн ажил хэрэгжүүлэхээр нийт 11.6 сая ам.долларыг төлөвлөснөөс, 6.8 сая ам.доллар буюу 58.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 19. Байгаль орчны хамгааллын ажлын зардлын нэгтгэл

№	Ажлын хөтөлбөр	Батлагдсан төлөвлөгөө	Аудитаар баталгаажуулсан	Зөрүү	
				Дүн	Хувь
1	Хаягдал өрмийн шингэнийг саармагжуулах	3,454.2	1,691.3	1,762.9	49.0
2	Газрын хөрсний дээж авах, авсан дээжийн лабораторийн шинжилгээ	183.0	175.5	7.5	95.9
3	Ахуйн бохир усыг цэвэршүүлэх станцын барилга угсралтын ажил	800.0	342.0	458.0	42.8
4	Хатуу хог хаягдлын цэгийн удирдлага, үйл ажиллагаа	580.0	418.2	161.8	72.1
5	Тостой шороо цэвэрлэх	800.0	0.0	800.0	-
6	БО-ны үнэлгээний ажил	500.0	260.3	239.7	52.1
7	БО-ны хяналт шинжилгээ	150.0	185.0	(35.0)	123.3
8	Технологийн хаягдал буюу тостой бохир шороог цэвэршүүлэх	930.0	0.0	930.0	-
9	Үйлдвэрлэлийн шингэн хаягдлын сангийн нөхөн сэргээлт	1,400.0	1,149.5	250.5	82.1
10	Биологийн нөхөн сэргээлтийн ажил, ургамалжуулалт	1,044.0	185.6	858.4	17.8
11	Замын нөхөн сэргээлт /95 замын тэмдэг, замын өргөн хязгаарлагч 43 км, замын хаалт 64 км/	236.8	180.4	56.4	76.2
12	Тосон Уул XIX дахь дотоод сүлжээний авто замын зураг гаргах	10.0	0.0	10.0	-
13	Гүний усны мониторинг хийх зориулалт бүхий усны цооногийн өрөмдлөг	400.0	487.2	(87.2)	121.8
14	Байгаль орчны ажлын аудит	80.0	50.0	30.0	62.5
15	Говийн цооног хоорондын замын засвар, үйлчилгээ	340.0	195.0	145.0	57.4
16	Үйлдвэрлэлийн бааз болон ТА-2 ОИБ-ийн ойролцоох биологийн нөхөн сэргээлт ба ургамалжуулалт, моджуулалт	160.0	110.0	50.0	68.8
17	Үйлдвэрлэлийн шингэн хаягдлын санг засварлах	60.0	60.0	0.0	100.0
18	Үйлдвэрлэлийн шингэн хаягдлын санг байгуулах	500.0	300.0	200.0	60.0
19	Тамсаг 21-р талбай дахь өрөмдлөгийн шингэнийг цэвэрлэх, нөхөн сэргээх, шингэн саармагжуулах	0.0	1,053.1	(1,053.1)	-
Дүн		11,628.0	6,843.2	4,784.8	58.9

Эх сурвалж: Газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас хянаж баталсан Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайн 2014-2018 оны ажлын жилийн төлөвлөгөө, төсөв, гэрээлэгчийн гүйцэтгэсэн тайлагнал.

Аудитаар дараах зөрчлүүдийг илрүүлж өртөг нөхөгдөх зардлаас хаслаа. Тухайлбал:

- Хөх чанар ХХК нь эвдэрсэн газрын техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх тусгай зөвшөөрөлтэй боловч хатуу хог хаягдал устгах, дахин боловсруулалтад оруулах ажлыг гүйцэтгэсэн нь чиг үүргийн дагуу ажил гүйцэтгээгүй, тухайн ажил менежментийн төлөвлөгөөнд тусгаадаагүй байна. Дорнод аймгийн Засаг даргын 2014 оны А/402 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн дүгнэлтээр хог хаягдлын менежментийн

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж буй Петрожайна Дачин Тамсаг ХХК-ийн 2014-2018 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийсэн аудитын тайлан

төлөвлөгөөний биелэлтийг 66.6% гэж дүгнэсэн, Хөх чанар ХХК-ийн үйл ажиллагаа хангалтгүй, хууль тогтоомж зөрчсөн талаар дурдсан байна. /Тосон Уул XIX талбайн 2014 онд 0.05 сая ам.доллар, 2015 онд 0.01 сая ам.доллар/;

- Тамсаг ХХI талбайд 2015 онд "Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө"-нд тусгасан 77 өрмийн шаврын хаягдлын сан, 10 үйлдвэрлэлийн шингэн хаягдлын сан, зам болон үйлдвэрлэлийн баазад тус тус техникийн нөхөн сэргээлт хийх, мөн ТА-2 олборлолтын ил байгууламжийн талбайд 0.09 сая ам.долларын биологийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн боловч дээрх арга хэмжээг хэрэгжүүлж ажиллаагүй, Халхголын хишиг ХХК-аар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан ч гүйцэтгэл хангалтгүй, Ажлын хэсэгт хүлээлгэн өгөөгүй;
- Тамсаг ХХI талбайн 2015 онд төлөвлөсөн сөрөг нөлөөллийг бууруулах ажил, тээврийн болон дотоод автозамын хажуугаар 1000 ширхэг мод тарих, мөн тосны цооног хооронд далд шугам байгуулж, автомашины явалтыг багасгахаар Эко Сольюшн Хануй ХХК-тай байгуулсан 0.08 сая ам.долларын гэрээт ажлууд бүрэн дуусаагүй, дарж булсан шорооны тэгшилгээ хийгээгүй, Хатуу хог хаягдлын байгууламжийн үйл ажиллагааг мэргэжлийн байгууллагаар хийлгээгүй, Түвшин мөрөн Эрдэнэ ХХК-тай байгуулсан 0.05 сая ам.долларын гэрээт ажлын гүйцэтгэл, ажлын чанар тус тус хангалтгүй;
- Тосон Уул XIX талбайн 2014 онд шороон далангаар хүрээлүүлсэн газарт шингэн нефть бүтээгдэхүүн болон төрөл бүрийн хог хаягдлыг хольж хаяж байгаа нь хүрээлэн байгаа байгаль орчинд төдийгүй хөрсөн бүрхэвчийн бохирдолтыг улам бүр нэмэгдүүлэх сөрөг үр дагаврыг бий болгож байгаа бөгөөд Юу Эм Си Эм ХХК-аар хийлгэсэн хөрсний нарийвчилсан үнэлгээгээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй;
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан ажлуудыг тус тус хийгээгүй /Тосон Уул XIX талбайд 2014 оны ахуйн барилга угсралтыг цэвэршүүлэх станцын барилга угсралтын ажил 0.4 сая ам.доллар, Технологийн хаягдал буюу тостой бохир шороог цэвэршүүлэх 0.7 сая ам.доллар, Тосон Уул XIX талбай дахь дотоод сүлжээний авто замын зураг гаргах 0.01 сая ам.доллар, Тосон Уул XIX талбайд 2015 онд газрын хөрсний дээж авах, авсан дээжид лабораторийн шинжилгээ хийх 0.02 сая, Тостой шороо цэвэршүүлэх 0.8 сая, гүний усны мониторинг хийх зориулалт бүхий усны цооногийн өрөмдлөг 0.07 сая, ТА-1 байгууламжийн тостой хаягдал ус цэвэршүүлэх бетон даланд хуримтлагдсан лаг шаврыг саармагжуулах 0.5 сая, ус тогтдог намгархаг газарт байрласан цооногийн замыг засах 0.2 сая, байнгын ахуйн цэвэрлэх байгууламж байгуулах 0.4 сая ам долларын ажлууд/;
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд зарим ажлыг төлөвлөж тусгаагүй /Тосон Уул XIX талбайд 2015 онд Юу Эм Си Эм ХХК-аар Байгаль орчны үнэлгээний ажил 0.04 сая, Бодлын нууц ХХК 2014 оны байгаль орчны нөхөн сэргээлтэд тавьсан хяналт 0.03 сая, Бадамлиг ХХК байгаль орчны аудит 0.02 сая, КТК ХХК-аар 0.2 сая ам.долларын ажлууд/;
- Тосон Уул XIX талбайд 2015 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг дүгнүүлээгүй, мөн Бадамлиг ХХК-ийн 2015 онд гүйцэтгэсэн Байгаль орчны аудитаар хуулийн нийцлийн нэгдсэн үнэлгээгээр "ХАНГАЛТГҮЙ" гэж дүгнүүлж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланд хөрөнгийн зарцуулалтыг ажил бүрээр тодорхойлох, ялангуяа хөрс, ус, агаарын бохирдол, доройтлыг бууруулах, техникийн болон биологийн нөхөн сэргээлт, байгальд ээлтэй техник, технологи нэвтрүүлэх, хяналт шинжилгээ хийх дотоодын багажтай болох зэрэг байгаль орчныг хамгаалах, сэргээх, цөлжилтийг бууруулахтай холбогдсон асуудлын талаар дурдаж зөвлөсөн боловч энэ талаар хийсэн ажил хангалтгүй байна.

Мөн МУЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг ГТГ болон Петрожайна Дачин Тамсаг ХХК 2014-2018 онуудад жилийн уулзалтыг зохион байгуулж, Тосон Уул XIX, Тамсаг ХХI талбайд өмнөх оны төлөвлөсөн ажлын хэрэгжилт болон дараа онд хийх ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг хэлэлцэн, талууд БХГ-ний заалтуудыг үргэлжлүүлэн тогтвортой хэрэгжүүлэхийн тулд тодорхой ажлуудыг харилцан тохиролцсон протокол үйлдсэн боловч ихэнх ажлууд тухайн ондоо бүрэн хэрэгжээгүй, дараагийн оны протоколуудаар дахин тохиролцоод ч үр дүнд хүрээгүй байна. Тухайлбал:

- 2011-2013 оны өртөг нөхөгдөх зардлыг баталгаажуулах санхүүгийн шалгалт хийж дуусгах /2014-2018 оны протоколуудад/;
- Талууд МУЗГ-т ногдох тосны орлогын тооцоог 2 талаас улирал бүр нийлэх /2014-2016 оны протоколуудад/;
- Петрожайна Дачин Тамсаг ХХК нь Тосон Уул, Тамсагийн ордуудын "Орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө"-г Уул уурхайн сайдын баталсан "Орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тавих шаардлага"-ын дагуу холбогдох тооцоо, судалгаануудыг шинэчлэн боловсруулах /2016-2018 оны протоколуудад/;
- ӨНЗ-д тооцогдох худалдан авсан бараа, материалын орлогыг гадаадаас болон дотоодоос худалдан авснаар ялган, нягтлан бодох бүртгэлийн дансанд нэр, марк, код, тоо хэмжээг тодорхой тусгаж бүртгэн, зарлага болох, бараа материалын тайланг ажлын жилийн төлөвлөгөө, төсөвт тусгасан ангиллын дагуу нэр төрөл бүрээр гаргаж, улирал бүр АМГТГ-т ирүүлэх, тайланг гаалийн байгууллагаас авах гаргасан мэдээ, бүртгэл, санхүүгийн бусад анхан шатны баримтыг үндэслэн гаргах /2017/;
- Ажиллагсдын цалин хөлс, түүнтэй адилтгах зардлыг нийгмийн даатгалын шимтгэлийн тайлантай нийцүүлэх, Монгол, Хятад ажиллагсдын цалин хөлс, түүнтэй адилтгах зардлыг ажилтнуудын ажилладаг хэлтэс, нэгжийг тодорхой тусгаж, тус тусад нь сар бүр гаргах бөгөөд өртөг нөхөгдөх зардлын улирлын тайланд хавсаргаж байх /2017/;
- Ажил эхлэх, ажил дуусах мэдэгдэл, зарцуулсан бараа материалын тайланг талбай дээр ажиллаж буй АМГТГ-ын мэргэжилтэнд тухай бүр хянуулж, баталгаажуулсан байх, баталсан төлөвлөгөө, төсөвт тусгаагүй ажлыг нэмж гүйцэтгэх шаардлагатай бол Петрожайна Дачин Тамсаг ХХК нь эдгээр ажлуудыг хийх үндэслэл тайлбараа ГТГ-т ирүүлэх /2014-2018 оны протоколуудад/;

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж буй Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн 2014-2018 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийсэн аудитын тайлан


- *Туслан гүйцэтгэгчид төлөх төлбөрийг Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкаар дамжуулах /2018/*
- *Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулгын холбогдох зүйл, заалтуудыг /11.2.5, 11.2.6, 11.2.7, удирдлагын зардал тооцоох хувь хэмжээ, Монгол Улсад бүртгэлтэй, татвар төлөгч хуулийн этгээдээр туслан гүйцэтгүүлэх, үйл ажиллагааны зардал дахь хуулийн зардал болон бусад хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байгаа болон БХГ-ний зарим заалтуудтай зөрчилдөж байгаа асуудлаар 2 талын ажлын хэсгийн хэлэлцээр хийж шийдвэрлэхээр харилцан тохиролцдог боловч тодорхой үр дүнд хүрээгүй /2015-2017 оны протоколууд/ гэх мэт.*

Мөн хөрөнгө оруулалт, ӨНЗ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тайланг англи хэл дээр бүртгэн тайлагнаж, анхан шатны баримтуудыг хятад хэл дээр үйлдсэнийг газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас монгол хэлээр хөрвүүлж хүлээн аваагүй нь зардлыг хянахад хүндрэл үүсгэж байгаа бөгөөд энэ нь Монгол хэлний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Монгол Улсын нутаг дэвсгэрт дараах үйл ажиллагаа, албан хэргийг монгол хэлээр хөтлөн явуулна, 6.1.1-д “төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагаа, албан хэрэг хөтлөлт” болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагын төлөөний газар нь нягтлан бодох бүртгэлээ монгол хэлээр хөтөлнө” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо хуваарилалтад тавьж буй хяналт

Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайгаас олборлон экспортолж буй газрын тосны тоо хэмжээ, чанарын шинжилгээг 2011 оноос хөндлөнгийн хяналтын эрх бүхий Амбер ХХК болон холбогдох хяналтыг ГЕГ, МХЕГ, ХХҮЕГ, ГИХГ-ын орон нутаг дахь салбар байгууллага Газрын тосны газрын төлөөлөгч, мэргэжилтнүүд хяналт тавьж байна.

Газрын тосны экспортын үйл ажиллагаа дараах байдлаар явагдаж байна. Үүнд:



ГТГ-аас 2011 оны 6 дугаар сарын 24-ний өдөр Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайгаас олборлож буй түүхий тосыг борлуулах эрхийг Петрочайна Дачин Тамсаг ХХК-д олгож, худалдан авагчтай гэрээний нөхцөлийг тохиролцож, ГТГ-ын зөвшөөрлийг авсны үндсэн дээр Гэрээлэгчийг худалдан авагч талтай Борлуулалтын гэрээг байгуулахыг зөвшөөрч харилцан тохиролцсон байна.

Энэ дагуу гэрээлэгч 2014-2018 онд Хятадын үндэсний газрын тосны нэгдсэн корпорац /China National United Oil Corporation/, Петрочайна олон улсын /Хонг Конг/ корпорац /PetroChina International /Hong Kong/ Corporation Limited/-тай газрын тос борлуулах нийт 3 гэрээ байгуулж, жил бүр хугацааг сунгаж ирсэн байна.

ГТГ болон Петрочайна Дачин Тамсаг ХХК 2014-2016 онуудад жилийн уулзалтаар Талууд МУЗГ-т ногдох тосны орлогын тооцоог 2 талаас улирал бүр нийлэх талаар тохиролцсон боловч хэрэгжүүлж ажиллаагүй байна.

ГТГ нь гэрээлэгчийн батлагдсан төсвийн гүйцэтгэл, тухайн оны хөрөнгө оруулалт, ӨНЗ, нөөц ашигласны төлбөр, олборлосон болон борлуулсан газрын тосны тайланг хянаж, нэгтгээгүй

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж буй Петрожайна Дачин Тамсаг ХХК-ийн 2014-2018 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийсэн аудитын тайлан

нь Газрын тосны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.8-д “Гэрээлэгчийн тухайн жилийн хөрөнгө оруулалт, зардал, нөөц ашигласны төлбөр, олборлосон болон борлуулсан газрын тосны тайланг хянаж нэгтгэх” гэсэн чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй байна.

Иймд гэрээлэгчийн тухайн жилийн болон нэмэлт төлөвлөгөө, төсвийн санал, төсвийн төслийн тооцоолол, мөн зардлыг нэмэгдүүлсэн болон бууруулсан үндэслэл, шалтгааныг тогтоох, батлагдсан төсвийн гүйцэтгэл, тухайн оны нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөх зардал, олборлосон болон борлуулсан газрын тосны тайланг тухай бүр буюу улирлаар анхан шатны баримттай тулгах, орлого, зардлыг хянаж, 2 тал хүлээн зөвшөөрснөөр тооцоо нийлж, баталгаажуулах шаардлагатай байна.

2.2. Гэрээлэгчийн газрын тосны ашиглалтын үйл ажиллагааны анхдагч мэдээ, тайлан, материалыг хүлээн авах, жилийн ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй байна

Гэрээлэгч нь Уул уурхайн сайдын 2015 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 49 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын анхдагч болон үр дүнгийн тайланд тавих шаардлага” журмын 2 дугаар зүйлийн 2.1-д “Жилийн тайланд батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гэрээт талбайд гүйцэтгэсэн бүх ажлын үр дүнг талбай тус бүрээр нэгтгэж, Хавсралт 1-ийн дагуу боловсруулан тайлагнана” гэж заасан байна.

Гэрээлэгч нь Газрын тосны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1⁵⁵-д заасны дагуу батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажлын тайланг ГТГ-т хүргүүлсэн байдлыг 2014-2018 оноор нэгтгэж хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 20. Тосон Уул XIX, Тамсаг ХХI талбайн 2014-2018 онд хэрэгжүүлсэн ажлын жилийн төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн хөрөнгө оруулалтын ажил

/ажлын нэр төрлөөр, давхардсан тоогоор/

Үзүүлэлт	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл			Зөрүү		
		Аудитаар баталгаажуулсан	Гэрээлэгч тайлагнасан	АМГТГ хянасан	Төлөвлөсөн ажил хэрэгжүүлээгүй	АМГТГ хянаагүй	Гэрээлэгч бодитой тайлагнаагүй
Орд ашиглалт	439	322	351	293	117	29	-29
Дэд бүтэц	200	102	108	106	98	-4	-6
Машин болон туслах тоног төхөөрөмж	10	10	10	5	0	5	0
Байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээх	79	50	60	61	29	-11	-10
Ашиглалтын дагалдах ажлууд	11	10	9	0	1	10	1
Дүн	739	494	538	465	245	29	-44

Эх сурвалж: Газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас хянаж баталсан 2014-2018 оны ажлын жилийн төлөвлөгөө, төсөв, гэрээлэгчийн гүйцэтгэлийн тайлан.

Хөрөнгө оруулалтын зардал /орд ашиглалт, дэд бүтэц, машин туслах тоног төхөөрөмж, байгаль орчин хамгаалах нөхөн сэргээх, ашиглалтын дагалдах ажил/-д 2014-2018 онд давхардсан тоогоор, нийт 739 төрлийн ажил хэрэгжүүлэхээр баталснаас аудитаар 494 ажлыг баталгаажууллаа.

Аудитаар гэрээлэгчийн ажлын жилийн төлөвлөгөө төсвийн дагуу хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийг анхан шатны баримттай тулган баталгаажуулахад анх баталсан төсвөөс төлөвлөсөн ажлаа хэрэгжүүлээгүй 245, гэрээлэгч илүү тайлагнасан 44, АМГТГ хянаагүй 29 байгаа нь ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг батлах, түүний гүйцэтгэлд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэх ГТГ-ын үйл ажиллагаа хангалтгүй байгаатай холбоотой байна.

Гэрээлэгчийн 2014-2018 оны ажлын жилийн төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэлийг гэрээлэгчийн тайлагнасан, ГТГ-ын хянасан байдлаар ажлын нэр төрлөөр тулгаж үзэхэд дараах нийтлэг зөрчлүүд илэрснийг тоон дүнгээр нэгтгэж харуулбал:

⁵⁵ Гэрээлэгч хайгуул, ашиглалтын ажлын үр дүнгийн тайлан, анхдагч мэдээ материалыг хуанлийн тухайн жил дууссанаас хойш 90 хоногийн дотор төрийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгнө.

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж буй Петрожайна Дачин Тамсаг ХХК-ийн 2014-2018 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийсэн аудитын тайлан

Хүснэгт 21. Гэрээлэгчийн Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайн 2014-2018 оны хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэл

/Нэг ажлын нэр төрлийг нэг тоо ширхгээр тооцов/

№	Гэрээлэгчийн 2014-2018 оны ажлын жилийн төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэл	Орд ашиглалтын ажлууд		Дэд бүтэц, гадаргуун байгууламж, машин тоног төхөөрөмж		Байгаль орчны хамгааллын ажлууд		Нийт
		XIX	XXI	XIX	XXI	XIX	XXI	
1	Төлөвлөөгүй болон төсөв хэтрүүлж гүйцэтгэсэн	10	5	5	7	9	7	43
2	Гэрээлэгч гүйцэтгэлээр тайлагнаагүй ажлыг АМГТГ гүйцэтгэснээр хянасан	6	2	7	16	2	-	33
3	Гэрээлэгчийн илүү тайлагнасныг аудитаар хассан	22	40	10	8	11	3	94
4	Гэрээлэгчийн тайлагнасан тоо АМГТГ-ын хянасан тоо зөрүүтэй	12	21	1	8	-	1	43
5	Он дамжсан ажлыг төлөвлөгөө, гүйцэтгэлээр нь хянаагүй	1	1	21	23	-	1	47
Бүгд		51	69	44	62	22	12	260

Эх сурвалж: АМГТГ хянаж баталсан Гэрээлэгчийн 2014-2018 оны ажлын жилийн төлөвлөгөө, төсөв, гэрээлэгчийн тайлагнасан гүйцэтгэл, АМГТГ-аас хянасан 2014-2018 оны ажлын жилийн төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэл.

Гэрээлэгчийн 2014-2018 оны хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэлийг анхан шатны баримттай тулгаж үзэхэд нийт зөрчилтэй 260 ажил байгаагаас төлөвлөөгүй ажил болон төсөв хэтрүүлж гүйцэтгэсэн 43, гэрээлэгчийн гүйцэтгэлээр тайлагнаагүй ажлыг АМГТГ гүйцэтгэснээр хянасан 33, гэрээлэгчийн илүү тайлагнасныг аудитаар хассан 94, гэрээлэгчийн тайлагнасан тоо АМГТГ-ын хянасан тоо зөрүүтэй 43, өмнөх оноос дамжсан ажлыг төлөвлөгөө, гүйцэтгэлээр нь хянаагүй 47 ажил байна.

Газрын тосны ашиглалтын үеийн үйл ажиллагааны анхдагч мэдээлэл, тайлан, материалыг хүлээн авах, хянах чиг үүргийг хэрэгжүүлэгч ГТГ-ын үйл ажиллагаа хангалтгүй байгаа нь Газрын тосны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3⁵⁶, 9.1.10⁵⁷, 9.1.11⁵⁸ дэх заалттай тус тус нийцэхгүй байна.

Нөгөө талаас гэрээлэгчийн газрын тосны орд ашиглалтын үйл ажиллагаанд АМГТГ-ын Ашиглалтын хэлтсийн 8 мэргэжилтэн /2 талбайд 1, 1 мэргэжилтэн 14 хоног тутамд ээлжилж томилолтоор ажиллахдаа 1 талбайд газрын тосны олборлолт, орд ашиглалтын хөрөнгө оруулалт болон байгаль орчны ажлын хяналтыг давхар гүйцэтгэдэг/, өртөг нөхөх зардал хариуцсан 1 мэргэжилтэн ажилладаг нь хяналт хангалтгүй болоход нөлөөлж байна.

Иймд газрын тосны ашиглалтын үеийн үйл ажиллагааны анхдагч мэдээлэл, тайлан, материалыг хүлээн авах, хянах чиг үүргийг холбогдох төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолт, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нарийвчлан тодорхой тусгах, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, ажлын гүйцэтгэл, түүний тайлагналд УУХҮЯ-ны хариуцсан нэгж, албан тушаалтнуудаас тавих давхар болон дараалсан хяналтын үр дүнг сайжруулах шаардлагатай байна.

БҮЛЭГ 3. БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭГ ШИНЭЧИЛЖ, МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖИД НИЙЦҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

3.1. Гэрээний талууд зөвшилцөлд хүрээгүйгээс Бүтээгдэхүүн хуваах гэрээг шинэчлэх ажил зогсонги байдалтай байна

Газрын тостой холбоотой үйл ажиллагааны эрх зүйн орчны тухайд МУЗГ-аас 1991 оны БНМАУ-ын Газрын тосны тухай хууль болон МУЗГ-ын 1991 оны 204 дүгээр тогтоолоор баталсан “БНМАУ-ын Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журам”-ыг мөрдлөг болгож, дараах Бүтээгдэхүүн хуваах гэрээг тус тус байгуулсан. Үүнд:

⁵⁶ газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг батлах, түүний гүйцэтгэлд хяналт тавих;

⁵⁷ хайгуул, ашиглалтын талбайд гүйцэтгэсэн газрын тос, уламжлалт бус газрын тосны геологи, геофизик, гидрогеологи, геохими, ерөмдлөг, хайгуул, ашиглалттай холбогдсон үйл ажиллагааны анхдагч мэдээлэл, тайлан, материалыг хүлээн авах, хянах;

⁵⁸ газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын ажлын үр дүнгийн тайланг хэлэлцэж, хүлээн авах;

1. Монгол Газрын тос (МГТ) компани болон Медаллион Монгол Ойл компанийн хооронд Тосон Уул XIX гэрээт талбайн талаар Бүтээгдэхүүн хуваах гэрээг 1993 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр;
2. Монгол газрын тосны товчоо (хуучин нэрээр) болон Австралийн Комманд Петролиум Лимитед, Монголын Цагаан шонхор ойл корпорац, Соко тамсаг Монголиа. Инк компаниудын хооронд Тамсаг ХХI гэрээт талбайн талаар Бүтээгдэхүүн хуваах гэрээг 1995 оны 12 дугаар сарын 11-ний өдөр тус тус байгуулжээ.

УИХ-аас 2014 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 18 дугаар тогтоолоор “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ыг баталсан, түүнчлэн газрын тос, байгалийн хий, уламжлалт бус газрын тосны талаарх ойлголт, төрийн байгууллагууд болон нутгийн удирдлагын байгууллагын эрх хэмжээг тодорхой болгох, роялти, татварын хувь хэмжээ, түүнийг оногдуулах, хөнгөлөх чөлөөлөх, тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, газрын тос эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаатай холбоотой харилцааг нарийн зохицуулах шаардлага үүссэн байна.

Газрын тосны тухай хуулийг шинэчлэн баталсантай холбогдуулан Засгийн газрын 2014 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 342 дугаар тогтоолоор Засгийн газрын 1991 оны 204 дүгээр “БНМАУ-ын Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журам”, 2004 оны 26 дугаар “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсон байна.

Мөн Газрын тосны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 7 дугаар зүйлийн 7.1.12-д “Бүтээгдэхүүн хуваах гэрээний загварыг батлах” гэж заасны дагуу МУЗГ-аас 2015 оны 104 дүгээр тогтоолоор “Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх талаар төрийн захиргааны байгууллага болон гэрээлэгч нарын хооронд байгуулах Бүтээгдэхүүн хуваах гэрээний загвар”-ыг баталсан байна.

МУЗГ-ын 2016 оны 130 дугаар тогтоолоор Газрын тосны тухай хууль /шинэчилсэн найруулга/ батлагдахаас өмнө байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийг үндсэн нөхцөлийг нь өөрчлөхгүйгээр дээрх загварт нийцүүлэн шинэчлэх арга хэмжээ авахыг эрх бүхий төрийн захиргааны төв байгууллагад даалгасан байна.

Газрын тосны газар /хуучин нэрээр/-ын даргын 2016 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 89, Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2016 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/19, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2016 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн А/57, 2018 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/12 дугаар тушаалаар тус тус байгуулагдсан Ажлын хэсгүүд Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийг хуульд нийцүүлэн шинэчлэх талаарх шаардлагыг гэрээлэгч компанид удаа дараа тавьж, уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан боловч Гэрээлэгчтэй “БХГ-ний зарим асуудлаар зөвшилцөлд хүрээгүй тул өнөөг хүртэл Тосон Уул XIX, Тамсаг ХХI гэрээт талбайн БХГ-г шинэчилж байгуулаагүй байна.

Иймд аудитын явцад 1993-1995 онд байгуулсан БХГ-үүд болон эдгээр гэрээг байгуулснаас хойш батлагдсан хууль тогтоомжийн харилцан хамаарал, нөлөөллийг тогтоохын тулд гэрээний харилцаанд мөрдөх хууль ба хууль буцаан хэрэглэх журмыг үндэслэл болгов.

Тамсаг ХХI, Тосон Уул XIX талбайн БХГ-ний 25.2-д “Талууд Монгол Улсын хуулийг дагаж мөрдөх бөгөөд гэрээлэгчийн урьдчилан бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр энэ гэрээний дагуу түүний эрхийг үгүйсгэхгүй эсхүл өөрчлөхгүй” гэж заасан байна. Монгол Улсын хуулийг дагаж мөрдөнө гэж талууд нэгэнт тохиролцсон учраас гэрээ байгуулах үед хүчинтэй байсан болон шинээр батлагдах хууль тогтоомжийг нэгэн адил дагаж мөрдөх үүрэг хүлээнэ. Гэхдээ талуудын эрх ашгийг дордуулах агуулгатай шинэ хууль тогтоомжийг гэрээлэгч зөвшөөрсөн нөхцөлд хэрэглэх боломжтой байдлаар талууд тохиролцсон байна.

Хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь өмнө байгуулсан гэрээний харилцаанд нөлөө үзүүлэх нөхцөлийг Иргэний хууль болон тухайн хуулиар зохицуулж байна. Тухайлбал, хуулийг буцаан хэрэглэх дараах журмыг 2002 оны Иргэний хуулийн 5 дугаар зүйлд тусгасан байна. Үүнд:

2002 оны Иргэний хуулийн 5 дугаар зүйл. Иргэний хууль тогтоомжийг буцаан хэрэглэх	
5.1.	Хуульд зааснаас бусад тохиолдолд иргэний хууль тогтоомжийг буцаан хэрэглэхгүй.

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж буй Петроцайна Дачин Тамсаг ХХК-ийн 2014-2018 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийсэн аудитын тайлан

5.2.	<i>Шинээр баталсан хууль тогтоомж нь гэрээний нэг буюу хоёр талын эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулахаар бол гэрээний нөхцөл хүчин төгөлдөр байна.</i>
5.3	<i>Гэрээний талууд харилцан хүлээн зөвшөөрсөн тохиолдолд өмнө үйлчилж байсан хууль тогтоомжоос илүү тааламжтай нөхцөл олгож байгаа шинээр баталсан хууль тогтоомжийг хэрэглэж болно.</i>

Энэ талаар Газрын тосны тухай хууль (шинэчилсэн найруулга)-д хууль хүчин төгөлдөр болох нөхцөл ба өмнө байгуулсан БХГ-д үзүүлэх нөлөөний талаар дараах зохицуулалтыг тусгасан байна. Үүнд:

Газрын тосны тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 45 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох	
45.1	<i>Энэ хуулийг дагаж мөрдөхөөс өмнө буюу 1991 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр баталсан Газрын тосны тухай хуулийн дагуу байгуулсан гэрээнд энэ хуулийн 17.3.1, 17.3.6-17.3.11, 30.2, 30.4, 32.2, 32.3, 33.1, 33.2-т заасан төлбөр, зардал, өртөг нөхөлт, бүтээгдэхүүн хуваалтыг тухайн гэрээнд заасан хувь, хэмжээгээр зохицуулах ба энэ хуулийн 17.3.2-т заасан нөөц ашигласны төлбөр төлөхгүй байгаа гэрээний тухайд төрийн захиргааны байгууллага гэрээлэгчтэй харилцан тохиролцож уг төлбөрийн хэмжээг тогтооно.</i>

Газрын тосны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн дээрх заалтаас үзэхэд өмнө байгуулсан гэрээ, түүний нөхцөлд шинэ хууль ямар нэг нөлөө үзүүлэхгүй, өмнөх гэрээний нөхцөлийг хэвээр үлдээхээр заасан байна. Зөвхөн талууд харилцан тохиролцсон тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Энд дурдаж буй “хуулийг буцаан хэрэглэхгүй байх” журмыг Иргэний хуулийн 5 дугаар зүйлийн зохицуулалттай хамт хэрэглэнэ. Ингэхдээ эхлээд 2014 оны Газрын тосны тухай хуулийн 45 дугаар зүйлд заасан тусгайлсан журам, дараа нь Иргэний хуулийн 5 дугаар зүйлд заасан ерөнхий журмыг мөрдөнө.

Өмнө дурдсаныг үндэслэл болговол, Тамсаг ХХИ, Тосон Уул XIX талбайн Бүтээгдэхүүн хуваах гэрээний “төлбөр, зардал, өртөг нөхөлт, бүтээгдэхүүн хуваалт”-ыг зохицуулсан зүйл, заалтуудын хувьд 2014 оны Газрын тосны тухай хуулийн зохицуулалт ямар нэг нөлөө үзүүлэхгүй буюу уг хуулийг буцаан хэрэглэхийг аль нэг тал шаардах боломжгүй байна.

Иймд талууд Тамсаг ХХИ, Тосон Уул XIX талбайн БХГ-ний нөхцөлүүдийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх замаар харилцан тохиролцох, ялангуяа гэрээний нэг тал болох МУЗГ-ыг төлөөлж буй АМГТГ болон уул уурхай, газрын тосны салбарын бодлого, хууль, эрх зүйн орчин, салбарын хөгжлийг хангах чиг үүрэг бүхий төрийн захиргааны төв байгууллага уг асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

3.2. Бүтээгдэхүүн хуваах гэрээг шинэчлээгүйгээс Газрын тосны тухай хууль болон бусад хууль тогтоомжтой нийцэхгүй байх үр дагавар үүсэж байна

Тус аудитын хүрээнд хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, экспорт, борлуулалтын орлогыг баталгаажуулахдаа 1991 оны Газрын тосны тухай хууль болон Тамсаг ХХИ, Тосон Уул XIX талбайн БХГ-г баримталж, БХГ-ээр зохицуулаагүй асуудлын хүрээнд 2014 оны Газрын тосны тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийг баримталсан болно.

Гэрээний талууд Тамсаг ХХИ, Тосон Уул XIX талбайн талаар БХГ-ний зарим заалтыг хэрэгжүүлэхийн тулд нэмэлт хэлэлцээр хийж, бүтээгдэхүүн хуваах гэрээний салшгүй хэсэг гэж тэмдэглэн протокол үйлдэж, харилцан тохиролцож ирсэн байна. БХГ-г байгуулсан тогтоол, шийдвэр, нэмэлт өөрчлөлт, талуудын гэрээний зарим заалтыг харилцан тохиролцсон протоколын дэлгэрэнгүйг [Хавсралт 9](#)-өөс үзнэ үү.

БХГ нь Монгол Улсын олон улсын гэрээнд хамаарахгүй бөгөөд гадаад улсын хувь этгээдтэй байгуулж буй хувийн эрх зүйн гэрээ мөн. Энэхүү гэрээ нь гэрээ байгуулах үед хүчин төгөлдөр үйлчилж байсан үндэсний хууль тогтоомжид нийцсэн байх шаардлагатай ба гэрээ эсхүл гэрээний аль нэг зүйл, заалт нь хууль тогтоомж зөрчсөн бол тухайн гэрээ бүхэлдээ эсхүл хэсэгчлэн хүчингүй байх эрх зүйн үр дагавартай.

а. Бүтээгдэхүүн хуваах гэрээний зарим зүйл, заалт Газрын тосны тухай хуульд нийцэхгүй байна

Тосон Уул XIX гэрээт талбайн БХГ-г батламжилсан болон зөвшөөрсөн талаарх Засгийн газрын тогтоолыг Ашигт малтмал, газрын тосны газар, Архивын ерөнхий газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын архиваас авахаар албан бичгээр хандсан боловч эдгээр байгууллагуудын архивд хадгалагдаагүй байна.

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж буй Петрожайна Дачин Тамсаг ХХК-ийн 2014-2018 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийсэн аудитын тайлан

Түүнчлэн АМГТГ нь БХГ-ний англи болон монгол хэл дээрх эх хувийг байгууллагын архивын баримтын байнгын хадгалалтад зохих ёсоор аваагүй байна.

Мөн гэрээ байгуулах үед хүчин төгөлдөр үйлчилж байсан БНМАУ-ын Газрын тосны тухай хуульд нийцэхгүй байгаа Тосон Уул XIX гэрээт талбайн БХГ-ний дараах зүйл, заалт байна. Үүнд:

БХГ-ний зүйл, заалт	1991 оны Газрын тосны тухай хууль	Тайлбар
БХГ-ний 2 дугаар зүйл. “Төлбөр (роялти) гэж Монгол Улсын Газрын хэвлийн хууль болон Газрын тосны хуулийн дагуу байгалийн дахин сэргээгдэхгүй нөөц баялгийг ашигласны төлбөрийг хэлнэ. Энэ өртгийг олборлосон нийт бүтээгдэхүүнд ногдуулж, өртөгт тосыг хуваарилахаас өмнө төлнө.”	9 дүгээр зүйл. Гэрээлэгчид ногдуулах төлбөр, татвар 1.Гэрээлэгч нь газрын тос олборлосны төлбөрийг улсад төлнө. Төлбөрийн хэмжээг Монгол Улсын Засгийн газар тогтооно.	БХГ-ний 2 дугаар зүйлийн нэр томъёоны хэсэгт “роялти” заавал төлөх нөхцөлийг тодорхой тусгаж, өртөгт тосыг хуваарилахаас өмнө түүнийг хасаж тооцох тухай заасан нь хуульд нийцэж байна.
8 дугаар зүйл. Төлбөр ба бүтээгдэхүүн 8.1 “Төлбөр (роялти) Бүтээгдэхүүний аливаа төлбөр нь ашигт тосны монголын ногдол хэсэгт багтах бөгөөд түүнийг МГТ Компани Монгол Улсын Засгийн газарт төлнө.” 8.3.а. Хуанлийн сард ногдох өртөгт тосны нийт хэмжээг хасаад үлдсэн бүх гэрээт түүхий тосыг Монгол Улсын Засгийн газар болон гэрээлэгчийн хооронд тухайн хуанлийн сард гаргасан хуваах тосны өдрийн дундаж хэмжээнд тулгуурлан дор дурдсан харьцаагаар хуваана.	10 дугаар зүйл. Бүтээгдэхүүн хуваах 1.Гэрээлэгч нь газрын тос олборлосны төлбөр болон зардлаа нөхөх хэсгийг нийт олборлолтоос хасаад үлдсэн бүтээгдэхүүнийг газрын тосны хэрэг эрхлэх байгууллагатай хуваана. Бүтээгдэхүүн хуваах хувь хэмжээг хоногт гаргаж байгаа газрын тосны хэмжээтэй уялдуулан тохиролцож газрын тосны тухай гэрээнд тодорхойлон заана.	Газрын тосны тухай хуулийн 10 дугаар зүйлд газрын тос олборлосны төлбөрийг нийт олборлолтоос эхэлж хасах, дараа нь өртөгт зардал хасах, үлдсэнийг хуваах журмыг тодорхой заасан. Гэвч БХГ-ний 8.1 ба 8.3 дахь заалтууд нь хуульд нийцэхгүй байна. Энэ тохиолдолд хуулийг давуу байдлаар хэрэглэнэ. Хэрэв хуулийг баримталбал нийт олборлосон тосноос эхлээд төлбөр, дараа нь өртөгт тосыг хасаад үлдсэнийг талуудад хуваах ёстой.

БХГ-ний 8.1-д дурдсан заалт нь 1991 оны Газрын тосны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх заалтыг зөрчсөн байна. Хэрэв ийнхүү хууль зөрчсөн тохиолдолд гэрээний тухайн зүйл, заалт хэсэгчлэн хүчин төгөлдөр бус байх үр дагавар үүснэ. Үүнд:

- Төлбөрийг эхэлж төлүүлэх эрэмбийг зөрчсөн ба энэ тохиолдолд хуулийн заалтыг баримтална.
- Гэрээнд тусгасан алдааг засаж төлбөр, өртөг нөхөлт, хуваах тосны тооцоог дараах дарааллын дагуу хийнэ.



Иймд БНМАУ-ын Газрын тосны тухай хуулийн 9 ба 10 дугаар зүйл, Тосон Уул XIX гэрээт талбайн БХГ-ний 2.2-д тусгасан “Хуваах тос”, “Төлбөр” (роялти) нэр томъёоны тодорхойлолтыг тус тус үндэслэн Тосон Уул XIX талбайн Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр тус талбайгаас олборлосон газрын тосонд 5 хувийн төлбөр /Роялти/ тооцох хууль зүйн үндэслэлтэй байна.⁵⁹

Өөрөөр хэлбэл 1993 оны 4 дүгээр сарын 26 ба 1995 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн байдлаар хүчин төгөлдөр байсан 1963 оны Иргэний хууль (1990 онд нэмэлт, өөрчлөлт орсон)-ийн 32 дугаар зүйлийн 1, 1994 оны Иргэний хууль (шинэчлэн найруулсан)-ийн 43 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-т “хууль зөрчсөн хэлцэл хүчин төгөлдөр бус байх” зохицуулалт тусгагдсан учраас БХГ-

⁵⁹ Тус аудитад олон улсын хууль, эрх зүйн шинжээчийн дүгнэлт гаргуулах тухай 2021 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн УАГ/ТШ-2021-34 тоот Зөвлөх үйлчилгээг үзүүлэх гэрээний дагуу энэхүү “Тамсаг ХХИ”, “Тосон уул XIX” талбайн бүтээгдэхүүн хуваах гэрээнүүд хууль тогтоомжид нийцэж буй талаар шинжээч Т.Мэндсайхан /хууль зүйн ухааны доктор/ ахалсан хуулийн багийн дүгнэсэн хууль зүйн дүгнэлтийг ашиглав.

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж буй Петрожайна Дачин Тамсаг ХХК-ийн 2014-2018 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийсэн аудитын тайлан

ний хууль зөрчсөн зүйл, заалт байвал анхнаасаа хүчин төгөлдөр бус болох ба хуулийн зохицуулалтыг заавал дагаж мөрдөнө.

Иймд Тосон Уул XIX гэрээт талбайн БХГ-ний хувьд төлбөр роялтийг тооцохгүй байгаа нь Газрын тосны тухай хуультай нийцэхгүй байна. Харин Тамсаг ХХИ гэрээт талбайн БХГ-ний хувьд төлбөр роялтийг тооцож байна.

Газрын тосны тухай хууль /шинэчилсэн найруулга/-аар бүтээгдэхүүн хуваалтыг нийт олборлолтын тоо хэмжээнээс нөөц ашигласны төлбөрийг хасаад үлдсэн тосны 40 хувиар ӨНЗ-ыг хасаад, үлдсэн тосыг хуваахаар зохицуулсан байна.

БНМАУ-ын Газрын тосны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1-т “Гэрээлэгч нь газрын тос олборлосны төлбөр болон зардлаа нөхөх хэсгийг нийт олборлолтоос хасаад үлдсэн бүтээгдэхүүнийг газрын тосны хэрэг эрхлэх байгууллагатай хуваана” гэж зааснаас үзэхэд дараах ойлголтын зөрүү үүсэж байна. Тухайлбал:

Газрын тосны шинж чанараас хамаарч газрын хэвлийгээс нийт олборлосон хэмжээнээс бүтээгдэхүүн хуваах тооцоолол хийх боломжгүй байна.

Газрын хэвлийгээс газрын тос дангаар гардаггүй, тодруулбал олборлолтын цооногоос тос, ус, хий, механик хольц гэсэн бүрэлдэхүүнтэй холимог шингэн гардаг. Тиймээс энэхүү олборлосон шингэнийг ялгах зорилгоор олборлолтын нэгдсэн байгууламж /ОНБ/-ийг ашиглаж, гурван фазын сеператорын тусламжтайгаар олборлосон шингэнээс тос, хий, усыг ялган авдаг. Ялган авсан газрын тосыг 7000 м³ багтаамжтай тос хадгалах саванд хуримтлуулдаг бол ялгасан хийг хийн зуух болон генераторт шатааж дулаан эрчим хүч гарган авч үйлдвэрлэлийн хэрэгцээнд, ялган авсан усыг цэвэршүүлж, давхаргын даралтыг нэмэгдүүлэх зорилгоор ус шахалтын үйл ажиллагаанд ашигладаг бөгөөд ОНБ-ийн техник, технологийн дамжлага нь бүтэн цикл байдлаар явагддаг байна.⁶⁰

Өөрөөр хэлбэл, газрын хэвлийгээс гаргасан нийт олборлолтын хэмжээнээс бус, ОНБ-ийн техник, технологийн дамжлагаар ялгасан хуримтлуулсан тосны экспортлохоор ачсан түүхий тосны хэмжээнээс МУЗГ газрын тосоо ашиглах тохиолдолд бүтээгдэхүүн хуваалтыг тооцоолж болохоор байна.

Монгол Улс газрын тосоо ашиглах боломжгүй байгаа өнөөгийн нөхцөлд түүхий тосны борлуулалтын орлогоос борлуулалттай холбоотой гарсан зардлыг хассан дүнгээс бүтээгдэхүүн хуваах тооцооллыг хийж байна.

Газрын тосны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 7 дугаар зүйлийн 7.1.6⁶¹, 11 дүгээр зүйлийн 11.2.4⁶² -т Монгол Улсад газрын тос боловсруулах үйлдвэр барьсан тохиолдолд гэрээлэгчид ногдох газрын тос болон өртөгт газрын тосыг тэргүүн ээлжинд, олон улсын зах зээлийн үнэ, нөхцөлөөр худалдаж авах давуу эрхийг МУЗГ-т олгох тухай зохицуулсан.

Цаашид БХГ-ний дагуу олборлосон гэрээт түүхий тосыг дотоодын зах зээлд борлуулах, нийлүүлэх талаар тодорхой эрх зүйн зохицуулалтгүй байна.

Мөн БХГ-ний 17.2 дэх заалт, Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.6 дахь заалттай, БХГ-ний С хавсралтын 2 дугаар зүйлийн “О” дахь заалт нь Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.6-д заасантай тус тус зөрчилдөж байна. Хүснэгтээр харуулбал:

БХГ-ний заалт	Бодит нөхцөл байдал	Газрын тосны тухай хууль
БХГ-ний 17 дугаар зүйлийн 17.2-д “Гэрээлэгч нь Монгол Улсын хилийн чанадад гадаадын банкуудад аливаа валютаар данс нээх, хадгалах, хянах, гүйлгээнд ашиглах, мөн эдгээр дансыг бүрэн хяналтандаа байлгах, ийм дансанд байгаа мөнгөн хөрөнгөө чөлөөтэй ашиглах болон гадаадад байлгах эрхтэй”	(Hong Kong)-ын Bank of China банкаар Хөрөнгө оруулалт, борлуулалтын орлоготой холбоотой нийт 501.9 сая ам.долларын гүйлгээ хийсэн байна.	11.2.6-д “Хөрөнгө оруулалт, борлуулалтын орлоготой холбоотой гүйлгээг Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэх бөгөөд уг гүйлгээг санхүүгийн тайланд ил тод, нээлттэй бүрэн тусгах”

⁶⁰ АМГТГ-ын газрын тосны ашиглалтын хэлтсийн газрын тосны олборлолт, экспортын тухай товч мэдээллээс

⁶¹ Монгол Улсад газрын тос боловсруулах үйлдвэр барьсан тохиолдолд гэрээлэгчид ногдох газрын тос болон өртөгт газрын тосыг тэргүүн ээлжинд, зах зээлийн үнээр худалдаж авах давуу эрхийг эдлэх;

⁶² Засгийн газар энэ хуулийн 7.1.6-д заасан давуу эрх эдлэх тохиолдолд бүтээгдэхүүнээ олон улсын зах зээлийн үнэ, нөхцөлөөр нийлүүлэх;

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж буй Петрожайна Дачин Тамсаг ХХК-ийн 2014-2018 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийсэн аудитын тайлан

БХГ-ний С хавсралтын 2 дугаар зүйлийн О-д “Эх компанийн захиргааны нэмэгдэл зардлыг “Гэрээний дагуу газрын тостой холбогдсон үйл ажиллагааны явцад Монгол Улсын хилийн чанадад гэрээлэгчийн эх компанийн (үүний дотор хувь нийлүүлэгч багтана) ажиллагсдын гүйцэтгэх ажил үйлчилгээ болон конторын ажилд хамаарах захиргааны нэмэгдэл зардал нь газрын тостой холбоотой гэрээлэгчийн жилийн зардлын 10 хувь байна”	БХГ-ний С хавсралтын 2 дугаар зүйлийн О-д зааснаар Эх компанийн захиргааны нэмэгдэл зардлыг 10 хувиар тооцож байна.	11.1.6-д “гэрээлэгчийн захиргааны зардал нь тухайн жилийн өртөг нөхөх зардлын тав хүртэл хувь байх”
БХГ-ний 10 дугаар зүйлийн 10.4.6 “Гэрээлэгч нь гэрээт талбайн хүрээнд байгаа талбайн хувьд газрын түрээсийг 1991 оны 7 дугаар сарын 05-нд хүчин төгөлдөр болсон “Монгол Улсын Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журам”-ын хавсралт 3-ын дагуу газрын түрээс төлнө”	Тосон Уул XIX, Тамсаг ХХI талбайн дэнчинг ГТГ-ын Төрийн банкны дансанд тушаасан байна.	30.4. Ашиглалтын тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр нь нэг хавтгай дөрвөлжин километр тутамд 100 америк доллартой тэнцэх хэмжээний төгрөг байна.

б. Бүтээгдэхүүн хуваах гэрээний зарим заалт, Монгол Улсын бусад хууль тогтоомжтой нийцэхгүй байна

Гэрээний талууд харилцан тохиролцож, БХГ-г Газрын тосны хуульд нийцүүлэн шинэчлээгүйгээс шийдвэрлээгүй олон асуудал үүсэж, бусад хууль тогтоомжтой зөрчилдөж байна.

БХГ-ний 10 дугаар зүйлийн 10.4.ж-д “Гэрээлэгчийн болон оролцон гүйцэтгэгчийн гадаадын ажиллагсад нь Монгол Улсын Засгийн газар, тухайлбал түүний аль нэг улс төрийн байгууллагаас ногдуулах орлогын бүх татвар, нийгмийн даатгалаас чөлөөлөгдөнө” гэж заасан нь дараах хууль тогтоомжтой зөрчилдөж байна. Үүнд:

1. БНХАУ-аас авч ажиллуулсан 2014 онд 169, 2015 онд 180, 2016 онд 185, 2017 онд 120, 2018 онд 118 гадаад ажилтанд олгосон цалин, урамшууллагаас нийт 2.0 сая ам.долларын нийгмийн даатгалын шимтгэлийг суутган аваагүй, ажил олгогчоос төлөх 4.0 сая ам.доллар нийт 6.0 сая ам.долларыг Нийгмийн даатгалын санд төвлөрүүлээгүй. Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2⁶³, 16 дугаар зүйлийн 16.1⁶⁴, 16.3⁶⁵, 17 дугаар зүйлийн 17.1.1⁶⁶, 32 дугаар зүйлийн 32.1.1⁶⁷, 32.1.2⁶⁸ дахь хэсэгт заасантай тус тус нийцэхгүй байна.
2. Дээрх ажилтнуудад олгосон цалин, урамшууллагаас 2014-2018 онд нийт 2.9 сая ам.долларын хувь хүний орлогын албан татварыг суутган авч төсөвт төвлөрүүлээгүй.

Энэ нь тухайн үед хүчин төгөлдөр үйлчилж байсан Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1⁶⁹-д заасантай нийцэхгүй байна.

Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.8-д “*ижил төрлийн ажил хөдөлмөр эрхлэгч гадаад, дотоодын ажилтны цалин, урамшууллыг тэгш тогтоох, түүнчлэн ажилтны хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах*” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, цалин хөлс тогтоолтод гэрээний нэг талаас буюу газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас ямар нэгэн оролцоо байхгүй байна. 2015 онд 14 мэргэжлийн 131 хятад, монгол

⁶³2. Нийгмийн даатгалд дор дурдсан ажилтан албан журмаар даатгуулна: 2/Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн нэгж, гадаад орны дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагад ажиллаж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн;

⁶⁴ 1. Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагчийн болон ажил олгогчийн тухайн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын төрөл бүрээр энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр сар бүр тооцож, тухайн сард нь багтаан нийгмийн даатгалын сангийн дансанд шилжүүлнэ.

⁶⁵ 3. Ажил олгогч нь тухайн сарын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг дараа сарын 05-ны өдрийн дотор нийгмийн даатгалын байгууллагад ирүүлэх бөгөөд энэ хугацаа долоо хоног бүрийн амралт, нийтээр амрах баярын өдөртэй давхцавал дараагийн ажлын өдөр тайлагнана.

⁶⁶ 1. Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ: 1/хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх;

⁶⁷ 1. Дараахь хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод нийгмийн даатгалын шимтгэл ногдуулна: 1/Хөдөлмөрийн тухай хуулийн 83.5 дахь хэсэг, 101 дүгээр зүйлд заасан цалин хөлс, 113, 114, 115, 116, 117 дугаар зүйлд заасан олговор;

⁶⁸ 2/Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээгээр тохирсон хөлс;

⁶⁹ 8 дугаар зүйлийн 8.1.1. цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого. 26 дугаар зүйлийн 26.3. Суутгагч нь албан татвар төлөгчийн орлогоос суутган авсан албан татварыг энэ хуулийн 26.1.6-д зааснаас бусад тохиолдолд дараа сарын 10-ны өдрийн дотор холбогдох төсөвт шилжүүлнэ.

ажилтныг хамруулан, ижил ажлын байранд авсан цалин хөлсийг харьцуулж үзэхэд монгол ажилчдын цалин 27-70 хувиар бага байна.

Петрожайна Дачин Тамсаг ХХК нь Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайн газрын тостой холбогдсон зарим үйл ажиллагааг туслан гүйцэтгэгч компаниудаар гүйцэтгүүлдэг. Тухайлбал: дэд станц, цахилгаан дамжуулах агаарын шугам, дизель генератор болон хийн генераторын ашиглалт, зам, тээвэр, цооног, өрөмдлөг хийх, бүтээн байгуулалт, засвар үйлчилгээ зэрэг ажлуудыг гүйцэтгүүлэхээр 2014 онд 28, 2015 онд 29 нэр бүхий хятад компанитай гэрээ байгуулан ажилласан байна.

Дээрх Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайд байрлан үйл ажиллагаа явуулдаг компаниудад тавих хяналт хангалтгүй байгаа нь Монгол Улсад мөрдөж буй хуулийн этгээдийн, тусгай зөвшөөрлийн болон санхүү, татварын хуулиуд хэрэгжихгүй байх нөхцөл бүрдсэн байна.

Петрожайна Дачин Тамсаг ХХК Олон улсын худалдааны нөхцөл (Incoterms)-ийн дагуу бараа материалыг агуулахдаа хүлээн авч байгаа учир гаалийн мэдүүлгийг бэлтгэн нийлүүлэгч тал хариуцна гэж тайлбарлан гаалийн мэдүүлгийг бүрдүүлээгүй нь Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1⁷⁰-д заасантай нийцэхгүй байна.

Өөрөөр хэлбэл, тухайн гаалийн татвараас чөлөөлөх барааг гэрээний дагуу ямар этгээд /БХГ-ний гэрээлэгч эсхүл туслан гүйцэтгэгч/-ийн аль нь барааг гаалийн хилээр оруулж ирсэн байна, тухайн этгээд гаалийн мэдүүлгийг бөглөж, хадгалж болно. Цаашид БХГ-ний дагуу гаалийн татвараас чөлөөлөгдсөн барааны мэдээлэл болох бараа нийлүүлэх гэрээ, гаалийн мэдүүлгийг авч, ӨНЗ-ын анхан шатны баримтаар хадгалж байх үүргийг гэрээлэгч талд даалгах шаардлагатай байна.

в. Хууль тогтоомж БХГ-ээр зохицуулахаар заасан зарим заалт огт хэрэгжихгүй байна

1. Гэрээлэгч тусгай зөвшөөрөлтэй талбайд хийж байгаа газрын тостой холбогдсон бүх үйл ажиллагааг НББ-ийн тухай хуулийн дагуу бүртгэлд бүрэн тусгаж, тайлагнахгүй байна.


Бүтээгдэхүүн хуваах гэрээний 13 дугаар зүйл.	
Нягтлан бодох бүртгэл	
13.1	Гэрээлэгч нь газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд хамаарах нягтлан бодох бүртгэлийг “С” Хавсралтад заасан тооцооны журам болон олон улсын газрын тосны үйлдвэрлэлд хэвшсэн нягтлан бодох бүртгэлийн нийтлэг зарчмуудын дагуу хөтөлнө.
13.2	Гэрээлэгч нь Монгол Улсад өөрийн төлөөлөгчийн газраа нээх хүртэл нягтлан бодох эдгээр бүртгэл, тайланг Засгийн газрын төлөөлөгчид гаргаж өгч байна. Гэрээлэгч Монголд төлөөлөгчийн газраа нээсний дараа нягтлан бодох бүртгэлийн хувийг төлөөлөгчийн газартаа байлгах бөгөөд Засгийн газрын төлөөлөгч нь түүнтэй дуртай цагтаа танилцах эрхтэй. Гэрээлэгч нь нягтлан бодох бүртгэлийн тайлан мэдээг нягтлан бодох бүртгэлийн журмын дагуу Засгийн газрын төлөөлөгчид улирал тутам гаргаж өгнө.
Газрын тосны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 36 дугаар зүйл.	
36.2.	Гэрээлэгч нь тусгай зөвшөөрөлтэй талбайд хийж байгаа газрын тостой холбогдсон бүх үйл ажиллагааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаж, тайлагнана.
Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйл.	
14.1	Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын ААНБ-ын төлөөний газар НББ хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.

2. Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.9-д “байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ бүрэн гүйцэд биелүүлэх, хайгуул, ашиглалтын барилга байгууламжийг татан буулгах баталгаа болгон тухайн жилийн хайгуулын ажлын хөрөнгө оруулалтын гурван хувь, ашиглалтын үед гэрээлэгчид ногдох ашигт газрын тосны нэг хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгийг жил бүр төлөвлөгөө батлагдсанаас хойш 60 хоногийн дотор Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг банкны эскроу дансанд байршуулах” гэсэн заалт хэрэгжээгүй байна.



⁷⁰ Гаалийн нутаг дэвсгэрт оруулах, эсхүл түүнээс гаргах бараанд гаалийн болон бусад татвар ногдуулах бөгөөд энэ заалт нь гаалийн болон бусад татвараас чөлөөлөгдөх бараанд нэгэн адил хамаарна”, 38 дугаар зүйлд гаалийн татвараас чөлөөлөгдөх барааг тусгасан бөгөөд түүний 38.1.16-д “гэрээлэгч болон туслан гүйцэтгэгч нь газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд зориулан хайгуулын нийт хугацаанд болон ашиглалтын эхний таван жилийн хугацаанд импортолсон тусгай зориулалтын машин, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, тоноглол, түүхий эд, материал, химийн болон тэсрэх бодис, сэлбэг хэрэгсэл

г. Монгол Улсын холбогдох Төрийн байгууллагуудаас хяналтыг хэрэгжүүлж, хууль тогтоомж зөрчиж байгаа асуудлыг шалгаж, тодорхой арга хэмжээ авч байгаа боловч үр дүн гарахгүй байна

1. Бүтээгдэхүүн хуваах гэрээний 10 дугаар зүйлийн 10.4-т “Гэрээлэгч нь түүний дотор хувь нийлүүлэгч болон хувьцаа эзэмшигчид, түншүүд болон бусад хүү эзэмшигчид энэ гэрээ хүчин төгөлдөр байх хугацаанд 10.2-т заасан урамшуулал, энэхүү 10.4-т заасан орлон төлөх орлогын татвар, Засгийн газрын байгууллагуудаас жинхэнэ үзүүлсэн үйлчилгээний ердийн хөлсийг төлөх бөгөөд харин орлогын татвар болон бусад бүх татвар төлөхөөс чөлөөлөгдөнө” гэсэн заалттай холбоотой татварын маргаан шийдэгдээгүй байна. Үүнд:



2. Бүтээгдэхүүн хуваах гэрээний 10 дугаар зүйлийн 10.4-ж-д “Гэрээлэгчийн болон орлогын гүйцэтгэгчийн гадаадын ажиллагсад нь Монгол Улсын Засгийн газар, тухайлбал түүний аль нэг улс төрийн байгууллагаас ногдуулж, орлогын бүх татвар, нийгмийн даатгалаас чөлөөлөгдөнө” гэсэн заалттай холбоотой нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн маргааныг шүүхээр шийдвэрлүүлсэн байна. Үүнд:



3. Дорнод аймгийн Төрийн аудитын газраас 2016, 2020 онд “Гадаадаас ажиллах хүч авч ажиллуулахтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилт”-д нийцлийн аудитыг гүйцэтгэж, хууль тогтоомжид заасан хувь хэмжээнээс илүү тооны гадаад ажилтан авч ажиллуулах, ажлын байрны нөхөн төлбөрөө төлөөгүй зөрчилд төлбөрийн акт тогтоосныг Петрожайна Дачин Тамсаг ХХК-аас шүүхэд өгсөн бөгөөд хянан шийдвэрлэх анхан шатны түвшинд байна.

4. Дорнод аймгийн Засаг даргын 2021 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн А/524 дүгээр захирамжаар газрын тосны Бүтээгдэхүүн хуваах гэрээт Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайд хяналт шалгалт хийх ажлын хэсгийг томилж дараах асуудлаар ажилласан байна. Үүнд:

- Дорнод аймгийн Матад, Халх гол сумдын нутаг дэвсгэрт үйлдвэрлэлийн зориулалтаар газрын доорх ус ашиглалт, байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх үйл ажиллагаа, газрын хэвлийн ашиглалт, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт;
- Тосон Уул XIX үйлдвэрлэлийн талбайгаас Бичигтийн боомт хүртэлх газрын тосны тээвэрлэлтийн автозамын Дорнод аймаг дахь хэсэг, Тамсаг XXI талбайгаас Баянхошуу боомт хүртэлх түүхий тос тээвэрлэлтийн автозам ашиглалтын байдал, хөдөлгөөний аюулгүй байдал;
- “Ашигт малтмал, газрын тосны газар, Дорнод аймгийн Засаг дарга, Петрожайна Дачин Тамсаг ХХК хоорондын байгуулсан гурван талт хэлцэл”-ийн биелэлтэд Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай, Газрын тосны тухай, Газрын тухай, Газрын хэвлийн тухай, Авто замын тухай, Усны тухай хууль болон холбогдох бусад дүрэм журам, норм, стандарт хангагдаж байгаа эсэх.

Эдгээр асуудлаарх хяналт шалгалтын дүн, ажлын хэсгийн тайланг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж ажилласан байна.

Аудитаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад Тосон Уул XIX, Тамсаг XXI гэрээт талбайн талаар байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх, АМГТГ-т нийгмийн даатгалын шимтгэл болон хувь хүний орлогын албан татвартай холбоотой тооцооллыг дахин хийж, холбогдох байгууллагуудаар баталгаажуулах, цаашид хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах албан шаардлага тус тус хүргүүлээ.

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж буй Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн 2014-2018 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийсэн аудитын тайлан

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

ПЕТРОЧАЙНА ДАЧИН ТАМСАГ ХХК

14200 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,
Ж.Самбуугийн гудамж-32
Блюмон төв 10 давхар
Утас: (976)-7710-2777, Факс (976)-7712-2777,
И-мэйл: ptdmdatamo@gmail.com

2022.07.08 № 22/5-696
танай _____ № _____

Хариу хүргүүлэх тухай,

Та бүхний 2014-2018 оны Тамсагийн сав газрын газрын тосны хайгуул олборлолтын төслийн ажилд хийсэн аудитын хяналт шалгалтын ажил нягт нямбай болсоныг тэмдэглэн хэлэх нь зүйтэй. Бид танай ирүүлсэн 50 хуудас бүхий 2014-2018 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж хариуг үүгээр хүргүүлж байгааг хүлээн авна уу.

Бид танай аудитын ажилд хүндэтгэлтэй хандаж бүх талаар хамтран ажиллаж ирлээ. Та бүхэн манай хариутай танилцаж үзээд БХГ-ний зүйл заалтуудаа мөрдөн ажиллаж байгааг ойлгож, нааштай хариу өгнө хэмээн найдаж байна.

Та бүхнийг гүнээ хүндэтгэсэн,

САНХҮҮ ХЭЛТСИЙН ДАРГА



ГЭ ЮҮФЭНГ

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж буй Петрожайна Дачин Тамсаг ХХК-ийн 2014-2018 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийсэн аудитын тайлан

Петрожайна Дачин Тамсаг ХХК-аас ирүүлсэн санал, тайлбар

№	Ирүүлсэн саналын товч утга	Хариу тайлбар
1	Дүгнэлт 1, 2-т. А) Манай компани нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 1996 оны 8 тоот зөвлөмж, МУЗГ-ын 1993 оны 07 сарын 23-ны өдрийн 253, 1996 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 144 дүгээр тогтоолуудаар тус тус батламжилсан БХГ-ний гэрээлэгч тал юм. БХГ-г баримтлан Тамсагийн төслийг явуулж, МУЗГ-т ногдох хувийг бүрэн төлж ирсэн. Иймд БХГ нь хүчин төгөлдөр болно. Б) Монгол Улсын Иргэний хуулийн 5.2-т “Шинээр баталсан хууль тогтоомж нь гэрээний нэг буюу хоёр талын эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулахаар бол гэрээний нөхцөл хүчин төгөлдөр байна”, 5.3-т “Гэрээний талууд харилцан хүлээн зөвшөөрсөн тохиолдолд өмнө үйлчилж байсан хууль тогтоомжоос илүү тааламжтай нөхцөл олгож байгаа шинээр баталсан хууль тогтоомжийг хэрэглэж болно” гэж тус тус заасан байна. В) Гэрээг байгуулах болон өөрчилж байгуулах нь талууд сайн дурын үндсэн дээр, өөр өөрийн хүсэл сонирхлыг илэрхийлсэн нөхцөлд хийгдсэн талуудын нэгдсэн тохиролцоо байна. Талууд 2014 оноос эхлэн 3 удаагийн хэлэлцээр хийсэн ба гэрээг шинэчлэх ажил зогссон гол шалтгаан нь талууд эхнээсээ л нэгдсэн саналд хүрээгүйгээс болсон.	Гэрээлэгч “Тосон Уул XIX, Тамсаг XXI гэрээт талбайн БХГ-г шинэчлэх асуудлаар газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай харилцан зөвшилцөлд хүрээгүй талаар өөрийн байр суурийг илэрхийлсэн тайлбар ирүүлсэн нь дүгнэлт 1, 2-той зарчмын зөрүүгүй, саналгүй гэж үзэв.
2	Дүгнэлт 3-т. А) ҮАГ-аас тооцоолсон газрын тосны хэмжээ, борлуулалтын орлого нь харьцангуй зөрүүтэй байгаа нь хорогдол тооцоогүй, компани нь сарын борлуулалтыг дараа сард бүртгэдэг, мөн компани нь санхүүгийн бүртгэлийг үндэслэл болгодог зэргээс шалтгаалсан байна. Б) ӨНЗ-ын 2015 оны дүн зөрүүтэй байна.	А) Аудитаар экспортолсон газрын тосны хэмжээ, борлуулалтын орлогыг баталгаажуулахдаа Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон Гэрээлэгч хооронд жил бүр тооцоо нийлж, баталгаажуулсан протоколууд дахь дүнг үндэслэсэн болно. Тус протоколуудад хорогдол тооцох болон хувь хэмжээний талаар тусгаагүй тул аудитын тооцоололд оруулаагүй болно. Б) Гэрээлэгчийн 2015 оны ӨНЗ-ын тайлангийн дүнд залруулга хийв.
3	Дүгнэлт 4, 5-д. А) Тосон Уул XIX талбайгаас олборлосон тосонд роялти төлөх тухайд ҮАГ буруу ойлголттой байна. БХГ-ний 8.1 заасны дагуу Тосон Уул XIX талбайн роялти нь Монгол Улсад төлж буй газрын тосны орлогод багтсан тул Монголын газрын тос компаниас роялтийг Засгийн газарт төлдөг.	А) Тосон Уул XIX талбайд байгалийн дахин сэргээгдэхгүй нөөц баялгийг ашигласны төлбөр /роялти/ тооцож аваагүй нь БХГ байгуулах үед мөрдөж байсан БНМАУ-ын Газрын тосны тухай хуулийн 9.1, 10.1 дүгээр зүйл, БХГ-ний 2.2 дахь заалтыг зөрчсөн тул аудитаар 2014-2018 онд нийт 46.3 сая ам.долларын роялтийг нөхөн тооцож баталгаажуулсан.
4	Дүгнэлт 6-д. А) Экспортолсон тосны хэмжээг 0.2 сая баррель буюу 8.9 сая ам.доллараар дутуу тооцоолсон нөхцөл байхгүй. Аудитын тайланд тусгасан экспортолсон тосны дүнд 0.66 хувийн технологийн хорогдол /тээвэрлэлтийн хорогдол, ачилт буулгалтын цэгийн тоо, усны агууламж, нягт зэрэг зөвшөөрөгдөх/-ыг тооцоогүй байна. Иймд манай компани Монгол талаас өгсөн бүх тооцооллын тоон мэдээ зөв биш гэж үзэж байна. Компанийн тооцооллоор 2014-2018 онд 34.6 сая баррель газрын тос борлуулж, 1,914.8 сая ам.долларын орлого олсон. Б) Борлуулалтын зардалд 29.5 сая, тээврийн зардалд 206.7 сая ам.доллар зарцуулсан. В) МУЗГ-т 436.8 сая ам.доллар ногдсон.	А) Аудитаар экспортолсон газрын тосны хэмжээг баталгаажуулахдаа Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон Гэрээлэгч хооронд жил бүр тооцоо нийлж, баталгаажуулсан экспортолсон тосны хэмжээг үндэслэсэн болно. Тус протоколуудад хорогдол тооцох болон хувь хэмжээний талаар тусгаагүй тул аудитын тооцоололд оруулаагүй болно. Тайлангийн 8, 9 дүгээр хуудас. Б) Аудитаар газрын тос борлуулахтай холбоотой гарсан зардлыг 29.5 сая, тээврийн зардлыг 208.1 сая ам.доллараар баталгаажуулсан болно. Тайлангийн 10, 11 хуудас. В) Гэрээлэгчийн тайлангаар МУЗГ-т 436.3 сая ам.доллар ногдуулсан. Аудитаар Тосон Уул XIX талбайд 46.5 сая ам.долларын роялти нөхөн

Г) Аудитаар ӨНЗ-аас 58.8 сая ам.доллар хассан. Үүнээс дараах зардлуудыг ӨНЗ-д оруулах, дахин анхаарч үзэх саналтай байна. Үүнд: - 2015 оны төсөв, хөтөлбөрт тусгаагүй удирдлагын 10 хувийн буюу 33.5 сая ам.долларын зардлыг төсөв, төлөвлөгөөнд тусгаагүй ч гэрээлэгч талуудын 2015 онд байгуулсан жилийн уулзалтын протоколд тусгасан. Тус протоколын 19-р зүйлд “Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулга болон БХГ-д заасан удирдлагын зардлыг тооцох хувь хэмжээ нь харилцан өөр байгаа нь маргаантай тул 2015 оны төлөвлөгөө, төсөвт тус зардлыг оруулж тооцохгүй бөгөөд энэхүү асуудал шийдвэрлэгдсэний дараа төсвийн тодотголд тооцож оруулахаар тохиролцов” гэж заасан, мөн дараагийн онуудад удирдлагын зардлыг тусгаж батлуулсан. Иймд БХГ-ний дагуу 2015 оны удирдлагын зардлыг 10 хувиар тооцох ёстой гэж үзэж байгаа тул харгалзан үзнэ үү. - Түүхий тосны борлуулалтын чухал дамжлага хэсэгт буюу ӨМӨЗО-ны Рашаантад ажилладаг, тос буулгах цэг дээр дээж авах, хэмжилт хийх, лабораторийн шинжилгээ хийх зэрэг ажлуудыг голчлон хийдэг ажилчдын 2.6 сая ам.долларын цалинг ӨНЗ-д оруулах; - 2014-2015 онд 10.0 сая ам.долларын үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг ашиглаж эхлээгүй байсан боловч дараа онуудад ӨНЗ-д оруулсан тул нөхцөл байдлыг харгалзан үзэж ӨНЗ-д оруулах; - Дээрх нөхцөл байдлыг харгалзан үзэж удирдлагын зардлыг 1.3 сая ам.доллароор хассаныг 1.1 сая ам.доллароор хасах.	тооцсон, борлуулалтын зардлыг 1.5 сая ам.доллароор хассан зэргээс шалтгаалан МУЗГ-т 466.7 сая ам.доллар ногдуулан баталгаажуулсан болно. Тайлангийн 16, 17 хуудас. Г) Дараах үндэслэлээр гэрээлэгчээс ирүүлсэн саналыг хүлээн авах боломжгүй байна. Үүнд: - Газрын тосны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ын 11 дүгээр зүйлийн 11.2.3-д “жилийн төлөвлөгөө, төсвийг төрийн захиргааны байгууллагаар батлуулж, хэрэгжүүлэх”, БХГ батлах үед мөрдөгдөж байсан ЗГ-ын 1991 оны 204-р тогтоолоор баталсан “БНМАУ-ын Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журам”-ын 6 дугаар зүйлийн 6 дахь заалтыг тус тус зөрчсөн тул ӨНЗ-аас хассан. - БХГ-ний “С” хавсралтаар баталсан Тооцооны журмын 2 дугаар зүйлийн 2.1.а.1-д “Энэ гэрээний дагуу төрөл бүрийн үйл ажиллагаанд тогтмол буюу ажлын бүрэн цагаар ажиллахаар томилогдсон буюу оролцсон ажиллагсдын цалин, хөлс болон дээрх үйл ажиллагаанд түр хугацаагаар буюу ажлын бүрэн бус цагаар ажиллахаар томилогдсон буюу оролцсон ажиллагсдын цалин хөлсний зохих хувь хэмжээ. Дээрхийг үл харгалзан тайлбарлах үүднээс, энэ зүйлийн 2.1.а.1-д заасан ажиллагсдын цалин, хөлсийг дээрх ажиллагсад нь Монгол дахь ийм үйл ажиллагаанд томилогдсон буюу оролцсон, эсвэл Монгол Улсаас ирэх, буцах хүрээнд л энэхүү 2.1.а.1-д заасны дагуу нөхөж авна” гэж заасан тул хилийн чанадад ажиллагсдын цалинг ӨНЗ-аас хасаж баталгаажуулсан. - Аудитын хугацаанд гэрээлэгчээс ӨНЗ-ын тайланд залруулга хийгээгүй, зохих баримтуудыг ирүүлээгүй бөгөөд дараагийн тайлант хугацаанд нөхөн залруулж тайлагнах боломжтой юм. - ӨНЗ-аас хассан дүнг үндэслэн Удирдлагын зардлыг 10 хувиар тооцоолсон болно. Хүснэгт 8, 9.
5 Дүгнэлт 7-д. Тосон Уул XIX талбайн борлуулсан газрын тосонд роялти тооцсон, борлуулсан газрын тосонд технологийн 0.66 хувийн хорогдол тооцоолоогүй тул, Монголын талаас гаргаж буй бүх тооцоолол буруу гэж үзэж байна.	Гэрээлэгчийн тайлангаар МУЗГ-т 436.3 сая ам.доллар ногдуулсан. Аудитаар Тосон Уул XIX талбайд 46.5 сая ам.долларын роялти нөхөн тооцсон, борлуулалтын зардлыг 1.5 сая ам.доллароор хассан зэргээс шалтгаалан МУЗГ-т 30.4 сая ам.долларыг нөхөн төлөхөөр тооцож, 466.7 сая ам.доллар ногдуулан баталгаажуулсан болно. Тайлангийн 16, 17 хуудас.
6 Дүгнэлт 8-д. Дутуу төвлөрүүлсэн гэгдэж буй дүн нь жилийн эцсийн тайлангаар таслагдсан төлбөр бөгөөд дараа оны эхэнд бүгд төлөгдсөн тул төлөгдөөгүй гэх асуудал байхгүй юм.	Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайгаас олборлож буй түүхий тосыг борлуулах асуудлаар ГТГ, Гэрээлэгч хооронд тохиролцсон 2011 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн протоколын 4 дүгээр заалтад талууд түүхий тосны борлуулалтын орлогыг сар бүр тооцоо нийлэн, МУЗГ-т ногдох орлогыг дараа сарын 25-ны өдрийн дотор шилжүүлж байхаар зохицуулсан. Аудитаар тус протоколыг мөрдөж, ажиллах зөвлөмж хүргүүлж байгаа болно.
7 Дүгнэлт 11-т. БХГ-ний 13.1-р зүйлд нягтлан бодох бүртгэлийг англи хэлээр хөтлөнө гэж заасан байдаг. Манай компани нь БХГ болон УАГ-ын шаардлагын дагуу англи, монгол хэл дээр анхан шатны баримтыг аль болох бүрдүүлэх болно.	Саналын зөрүүгүй байна.

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж буй Петровича Дачин Тамсаг ХХК-ийн 2014-2018 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийсэн аудитын тайлан



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**АШИГТ МАЛТМАЛ,
ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР**


Засгийн газрын XII байрны баруун жигүүр,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 7777-1900, 26 36 28 Факс: (976-11) 31 03 70,
Цахим шуудан: info@mgram.gov.mn,
Цахим хуудас: mgram.gov.mn

2022. 07. 07 № 1/3638.
танай 2022. 06. 24-ны № 01/1282. -т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Танай 2022 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 01/1282 дугаар албан бичгээр ирүүлсэн "Петровича Дачин Тамсаг" ХХК-ийн бүтээгдэхүүн хуваах гэрээт Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайн 2014-2018 оны хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон өртөг нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо хуваарилалтад хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т заасны дагуу аудитын тайлангийн төсөлд өгөх саналыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 12 хуудастай.

ДАРГА 

Л.БАЯРМАНДАЛ

53752855

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж буй Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн 2014-2018 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийсэн аудитын тайлан

АМГТГ-аас ирүүлсэн санал, тайлбар

№	Ирүүлсэн санал	Хариу тайлбар
1	Дүгнэлтийн 1, 2-д: Бүтээгдэхүүн хуваах гэрээг шинэчлэх ажлын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, талуудын илэрхийлсэн байр суурийн талаар нэмэлт тайлбар ирүүлсэн байна.	Энэ тайлбар нь 1, 2 дугаар дүгнэлттэй зарчмын зөрүүгүй, саналгүй байна.
2	Дүгнэлтийн 3, 4-д: Төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитаар тогтоосон баримтын шаардлага хангаагүй, баримтаар нотлогдоогүй зардлуудыг хасаж баталгаажуулсан байдалд тусгайлан саналгүй болно.	Саналгүй байна.
3	Дүгнэлтийн 5, 7-д Тосон Уул XIX талбайн БХГ-ний 8.1-т “Бүтээгдэхүүний аливаа төлбөр нь ашигт тосны монголын ногдол хэсэгт багтах бөгөөд түүнийг МГТ компани Монгол Улсын Засгийн газарт төлнө” гэж заасны дагуу АМГТГ нь Тосон Уул XIX талбайн газрын тосны хуваалтын тооцоог хийж ирсэн. Тухайн үеийн хууль журам болон БХГ-нд роялти төлбөрийг тусгайлан 5 хувь гэж заасан зохицуулалт байхгүй бөгөөд Газрын тосны шинэчилсэн найруулгаар төрийн захиргааны байгууллага гэрээлэгчтэй харилцан тохиролцож уг төлбөрийн хэмжээг тогтоохоор заасан боловч одоогийн байдлаар тохиролцож чадаагүй байна. Иймээс Тосон Уул XIX талбайн газрын тосны хуваалтын тооцоонд роялти төлбөрийг тусад нь тооцохоор хувь хэмжээ заагаагүй тул хуулийн дагуу гэрээлэгчтэй харилцан тохиролцон тогтоосны дараа ногдуулах боломжтой болно.	Тосон Уул XIX талбайн БХГ-ний 8.1-д дурдсан заалт нь 1991 оны Газрын тосны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх заалтыг зөрчсөн байна. Хэрэв ийнхүү хууль зөрчсөн тохиолдолд гэрээний тухайн зүйл, заалт хэсэгчлэн хүчин төгөлдөр бус байх үр дагавар үүсэж байна. Газрын тосны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 45 дугаар зүйлийн 45.1-т “...нөөц ашигласны төлбөр төлөхгүй байгаа гэрээний тухайд төрийн захиргааны байгууллага гэрээлэгчтэй харилцан тохиролцож уг төлбөрийн хэмжээг тогтооно” гэж заасан боловч одоогийн байдлаар гэрээлэгчтэй тохиролцож чадаагүй тул ТАБ-аас Газрын тосны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн доод хэмжээ буюу 5 хувиар тооцож авахаар шийдвэрлэсэн болно. /Дэлгэрэнгүйг тайлангийн 29 дүгээр хуудаснаас/
4	Дүгнэлтийн 6-д: Аудитаар Гэрээлэгчийн 2014-2018 оны тайлагнасан өртөг нөхөгдөх зардлаас нийт 58.8 сая ам.долларын зардлыг хассан бөгөөд тайланд бараа материалын үлдэгдлийг хассан талаар дурдаагүй байна. Иймд бараа материалын үлдэгдлийг хянуулж, өртөг нөхөгдөх зардлаас хасуулах саналтай байна.	Аудитаар дараах БХГ-ний заалт, талуудын харилцан тохиролцсон протоколыг үндэслэсэн болно. Үүнд: - Тосон Уул XIX гэрээт талбайн талаар байгуулсан БХГ болон Тамсаг ХХК гэрээт талбайн талаар байгуулсан БХГ-ний “С” хавсралтын 2.2. Тооцооны үндэс. Гэрээлэгч нь гэрээтэй холбогдох тооцооны дансыг өссөн дүнгээр хөтөлнө. Энд хэрэглэсэн “өссөн дүн” гэдэг нь тухайн зардлыг хэзээ төлснөөс үл шалтгаалан уг зардлыг цаг хугацаанд нь хамааруулан тооцохыг хэлж буй болно. - 2001.09.02-ны өдрийн протоколын Аудитын зарчим хэсгийн 4 дэх заалт. Үндсэн хөрөнгийн шинжтэй бараа материалыг түүний ашиглалтын байдалд үндэслэн ӨНЗ-д оруулах ба хараахан ашиглаж эхлээгүй байгаа бараа материалыг дараа жилд нь өртөг нөхөх зардалд оруулна. Бусад бараа материалыг тухайн материалын худалдан авсан үнийн дүнгийн дагуу өртөг нөхөх зардалд оруулах ба тухайн жилд ашиглаагүй бараа материалыг агуулахын үлдэгдэлд оруулан тооцно. АМГТГ нь дараагийн онуудын ӨНЗ-ын тайланг баталгаажуулахдаа уг асуудалтай холбоотой зохицуулалтыг тодорхой болгох шаардлагатай.

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж буй Петроцайна Дачин Тамсаг ХХК-ийн 2014-2018 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийсэн аудитын тайлан

5	Дүгнэлтийн 8-д: Газрын тосны газар /хуучин нэрээр/ болон Петроцайна Дачин Тамсаг ХХК-ийн хооронд 2011 оны 06 дугаар сарын 24-ний өдөр байгуулсан протоколд гэрээлэгч түүхий тосны борлуулалтын орлогоос Засгийн газарт ногдох орлогыг дараа сарын 25-ны өдрийн дотор ГТГ-ын дансанд шилжүүлж байхаар тусгасны дагуу Гэрээлэгч нь тухайн оны 12 сард борлуулсан тосны орлого дараа онд АМГТГ-ын дансанд шилжүүлсэн болно.	Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайгаас олборлож буй түүхий тосыг борлуулах асуудлаар ГТГ, Гэрээлэгч хооронд тохиролцсон 2011 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн протоколын 4 дүгээр заалтад талууд түүхий тосны борлуулалтын орлогыг сар бүр тооцоо нийлэн, МУЗГ-т ногдох орлогыг дараа сарын 25-ны өдрийн дотор шилжүүлж байхаар зохицуулсан. Аудитаар тус протоколыг мөрдөж, ажиллах зөвлөмж хүргүүлж байгаа болно.
6	Дүгнэлтийн 9, 10-д: Газрын тосны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 9 дүгээр зүйлийн 9.1.8-д заасны дагуу гэрээлэгчийн тухайн жилийн хөрөнгө оруулалт, зардал, нөөц ашигласны төлбөр, олборлосон болон борлуулсан газрын тосны тайланг хянаж, нэгтгэх ажлын хүрээнд холбогдох хууль журам, гэрээнд заасан хугацаа /сар, улирал, жил/-нд гэрээлэгчээр тайланг гаргуулан нэгтгэн бүртгэж байна Орд ашиглалтын үйл ажиллагаатай холбоотой ажил бүрийн ажил эхлэх, дуусгах мэдэгдэл, ажлын хөтөлбөр, ажлын үр дүнгийн тайлан зэргийг тухай бүр хянаж, хүлээн авч байгаа ба үүний үндсэн дээр газрын тостой холбоотой үйл ажиллагааны тайланг баталгаажуулж байна. Гэвч тус тайланг баталгаажуулахдаа зөвхөн ажлын үр дүн, ажлын хэмжээг баталгаажуулж байна.	Гэрээлэгчийн тухайн жилийн хөрөнгө оруулалт, зардал, нөөц ашигласны төлбөр, олборлосон болон борлуулсан газрын тосны тайлан болон орд ашиглалтын үйл ажиллагаатай холбоотой төлөвлөж, гүйцэтгэсэн ажлыг жилийн байдлаар хянаж, нэгтгэсэн дүн АМГТГ-т байгаагүй. Газрын тосны хуулиар хянаж нэгтгэх чиг үүрэг АМГТГ-т, баталгаажуулах чиг үүрэг Төрийн аудитын байгууллагад байх бөгөөд хянаж нэгтгэх, баталгаажуулах аль ч чиг үүрэг анхан шатны баримт материалд үндэслэх тул тайлбарыг хүлээж авах боломжгүй байна.
7	Дүгнэлтийн 11-д: БХГ-г Газрын тосны тухай хуульд нийцүүлэн шинэчлээгүй тул Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайн БХГ-ний 13.1-д заасны дагуу гэрээлэгч нь нягтлан бодох бүртгэлийг англи хэл дээр хөтлөн явуулж байна. Мөн БХГ-ний 13.2-д заасны дагуу зөвхөн Улаанбаатар оффисын зардлыг нягтлан бодох бүртгэлийн тайландаа тусган, тайлагнаж ирсэн. АМГТГ нь Гэрээлэгчид НББ-ийн тайландаа БХГ-т талбайн зардлыг бүрэн тусгаж тайлагнах талаар удаа дараа шаардлага тавин ирсэн.Үүний үр дүнд Гэрээлэгч нь 2021 оны сүүлийн хагас жилээс үйл ажиллагаатай холбоотой зардлаа НББ-ийн тайландаа тусган, тайлангаа холбогдох байгууллагад хүргүүлж эхэлсэн.	Энэ тайлбар нь 11 дүгээр дүгнэлттэй зарчмын зөрүүгүй, саналгүй байна.
8	Зөвлөмжийн 4, 5-д: Гэрээлэгчийн өртөг нөхөгдөх зардал болон олборлосон, борлуулсан газрын тосны тайланг сар, улирлаар тасалбар болгон анхан шатны баримттай тулган хянаж, тооцоо нийлэн баталгаажуулан нэгтгэж байх гэсэн зөвлөмжөөс МУЗГ-ын 2018 оны 5 дугаар тогтоолоор баталсан “Нөөц ашигласны төлбөр болон тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах журам”-ын 2.2, 2.3, МУЗГ-ын 2019 оны 178 дугаар тогтоолоор баталсан “Газрын тосны бүртгэл, тооцооны журам”-ын 10.1-д заасныг үндэслэн “сараар” гэдгийг хасуулах саналтай байна.	Саналыг хүлээж авч зөвлөмж хэсэг дэх “сараар” гэсэн үгийг хасав.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Аудитаар газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж буй Петрожайна Дачин Тамсаг ХХК-ийн 2014-2018 онд Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайгаас нийт экспортолсон газрын тосны хэмжээг 34.8 сая баррелиар, борлуулалтын орлогыг 1,923.8 сая, өртөг нөхөгдөх зардлыг 1,299.0 сая, ирээдүйд нөхөгдөх боломжтой зардлыг 2,100.4 сая ам.доллараар тус тус баталгаажууллаа.
2. Гэрээлэгчийн 2014-2018 онд нийт экспортолсон газрын тосны орлогоос борлуулалттай холбоотой гарсан 237.6 сая ам.доллар (12.3%)-ын зардлыг хасаж, үлдэх хэсгийн 24.3 хувь буюу 466.7 сая ам.доллар нь Монгол Улсын Засгийн газарт, 63.4 хувь буюу 1,219.5 сая ам.доллар нь гэрээлэгчид ногдож байна.
3. Мөн Тосон Уул XIX талбайгаас 2014-2018 оны газрын тосны нийт борлуулалтын орлого 925.1 сая ам.доллараас 5 хувиар тооцон 46.2 сая ам.долларын роялти нөхөн тооцож баталгаажууллаа. Энэ нь Бүтээгдэхүүн хуваах гэрээг байгуулах үед хүчин төгөлдөр үйлчилж байсан БНМАУ-ын Газрын тосны тухай хуулийн 9 ба 10 дугаар зүйл, Тосон Уул XIX гэрээт талбайн Бүтээгдэхүүн хуваах гэрээний 2.2-т тусгасныг үндэслэн Тосон Уул XIX талбайн Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр тус талбайгаас олборлосон газрын тосонд 5 хувийн төлбөр /Роялти/ тооцох хууль зүйн үндэслэлтэй байна.
4. Талууд Бүтээгдэхүүн хуваах гэрээг Газрын тосны тухай хуульд нийцүүлэх талаар харилцан зөвшилцөлд хүрээгүйгээс гэрээг шинэчлэх ажил зогсонги байдалд хүрсэн, төслийн үр ашиг буурах эрсдэлтэй байна.
5. БХГ-ний зарим зүйл, заалт татвар, нийгмийн даатгалын, Нягтлан бодох бүртгэлийн болон бусад хууль тогтоомжтой зөрчилдөж байгаагаас шалтгаалж төсөвт татвар, хураамжийг дутуу төвлөрүүлэх, тайлан мэдээг зөрүүтэй тайлагнах, төрийн байгууллагуудтай үл ойлголцол, маргаан гарах нөхцөл үүсэж байна.
6. Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу олборлосон гэрээт түүхий тосыг дотоодын зах зээлд борлуулах, нийлүүлэх талаар тодорхой эрх зүйн орчин бүрдээгүй байгаа нь үндэсний газрын тосны үйлдвэрийн үйл ажиллагааг хэвийн явуулахад уялдахгүй байх өндөр эрсдэл бүхий байна.
7. Газрын тос экспортлох үйл ажиллагааны үед гарах технологийн хорогдол тооцох аргачлал, хэмжээг гэрээлэгч талууд харилцан тохиролцож баталгаажуулаагүйгээс бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу гаргасан тайлан, тооцооллууд зөрүүтэй байна.
8. Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хуваарилсан Монгол Улсын Засгийн газарт ногдох орлогыг хугацаанд нь бүрэн төвлөрүүлээгүй, үлдэгдлийг тухай бүр тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.
9. Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гэрээлэгчтэй холбоотой бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан тайлангууд болон газрын тосны ашиглалтын үеийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг хянаж, нэгтгэх, гэрээлэгчийн жилийн ажлыг нэгтгэж дүгнэх, төлөвлөгөө төсвийн гүйцэтгэлийг харьцуулах, дүн шинжилгээ хийх үндсэн чиг үүргийн хэрэгжилт, бүтцийн нэгжүүдийн ажлын уялдаа хангалтгүй байгаа нь Газрын тосны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3, 9.1.8, 9.1.10, 9.1.11 дэх заалттай тус тус нийцэхгүй байна.
10. Петрожайна Дачин Тамсаг ХХК нь газрын тостой холбоотой үйл ажиллагааг санхүүгийн тайланд тусгаагүй, анхан шатны баримтыг болон газрын тосны борлуулалтын орлого, өртөг нөхөгдөх зардлын тайланг хятад, англи хэлээр үйлдэж байгаа нь Монгол хэлний тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Газрын тосны тухай хуулийн холбогдох заалттай тус тус нийцэхгүй байна.
11. Гэрээний талууд БХГ-ний дагуух газрын тосны болон санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг цахимжуулах, нэгдсэн цахим систем бий болгоход анхаарах шаардлагатай байна.
12. БХГ-ний дагуух үйл ажиллагаа, төсөвт төвлөрүүлэх орлого зэрэгт газрын тосны болон төсөв санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас хяналтыг бүрэн хэрэгжүүлэхгүй байна.

13. Газрын тосны ашиглалтын үеийн үйл ажиллагааны анхдагч мэдээлэл, тайлан, материалыг хүлээн авах, хянах чиг үүргийг холбогдох төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолт, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нарийвчлан тодорхой тусгах, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, ажлын гүйцэтгэл, түүний тайлагналд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны хариуцсан нэгж, албан тушаалтнуудаас тавих давхар болон дараалсан хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Монгол Улсын Ерөнхий сайдад:

1. Газрын тосны салбарт олборлолтын үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгчийн бүтээгдэхүүн хуваах гэрээний зохицуулалтыг тодорхой болгож, хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагад үүрэг чиглэл өгч, хэрэгжилтийг хангуулах;
2. Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу олборлосон гэрээт түүхий тосыг дотоодын зах зээлд борлуулах, нийлүүлэх талаар эрх зүйн орчныг бүрдүүлэх.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад:

3. Гэрээлэгчийн жилийн ажлын төлөвлөгөө, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийг хянах, нэгтгэх, тайлагнахтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;
4. Гэрээлэгчийн БХГ-ний дагуу явуулж буй үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагын /гааль, татвар, нийгмийн даатгал, нийгмийн халамж, мэргэжлийн хяналт, орон нутгийн удирдлага гэх мэт/ үйл ажиллагаа хоорондоо хэрхэн уялдаж байгаа талаар болон бүтээгдэхүүн хуваах гэрээний хууль тогтоомжийн нийцлийн судалгаа хийж, нийцэлгүй асуудлыг холбогдох байгууллагуудад танилцуулан шийдвэрлүүлэх арга хэмжээ авч байх;
5. Газрын тосны ашиглалтын үеийн үйл ажиллагааны анхдагч мэдээлэл, тайлан, материалыг хүлээн авах, хянах чиг үүргийг холбогдох төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд мэргэжлийн чиглэлээр тодорхой тусгах, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, ажлын гүйцэтгэл, тайлагналд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны хариуцсан нэгж, албан тушаалтнуудын давхар болон дараалсан хяналтын үр дүнг сайжруулах.

Ашигт малтмал, газрын тосны газрын даргад:

6. Гэрээлэгчийн жилийн болон нэмэлт төлөвлөгөө, төсвийн тооцоолол, түүний үндэслэл, өөрчлөлт оруулах шалтгааныг судалж баримтжуулах, батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу жилийн ажлыг нэгтгэж дүгнэх, өртөг нөхөх зардал болон олборлосон, борлуулсан газрын тосны тайланг улирлаар тасалбар болгон анхан шатны баримттай тулган хянаж, тооцоо нийлж, баталгаажуулан нэгтгэж байх;
7. Гэрээлэгчийн тусгай зөвшөөрөлтэй талбайд хийж байгаа газрын тостой холбоотой үйл ажиллагааны баримт бичгийг монгол хэлээр хөтлөх, санхүүгийн тайланд ил тод, нээлттэй, бүрэн тусгаж тайлагнах арга хэмжээг Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлэх;
8. Монгол Улсын Засгийн газарт хуваасан газрын тосны орлогыг Газрын тосны газар, Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн хооронд харилцан тохиролцсон 2011.06.24-ний өдрийн протоколын дагуу сар бүр тооцоо нийлэн, дараа сарын 25-ны өдрийн дотор төвлөрүүлж байх.
9. Газрын тосны салбарт БХГ-ээр үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсөв, түүний дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалт, мөн газрын тосны үйл ажиллагаа явуулахаар бэлтгэсэн материал, эд хөрөнгийн бүртгэл, тооцоог программчилж, нэгдсэн цахим систем бий болгон газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах;
10. Газрын тосны ашиглалтын үеийн үйл ажиллагааны анхдагч мэдээлэл, тайлан, материалыг хүлээн авах, хянах чиг үүргийг холбогдох төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд мэргэжлийн чиглэлээр тодорхой тусгах, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, ажлын гүйцэтгэл, тайлагналд тавих хяналтыг сайжруулах.

ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

/мянган ам.доллар, төгрөг/

д/ д	Зөрчлийн товч утга	Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Борлуулалтын орлого нэмсэн, ӨНЗ- аас хассан	Тайланд залруулга хийсэн	Нийт дүн
Нэг. Орлого, ӨНЗ баталгаажуулалт, санхүүгийн тайлагнал							
1	Тухайн үед мөрдөгдөж байсан Газрын тосны тухай хууль, журмыг зөрчин Тосон Уул XIX талбайд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулаагүй, мөн газрын тосны борлуулалтын орлого дутуу тайлагнасан, борлуулалттай холбогдон гарах зардал илүү тооцсон зэргээс шалтгаалан МУЗГ-т 30.4 сая ам.долларыг нөхөн төвлөрүүлэх	30,438.7					30,438.7
2	Улсын төсөвт төвлөрүүлэх газрын тосны орлогыг сар бүр тооцоо нийлэн, дараа сарын 25-ны өдрийн дотор төвлөрүүлээгүй			6,531.8			6,531.8
3	Өртөг нөхөгдөх зардал илүү тооцож тайлагнасан				58,829.4		58,829.4
4	Экспортолсон газрын тосны борлуулалтын орлого дутуу тооцож тайлагнасан		8,298.5		600.1		8,898.6
5	Гэрээлэгч нь тусгай зөвшөөрөлтэй талбайд хийгдэж байгаа газрын тостой холбогдсон үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлд тусгаж санхүүгийн тайлан гаргаагүй			0.0			0.0
6	Анхан шатны баримтыг зохих журмын дагуу хөтөлж, гарын үсэг тамга тэмдгээр бүрэн баталгаажуулаагүй			4,194.3			4,194.3
7	Бараа материалын үндсэн хөрөнгийн үлдэгдэлд тавих хяналтгүй, орлого авалгүй шууд зардлаар бүртгэсэн, зарим хөрөнгө, материалыг илүү дутуу дүнгээр орлого авсан			5,022.8			5,022.8
8	ӨНЗ-ын тайланд зардлын ангилал буруу тайлагнасан					5,919.0	5,919.0
Хоёр. Төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэл							
9	Гэрээгээр гүйцэтгүүлсэн хөрөнгө оруулалтын ажлын гэрээний гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй байна. Тухайлбал: ажил гүйцэтгэсний дараа гэрээ, баримт бичиг үйлдсэн, зарим баримт шаардлага хангаагүй, гэрээнд өөрчлөлт оруулсан			10,142.7			10,142.7
Гурав. Хуулийн нийцэл							
10	Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн Тосон Уул XIX, Тамсаг XXI гэрээт талбайн талаар 1993, 1995 онд байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээг Газрын тосны тухай хуульд нийцүүлэн шинэчлээгүй байна		0.0				0.0
11	Газрын тос олборлох үйл ажиллагаанд Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүй, Хятад ажилчдад олгосон цалин, хөдөлмөрийн хөлсөнд нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татвар тооцож, төсөвт шилжүүлээгүй байна		0.0				0.0
Нийт дүн /мянган ам.доллар/		30,438.7	8,298.5	25,891.7	59,429.6	5,919.0	129,977.5
Нийт дүн /мянган төгрөг		66,727,588.8	20,791,315.8	59,246,081.3	121,836,306.4	11,681,328.2	280,285,620.5

Жич: Хаалтын ханш 2014 он 1\$=1885.60₮, 2015 он 1\$=1995.98₮, 2016 он 1\$=2489.53₮, 2017 он 1\$=2427.13₮, 2018 он 1\$=2642.92₮

**Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайн Бүтээгдэхүүн хуваах гэрээ болон
Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн үйл ажиллагааны талаар товч мэдээлэл**

Гэрээлэгчийн талаар:

БНХАУ-ын Үндэсний газрын тосны корпорацийн харьяа “Дачин ойл Фийлд Лимитед” нь газрын тос, байгалийн хийн олборлолтоор улсдаа болон дэлхийд томоохонд тооцогддог, гадаад зах зээлд бие даасан үйл ажиллагаа явуулах эрх бүхий төрийн өмчит компани юм.

Тус компани нь 2005 оны 8 дугаар сард МУЗГ-ын баталсан Дорнод аймгийн Тамсагийн сав газрын XIX, XXI, XXII гэрээт талбайд газрын тосны хайгуулын болон олборлолтын үйл ажиллагаа явуулах БХГ-ний эрх, үүргийг дараах байдлаар шилжүүлэн авсан байна.

**АНУ-ын “СОКО
Интернейшнл” ХХК-ийн**


• **Кейман аралд бүртгэлтэй**
• **СОКО Тамсаг Монгол (XIX) ХХК-ийн эзэмшил хувьцааг**

**АНУ-ын Делавер хотод
бүртгэлтэй “Петрочайна Дачин
Тамсаг”-ийн**


• **Кейман аралд бүртгэлтэй**
• **Петрочайна Дачин Тамсаг Монгол (XIX) ХХК шилжүүлж, худалдаж авсан.**

БХГ-ний эрх үүргийг шилжүүлж авсан дээрх компани нь БНХАУ-ын 100 хувийн хөрөнгө оруулалттай Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийг Монгол Улсад байгуулан Дорнод аймгийн Халхгол, Матад сумдын нутагт орших Тамсагийн сав газрын Тосон Уул XIX, Тамсаг XXI, Буйр XXII талбайд бүтээгдэхүүн хуваах зарчмаар МУЗГ-тай байгуулсан гэрээний дагуу газрын тостой холбогдох үйл ажиллагаа явуулж эхэлсэн ба Буйр XXII гэрээт талбайг 2012 онд буцаасан байна.


Тосон Уул XIX гэрээт талбайн бүтээгдэхүүн хуваалт:



Тамсаг XXI гэрээт талбайн бүтээгдэхүүн хуваалт:



Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлбэл:



Гэрээлэгчийн хийсэн ажлын талаар:

Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайд 1993-2018 онд хайгуул, үнэлгээ, туршилтын олборлолт, ашиглалтын нийт 1506 цооног өрөмдөн, 7.6 мянган тууш км хоёр хэмжээст, 5.0 мянган км² гурван хэмжээст чичирхийллийн судалгаа хийсэн байна.

Хүснэгт-1. Тосон Уул XIX, Тамсаг-XXI талбайд хийсэн ажлын ерөнхий мэдээлэл

№	Хийсэн ажил, судалгаа	Талбайн нэр		Нийт
		Тамсаг XXI	Тосон Уул XIX	
1	Хайгуул, үнэлгээ, туршилтын олборлолт, ашиглалтын нийт өрөмдсөн цооног	557 цооног	949 цооног	1506 цооног
2	Хоёр хэмжээст чичирхийллийн судалгаа	3.3 мянган тууш км	4.4 мянган тууш км	7.6 мянган тууш км
3	Гурван хэмжээст чичирхийллийн судалгаа	2.7 мянган км ²	2.3 мянган км ²	5.0 мянган км ²

Петрочайна Дачин Тамсаг ХХК нь Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайд хийсэн хайгуул, үнэлгээ, туршилтын олборлолтын ажлын үр дүнд үндэслэн тус талбайн газрын тосны нөөцийг тооцоолж, дэлхийн газрын тос олборлогч ихэнх орнуудын дагаж мөрддөг газрын тосны нөөцийн тооцооны ангиллын дагуу 2008-2010 онд нийт 6 блокт “баталгаат”, “магадтай” болон “боломжит” зэрэглэлээр газрын тосны нөөцийг тооцоолон, АНУ-ын “DeGolyer and MacNaughton” (D&M) компаниар хөндлөнгийн үнэлгээ хийлгэжээ.

Газрын тосны нөөцийн талаар:

Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайн газрын тосны нөөцийн тооцооны тайланг ЭБЭХЯ-ны (хуучин нэрээр) дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн ЭБЭХ-ний сайдын тушаалаар Тамсагийн орд газрын тосны нийт баталгаат нөөцийг 306.6 сая тонн, ашиглалтын баталгаат нөөцийг 41.2 сая тонн, магадтай нөөц 19.9 сая тонн, боломжит нөөц 6.3 сая тонноор тус тус Монгол Улсын Ашигт малтмалын нөөцийн нэгдсэн санд бүртгүүлсэн байна.

Хүснэгт-2. Тамсагийн ордын газрын тосны нөөцийн мэдээлэл

/сая.тонн/

№	Газрын тосны нөөцийн тайлан	ЭБМЗ-ийн дүгнэлт	ЭБЭХС-ын тушаал	Баталгаат нөөц	Ашиглалтын баталгаат нөөц	Магадтай нөөц	Боломжит нөөц
1	Тосон Уул XIX талбайн газрын тосны нөөцийн тайлан	2010.02.04-ний 06 дугаар дүгнэлт	2010.02.18-ны 41 дүгээр тушаал	119.0	13.7	-	-
2	Тосон Уул XIX талбайн газрын тосны нөөцийн нэмэлт тайлан	2011.06.03-ны 06 дугаар дүгнэлт	2011.06.21-ний 148 дүгээр тушаал	60.1	6.5	16.8	-
Тосон Уул XIX талбайн газрын тосны нөөц				179.1	20.2	16.8	-
3	Тамсаг XXI талбайн газрын тосны нөөцийн тайлан	2012.03.02-ны 01/12 дугаар дүгнэлт	2012.05.16-ны 41 дүгээр тушаал	127.5	21.0	3.1	6.3
Тамсаг XXI талбайн газрын тосны нөөц				127.5	20.0	3.1	6.3
Тамсагийн ордын газрын тосны нийт нөөц				306.6	41.2	19.9	6.3

Ашиглалтын нөөц 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 9.0 сая тонн газрын тос

олборлож, 32.2 сая тонн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Ордын ашиглалт эхлүүлсэн талаар:

МУЗГ-ын 1991 оны 204 дүгээр тогтоолоор баталсан “БНМАУ-ын газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журам”-ын 10.2-т заасны дагуу гэрээний талууд газрын тосны ашиглалт (үйлдвэрлэлийн олборлолт) явуулах талбайн хэмжээ, хил заагийн эргэлтийн цэгүүдийн солбилцлыг тохиролцож, Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайн газрын тосны ордын ашиглалтын талбайн хэмжээг тогтоосон тухай протокол”-ыг үйлдсэн байна.

Хүснэгт-3. Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайн ерөнхий мэдээлэл

№	Ерөнхий мэдээлэл	Талбайн нэр	
		Тамсаг XXI	Тосон Уул XIX
1	Протоколын огноо	2012.06.20	2011.06.24
2	Байршил	Дорнод аймгийн Халх гол сум	Дорнод аймгийн Матад сум
3	Хайгуулын талбай	9,639.7 км ²	7,690.0 км ²
4	Ашиглалтын талбай	209.2 км ² /хайгуулын талбайн 2.2 хувь/	650 км ² /хайгуулын талбайн 8.4 хувь/

Газрын тосны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасны дагуу газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахад зориулан уурхайн эдэлбэр (ашиглалтын талбай)-ийн зөвшөөрлийг МУЗГ-ын 2012 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 154 дүгээр тогтоолоор олгосон байна.

Газрын тосны олборлолт, экспорт /2021 оны жилийн эцсийн байдлаар/:

- Тосон Уул XIX талбайн 490 цоонгог олборлолтын тоног төхөөрөмж суурилуулснаас хоногт дунджаар 315 цооногоор 996 тонн газрын тос олборлож, 27 автоцистернээр Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Бичигт хилийн боомт болон Дорнод аймгийн Халхгол сумын Баянхошуу хилийн боомтоор;
- Тамсаг XXI талбайд 311 цоонгог олборлолтын тоног төхөөрөмж суурилуулснаас хоногт дунджаар 306 цооногоор 1051 тонн газрын тос олборлож, 28 автоцистернээр Дорнод аймгийн Халхгол сумын Баянхошуу хилийн боомтоор;

Нийт Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайгаас 1998-2021 онд нийт 66.7 сая баррель буюу 9.0 сая тонн газрын тос олборлож, 63.7 сая баррель буюу 8.6 сая тонн газрын тосыг БНХАУ-д экспортолсон байна.

Газрын тосны шинж чанар, борлуулалтын талаар:

Тамсагийн ордын газрын тосны нягт дунджаар 850 кг/м³, хүхрийн агууламж 0.11 хувь байгаа нь дэлхийн газрын тосны аж үйлдвэрт мөрддөг түүхий тосны нягтын хувьд дунд зэргийн, хүхэр багатай тосонд хамаардаг байна.

Хүснэгт-4. Тамсагийн ордын газрын тосны шинж чанар

Орд	Нягт (кг/м ³)	Хүхрийн агуулга (%)	Зууралдлага (мПа.с)	Парафин (%)	Давирхай (%)	Царцах температур (°C)
Тосон Уул	836	0.06	5.75	12.48	9.6	21.6
Тамсаг	875	0.17	32.5	17.75	18.44	24

Тамсагийн ордоос олборлож буй түүхий тосыг Сингапурын бирж дээр худалддаг Платсын⁷¹ Дачин 33⁷² маркийн тосны үнээс 1.00 ам.доллороор хямд үнээр борлуулдаг.


Дэд бүтэц, бүтээн байгуулалтын ажлууд:

Газрын тосны ордыг ашиглалтад оруулах ажлын хүрээнд дараах дэд бүтэц, бүтээн байгуулалтын ажлыг хийж, ашиглалтад оруулсан гэж тайлагнасан байна. Үүнд:

Зураг-1. Ордыг ашиглах зорилгоор хийсэн бүтээн байгуулалтын ажлууд

⁷¹ “S&P Global Platts” компани буюу товчоор “Платс” /Platts/ нь 1909 оноос хойш ажилласан олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрчим хүчний мэдээллийн нэгдсэн сүлжээ байгууллага бөгөөд тухайн өдрийн үнийн мэдээллийг гаргахдаа биржүүд дээр худалдсан газрын тосны үнэ, тоо хэмжээ, компани, байгууллага зэрэг бусад холбогдох мэдээлэлд тусгай шалгуур үзүүлэлтүүдтэйгээр өөрийн гэсэн “Market-On-Close” /МОС/ аргачлал /methodology/-аар хугацааны нарийвчлалтайгаар боловсруулалт хийж зөвхөн өөрсдийн хэрэглэгчдэдээ төлбөртэйгөөр мэдээллийг түгээдэг. Дэлхийн ихэнх газрын тосны трейдэрүүд худалдааны үнийг тогтоохдоо энэ байгууллагаас зарлаж буй биржүүдийн үнийн мэдээлэлд тулгуурладаг.

⁷² “Платс”-аас зарласан Сингапурын бирж дээр худалдаалагдаж буй “Daqing” маркийн түүхий тосны спот үнэ дээр суурилж тооцдог.



Тосон Уул XIX талбайд	
2011	Хоногт 4200 тонн шингэн цэвэршүүлэх хүчин чадалтай түүхий тос цуглуулах, цэвэршүүлэх, хадгалах, ачих, буулгах олборлолтын ил байгууламж, тос хадгалах савны багтаамж нийт 28.3 мянган тонн
2013	Дорнод аймгийн Чойбалсан хотоос Тосон Уул XIX талбай хүртэл 110 кВ-ийн хүчин чадал бүхий 188.6 км Цахилгаан дамжуулах агаарын шугам
2011	Тосон Уул XIX талбайгаас Бичигтийн хилийн боомтын чиглэлд 139 км сайжруулсан хайрган зам
2019	Тосон Уул XIX талбайгаас Баянхошуу хилийн боомтын чиглэлд 210 км хатуу хучилттай авто зам
Тамсаг XXI талбайд	
2014	Хоногт 4000 тонн шингэн цэвэршүүлэх хүчин чадалтай түүхий тос цуглуулах, цэвэршүүлэх, хадгалах, ачих, буулгах олборлолтын ил байгууламж, тос хадгалах савны багтаамж нийт 28.3 мянган тонн
2016	Тосон Уул XIX талбайгаас Тамсаг XXI талбай хүртэл 110 кВ-ийн хүчин чадал бүхий 93.7 км Цахилгаан дамжуулах агаарын шугам

**Газрын тосны экспорт, борлуулалтын орлого
2014-2018 он**

ам.доллар

Үзүүлэлт	Гэрээлэгч		Аудитаар					
			нэмсэн		хассан		баталгаажуулсан	
	баррель	ам.доллар	баррель	ам.доллар	баррель	ам.доллар	баррель	ам.доллар
Тосон-Уул XIX								
2014 он	5,002,706.91	393,348,343.89	13,264.75	1,040,826.77	790,167.72		4,225,803.94	394,389,170.66
2015 он	4,413,604.49	199,185,015.81	29,268.25	1,322,454.66			4,442,872.74	200,507,470.47
2016 он	3,741,998.59	134,201,925.70	28,113.55	1,063,008.53			3,770,112.14	135,264,934.23
2017 он	3,323,345.48	158,754,820.86	20,164.83	959,407.76			3,343,510.31	159,714,228.62
2018 он	2,893,670.30	179,519,709.71	19,217.66	1,193,396.74			2,912,887.96	180,713,106.45
Дүн	19,375,325.77	1,065,009,815.97	110,029.04	5,579,094.47	790,167.72	-	18,695,187.09	1,070,588,910.44
Тамсаг XXI								
2014 он	2,267,409.69	206,045,452.76		43,925.17	2,453.59		2,264,956.10	206,089,377.93
2015 он	3,207,467.33	140,939,711.81	14,056.06	527,507.14			3,221,523.39	141,467,218.95
2016 он	3,854,156.42	140,153,628.08	25,797.72	946,305.65			3,879,954.14	141,099,933.73
2017 он	3,795,277.74	181,660,172.81	25,032.32	896,809.32			3,820,310.06	182,556,982.13
2018 он	2,929,841.68	181,143,993.19	9,454.03	904,999.23			2,939,295.71	182,048,992.42
Дүн	16,054,152.86	849,942,958.65	74,340.13	3,319,546.50	2,453.59	-	16,126,039.40	853,262,505.16
Нийт дүн	35,429,478.63	1,914,952,774.62	184,369.17	8,898,640.97	792,621.31	-	34,821,226.49	1,923,851,415.60

**Гэрээт түүхий тос борлуулахтай холбоотой гарсан зардал
2014-2018 он**

ам.доллар

Он	Үзүүлэлт	Тосон Уул XIX			Тамсаг XXI		
		Гэрээлэгчийн тайлан	Аудитаар хассан	Аудитаар баталгаажуулсан	Гэрээлэгчийн тайлан	Аудитаар хассан	Аудитаар баталгаажуулсан
2014	I.Буулгалтын зардал	945,440.40		945,440.40	509,263.21		509,263.21
	II.Хяналтын зардал	84,413.37		84,413.37	45,469.32		45,469.32
	III.Халаалтын зардал	1,785,907.82		1,785,907.82	1,451,366.76		1,451,366.76
	IV.Ус ялгалтын зардал	271,199.84	271,199.84	-	12,442.50	12,442.50	-
	V.Банкны үйлчилгээний зардал	658,445.13	658,445.13	-	154,921.32	154,921.32	-
Дүн		3,745,406.56	929,644.97	2,815,761.59	2,173,463.11	167,363.82	2,006,099.29
2015	I.Буулгалтын зардал	989,768.49		989,768.49	720,717.51		720,717.51
	II.Хяналтын зардал	88,372.22		88,372.22	64,348.64		64,348.64
	III.Халаалтын зардал	2,490,891.79		2,490,891.79	1,967,210.11		1,967,210.11
	IV.Ус ялгалтын зардал			-	267.18		267.18
	V.Банкны үйлчилгээний зардал			-	2,383.86	2,383.86	-
Дүн		3,569,032.50	-	3,569,032.50	2,754,927.30	2,383.86	2,752,543.44
2016	I.Буулгалтын зардал	842,176.48		842,176.48	868,083.10		868,083.10
	II.Хяналтын зардал	75,194.95		75,194.95	77,507.60		77,507.60
	III.Халаалтын зардал	2,384,907.87		2,384,907.87	2,464,186.78		2,464,186.78
	IV.Ус ялгалтын зардал			-	7,690.12		7,690.12
	V.Банкны үйлчилгээний зардал			-	1,798.60	1,798.60	-
Дүн		3,302,279.30	-	3,302,279.30	3,419,266.20	1,798.60	3,417,467.60
2017	I.Буулгалтын зардал	741,163.00		741,163.00	853,090.72		853,090.72
	II.Хяналтын зардал	66,175.89		66,175.89	76,169.92		76,169.92
	III.Халаалтын зардал	2,191,310.69		2,191,310.69	2,438,305.14		2,438,305.14
	IV.Ус ялгалтын зардал			-	2,113.79		2,113.79
	V.Банкны үйлчилгээний зардал	2,872.41	2,872.41	-	3,487.31	3,487.31	-
Дүн		3,001,521.99	2,872.41	2,998,649.58	3,373,166.88	3,487.31	3,369,679.57
2018	I.Буулгалтын зардал	651,540.14		651,540.14	657,923.52		657,923.52
	II.Хяналтын зардал	58,175.01		58,175.01	58,742.88		58,742.88

	III.Халаалтын зардал	1,912,712.88		1,912,712.88	1,932,023.67		1,932,023.67
	IV.Ус ялгалтын зардал			-	2,167.18		2,167.18
	V.Банкны үйлчилгээний зардал	4,071.60	4,071.60	-	3,797.12	3,797.12	-
Дүн		2,626,499.63	4,071.60	2,622,428.03	2,654,654.37	3,797.12	2,650,857.25
Нийт дүн /2014-2018 он/		16,244,739.98	936,588.98	15,308,151.00	14,375,477.86	178,830.71	14,196,647.15
	I.Буулгалтын зардал	4,170,088.51	-	4,170,088.51	3,609,078.06	-	3,609,078.06
	II.Хяналтын зардал	372,331.44	-	372,331.44	322,238.36	-	322,238.36
	III.Халаалтын зардал	10,765,731.05	-	10,765,731.05	10,253,092.46	-	10,253,092.46
	IV.Ус ялгалтын зардал	271,199.84	271,199.84	-	24,680.77	12,442.50	12,238.27
	V.Банкны үйлчилгээний зардал	665,389.14	665,389.14	-	166,388.21	166,388.21	-
Нийт дүн /2014-2018 он/		16,244,739.98	936,588.98	15,308,151.00	14,375,477.86	178,830.71	14,196,647.15

Хавсралт 4

Борлуулсан гэрээт түүхий тосны борлуулалтын тээврийн зардал

ам.доллар

Он	Тосон Уул XIX			Тамсаг XXI				Нийт дүн		
	Гэрээлэгчийн тайлан	Аудитаар хассан	Аудитаар баталгаажуулсан	Гэрээлэгчийн тайлан	Аудитаар хассан	ӨНЗ-д шилжүүлэн залруулсан	Аудитаар баталгаажуулсан	Гэрээлэгчийн тайлан	Аудитаар хассан	Аудитаар баталгаажуулсан
2014	31,820,875.45	(25,153.95)	31,846,029.40	15,752,200.45	463,286.28	2,247,168.00	15,288,914.17	47,573,075.90	438,132.33	47,134,943.57
2015	32,248,289.50	(730.70)	32,249,020.20	15,473,823.21	2.11		15,473,821.10	47,722,112.71	(728.59)	47,722,841.30
2016	26,104,543.12	-	26,104,543.12	18,245,100.34	-		18,245,100.34	44,349,643.46	-	44,349,643.46
2017	21,508,092.06	-	21,508,092.06	16,392,324.68	-		16,392,324.68	37,900,416.74	-	37,900,416.74
2018	18,503,657.25	-	18,503,657.25	12,499,465.91	-		12,499,465.91	31,003,123.16	-	31,003,123.16
Дүн	130,185,457.38	(25,884.65)	130,211,342.03	78,362,914.59	463,288.39	2,247,168.00	77,899,626.20	208,548,371.97	437,403.74	208,110,968.23

Тосон Уул XIX талбайн 2014-2018 оны өртөг нөхөгдөх зардал

ам.доллар

Он	Гэрээлэгчийн тайлагнасан дүн			Аудитаар хассан		Залруулга	Аудитаар баталгаажуулсан дүн		
	ӨНЗ	Эх компанийн зардал	Нийт ӨНЗ	ӨНЗ	Эх компани		ӨНЗ	Эх компанийн зардал	Нийт ӨНЗ
2014	170,533,193.17	17,053,319.32	187,586,512.49	2,014,911.76	201,491.18	1,272.79	168,519,554.20	16,851,955.42	185,371,509.62
2015	150,796,116.42	15,079,611.64	165,875,728.06	4,514,046.67	15,079,611.64	8,960.83	146,291,030.58		146,291,030.58
2016	75,229,690.79	7,522,969.08	82,752,659.87	830,033.66	83,003.37		74,399,657.13	7,439,965.71	81,839,622.84
2017	84,853,588.63	8,485,358.86	93,338,947.49	1,186,187.72	118,618.77		83,667,400.91	8,366,740.09	92,034,141.00
2018	107,023,610.42	10,702,361.04	117,725,971.46	1,961,478.59	196,147.86		105,062,131.83	10,506,213.18	115,568,345.01
Дүн	588,436,199.43	58,843,619.94	647,279,819.37	10,506,658.40	15,678,872.81	10,233.62	577,939,774.65	43,164,874.41	621,104,649.06

Тамсаг XXI талбайн 2014-2018 оны өртөг нөхөгдөх зардал

ам.доллар

Он	Гэрээлэгчийн тайлагнасан дүн			Аудитаар хассан		Залруулга	Аудитаар баталгаажуулсан дүн		
	ӨНЗ	Эх компанийн зардал	Нийт ӨНЗ	ӨНЗ	Эх компани		ӨНЗ	Эх компанийн зардал	Нийт ӨНЗ
2014	189,308,845.82	18,930,884.58	208,239,730.40	4,760,237.09	476,023.71		184,548,608.73	18,454,860.87	203,003,469.60
2015	184,131,623.47	18,413,162.35	202,544,785.82	5,894,941.63	18,413,162.35	(8,960.83)	178,227,721.01		178,227,721.01
2016	77,648,948.51	7,764,894.85	85,413,843.36	1,580,210.04	158,021.00		76,068,738.47	7,606,873.85	83,675,612.32
2017	88,211,557.19	8,821,155.72	97,032,712.91	750,735.82	75,073.58		87,460,821.37	8,746,082.14	96,206,903.51
2018	106,612,768.60	10,661,276.86	117,274,045.46	486,827.96	48,682.80		106,125,940.64	10,612,594.06	116,738,534.70
Дүн	645,913,743.59	64,591,374.36	710,505,117.95	13,472,952.54	19,170,963.44	(8,960.83)	632,431,830.22	45,420,410.92	677,852,241.14

Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайн 1993-2018 онд нөхөгдөх боломжтой зардал

ам.доллар

Он	Баталгаажуулсан Өртөг нөхөгдөх зардлын дүн		Өртөгт тосоор нөхөгдсөн дүн /40%/		Нөхөгдөх боломжтой зардал			Тэмдэглэл
	XIX	XXI	XIX	XXI	XIX	XXI	Дүн	
XIX-талбай 1993-2013 он, XXI-талбай 1995-2013 он	1,481,197,506.74	502,284,934.41	473,851,767.23	33,649,381.17	1,007,345,739.51	468,635,553.24	1,475,981,292.75	Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталгаажуулсан үлдэгдэл
2014	185,371,509.62	203,003,469.60	143,890,951.87	75,517,745.79	41,480,557.75	127,485,723.82	168,966,281.57	ҮАГ-аас баталгаажуулсан
2015	146,291,030.58	178,231,693.92	65,875,767.11	49,296,341.77	80,415,263.47	128,935,352.15	209,350,615.62	ҮАГ-аас баталгаажуулсан
2016	81,839,622.84	83,675,612.32	42,343,244.72	47,774,946.32	39,496,378.12	35,900,666.00	75,397,044.12	ҮАГ-аас баталгаажуулсан
2017	92,034,141.00	96,206,903.51	54,082,994.79	65,117,991.15	37,951,146.21	31,088,912.35	69,040,058.56	ҮАГ-аас баталгаажуулсан
2018	115,568,345.01	116,738,534.70	63,834,808.47	66,759,467.70	51,733,536.55	49,979,067.00	101,712,603.55	ҮАГ-аас баталгаажуулсан
Дүн	2,102,302,155.80	1,180,141,148.46	843,879,534.19	338,115,873.89	1,258,422,621.61	842,025,274.57	2,100,447,896.18	

**Тосон Уул XIX талбайн газрын тосны борлуулалтын орлого хуваарилалт
2014-2018 он**

ам.доллар

д/д	Үзүүлэлт	Мөр дугаар	Гэрээлэгч	Аудитаар баталгаажуулсан	Зөрүү
1	Борлуулсан газрын тосны хэмжээ /баррель/	А	19,375,325.77	18,695,187.09	(680,138.68)
2	Нэгж үнэ /2014-2018 оны дундаж/ ам.дол	Б	57.12	57.12	-
3	Борлуулсан газрын тосны дүн	В	1,065,009,815.97	1,070,588,910.44	5,579,094.47
4	Борлуулалтын зардал	Г	146,430,197.36	145,519,493.03	(910,704.33)
5	Борлуулалтын орлого	Д /В-Г/	918,579,618.61	925,069,417.41	6,489,798.80
6	Роялти	Е /Д*5%/		46,253,470.87	46,253,470.87
7	Өртөгт газрын тос	Ё /Д*40%/	367,431,847.44	370,027,766.96	2,595,919.52
8	Ашигт газрын тос	Ж /Д-Е-Ё/	551,147,771.16	508,788,179.57	(42,359,591.59)
9	МУЗГ-т ногдох газрын тос	З /Ж*40%/	220,459,108.47	203,515,271.83	(16,943,836.64)
	Гэрээлэгчид ногдох газрын тос	И /Ж*60%/	330,688,662.70	305,272,907.74	(25,415,754.95)
10	МУЗГ-т ногдох нийт дүн	Й /Е+З/	220,459,108.47	249,768,742.70	29,309,634.23
	Роялти	Е	-	46,253,470.87	46,253,470.87
	Бүтээгдэхүүн хуваалт	З	220,459,108.47	203,515,271.83	(16,943,836.64)
11	Гэрээлэгчид ногдох нийт дүн	К /Ё+И/	698,120,510.14	675,300,674.71	(22,819,835.43)
	Өртөгт газрын тос	Ё	367,431,847.44	370,027,766.96	2,595,919.52
	Бүтээгдэхүүн хуваах	И	330,688,662.70	305,272,907.74	(25,415,754.95)

**Тамсаг ХХI талбайн газрын тосны борлуулалтын орлого хуваарилалт
2014-2018 он**

ам.доллар

Д/д	Үзүүлэлт	Мөр дугаар	Гэрээлэгч	Аудитаар баталгаажуулсан	Зөрүү
1	Борлуулсан газрын тосны хэмжээ /баррель/	А	16,054,152.86	16,126,039.40	71,886.54
2	Нэгж үнэ /жилийн дундаж/	Б	57.12	57.12	-
3	Борлуулсан газрын тосны дүн	В	849,942,958.65	853,262,505.16	3,319,546.51
4	Борлуулалтын зардал	Г	92,738,392.45	92,096,273.35	(642,119.10)
5	Борлуулалтын орлого	Д /В-Г/	757,204,566.20	761,166,231.81	3,961,665.61
6	Роялти	Е /Д*7.5%/	56,790,342.47	57,087,467.39	297,124.92
7	Өртөгт газрын тос	Ё /Д*40%/	302,881,826.48	304,466,492.72	1,584,666.24
8	Ашигт газрын тос	Ж /Д-Е-Ё/	397,532,397.26	399,612,271.70	2,079,874.44
9	МУЗГ-т ногдох газрын тос	З /Ж*40%/	159,012,958.90	159,844,908.68	831,949.78
	Гэрээлэгчид ногдох газрын тос	И /Ж*60%/	238,519,438.35	239,767,363.02	1,247,924.67
10	МУЗГ-т ногдох нийт дүн	Й /Е+З/	215,803,301.37	216,932,376.06	1,129,074.70
	Роялти	Е	56,790,342.47	57,087,467.39	297,124.92
	Бүтээгдэхүүн хуваалт	З	159,012,958.90	159,844,908.68	831,949.78
11	Гэрээлэгчид ногдох нийт дүн	К /И/	541,401,264.83	544,233,855.74	2,832,590.91
	Өртөгт газрын тос	Ё	302,881,826.48	304,466,492.72	1,584,666.24
	Бүтээгдэхүүн хуваах	И	238,519,438.35	239,767,363.02	1,247,924.67

**Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайн
нийт газрын тосны борлуулалтын орлого хуваарилалт
2014-2018 он**

ам.доллар

д/д	Үзүүлэлт	Мөр дугаар	Гэрээлэгч	Аудитаар баталгаажуулсан	Зөрүү
1	Борлуулсан газрын тосны хэмжээ /баррель/	А	35,429,478.63	34,821,226.49	(608,252.14)
2	Нэгж үнэ /жилийн дундаж/	Б	57.12	57.12	-
3	Борлуулсан газрын тосны дүн	В	1,914,952,774.62	1,923,851,415.60	8,898,640.98
4	Борлуулалтын зардал	Г	239,168,589.81	237,615,766.38	(1,552,823.43)
5	Борлуулалтын орлого	Д /В-Г/	1,675,784,184.81	1,686,235,649.21	10,451,464.41
6	Роялти	Е /Д*5%, 7.5%/	56,790,342.47	103,340,938.26	46,550,595.79
7	Өртөгт газрын тос	Ё /Д*40%/	670,313,673.92	674,494,259.69	4,180,585.76
8	Ашигт газрын тос	Ж /Д-Е-Ё/	948,680,168.42	908,400,451.27	(40,279,717.15)
9	МУЗГ-т ногдох газрын тос	З /Ж*40%/	379,472,067.37	363,360,180.51	(16,111,886.86)
	Гэрээлэгчид ногдох газрын тос	И /Ж*60%/	569,208,101.05	545,040,270.76	(24,167,830.29)
10	МУЗГ-т ногдох нийт дүн	Й /Е+З/	436,262,409.83	466,701,118.76	30,438,708.93
	Роялти	Е	56,790,342.47	103,340,938.26	46,550,595.79
	Бүтээгдэхүүн хуваалт	З	379,472,067.37	363,360,180.51	(16,111,886.86)
11	Гэрээлэгчид ногдох нийт дүн	К /И/	1,239,521,774.97	1,219,534,530.45	(19,987,244.53)
	Өртөгт газрын тос	Ё	670,313,673.92	674,494,259.69	4,180,585.76
	Бүтээгдэхүүн хуваах	И	569,208,101.05	545,040,270.76	(24,167,830.29)

**Тосон Уул XIX талбайн газрын тосны борлуулалтын орлого төвлөрүүлэлт
2014-2018 он**

ам.доллар

Огноо	Жилийн эхний үлдэгдэл тооцоо	Төлбөл зохих*	Улсын төсвийн дансанд төвлөрүүлсэн	Жилийн эцсийн үлдэгдэл тооцоо
2013.12.31				9,860,556.07
2014.12.31	9,860,556.07	97,126,392.51	90,260,788.26	16,726,160.32
2015.12.31	16,726,160.32	44,466,142.80	40,573,426.59	20,618,876.53
2016.12.31	20,618,876.53	28,581,690.19	25,838,996.03	23,361,570.69
2017.12.31	23,361,570.69	36,506,021.49	31,907,738.33	27,959,853.84
2018.12.31	27,959,853.84	43,088,495.72	38,472,545.69	32,575,803.87
Нийт дүн	9,860,556.07	249,768,742.70	227,053,494.90	32,575,803.87

**Тамсаг XXI талбайн газрын тосны борлуулалтын орлого төвлөрүүлэлт
2014-2018 он**

ам.доллар

Он	Жилийн эхний үлдэгдэл тооцоо	Төлбөл зохих*	Улсын төсвийн дансанд төвлөрүүлсэн	Жилийн эцсийн үлдэгдэл тооцоо
2013.12.31				3,915,349.42
2014.12.31	3,915,349.42	53,806,393.87	54,350,620.98	3,371,122.31
2015.12.31	3,371,122.31	35,123,643.51	35,841,838.82	2,652,927.00
2016.12.31	2,652,927.00	34,039,649.25	31,787,641.76	4,904,934.49
2017.12.31	4,904,934.49	46,396,568.70	46,069,973.90	5,231,529.29
2018.12.31	5,231,529.29	47,566,120.74	48,401,604.17	4,396,045.85
Нийт дүн	3,915,349.42	216,932,376.06	216,451,679.63	4,396,045.85

**Газрын тосны борлуулалтын орлого төвлөрүүлэлт
2014-2018 он**

Тосон Уул XIX, Тамсаг XXI

ам.доллар

Он	Жилийн эхний үлдэгдэл тооцоо	Төлбөл зохих*	Улсын төсвийн дансанд төвлөрүүлсэн	Жилийн эцсийн үлдэгдэл тооцоо
2013.12.31				13,775,905.49
2014.12.31	13,775,905.49	150,932,786.38	144,611,409.24	20,097,282.63
2015.12.31	20,097,282.63	79,589,786.31	76,415,265.41	23,271,803.53
2016.12.31	23,271,803.53	62,621,339.44	57,626,637.79	28,266,505.18
2017.12.31	28,266,505.18	82,902,590.18	77,977,712.23	33,191,383.13
2018.12.31	33,191,383.13	90,654,616.45	86,874,149.86	36,971,849.72
Нийт дүн	13,775,905.49	466,701,118.76	443,505,174.53	36,971,849.72

Тамсаг XXI, Тосон Уул XIX Бүтээгдэхүүн хуваах гэрээний талаарх тогтоол, шийдвэр, БХГ-ний нэмэлт өөрчлөлт, протоколууд

“Тамсаг XXI” Бүтээгдэхүүн хуваах гэрээний талаарх тогтоол, шийдвэр, нэмэлт өөрчлөлт			
№	Огноо	Нэр, дугаар	Хэлэлцэж, баталсан асуудал
1	1996.08.06	МУЗГ-ын 1996 оны 08 дугаар 06-ны өдрийн 27 дугаар хуралдааны тэмдэглэл “Газрын тосны талаар авах зарим арга хэмжээний тухай”	Австралийн Комманд Петролеум компаниар толгойлуулсан олон улсын газрын тосны консорциумын хооронд 1995 оны 12 дугаар сарын 11-нд байгуулсан Тамсагийн сав газрын “Тамсаг XXI” талбайд газрын тос хайж олборлох тухай бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийг нэг бүрчлэн авч үзсэний үндсэн дээр уг гэрээнүүдийг батламжлах асуудлыг Засгийн газарт албан ёсоор оруулахыг Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайдад даалгасан байна.
2	1996.08.07	МУЗГ-ын 183 дугаар тогтоол “Гэрээнүүд зөвшөөрөх тухай”	Монгол газрын тос товчоо болон АНУ-ын Территориол ресурсис компани, Австрали Улсын Комманд Петролеум компани, Олон улсын газрын тосны консорциумын хооронд “Матад XX”, “Тамсаг XXI” талбайд газрын тос хайж олборлох тухай 1995 оны 12 дугаар сарын 11-нд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийг зөвшөөрсөн байна.
3	1996.08.09	МУЗГ-ын 3Г/144 дугаар Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийн батламж	Монгол Газрын Тос товчоо болон Австралийн Комманд Петролеум компаниар толгойлуулсан олон улсын газрын тосны консорциумын хооронд 1995 оны 12 дугаар сарын 11-нд байгуулсан Тамсагийн сав газрын “Тамсаг XXI” талбайд газрын тос хайж олборлох тухай Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийг МУЗГ-ын 1996 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 183 тогтоолоор тус тус зөвшөөрснийг МУЗГ-ын гишүүн, Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд гарын үсэг зурж батламжилсан байна.
4	1995.12.11	Тамсаг XXI гэрээт талбайн талаар Монголын газрын тосны товчоо болон Австралийн Комманд Петролеум лимитед, Монголын цагаан шонхор ойл корпорац, АНУ-ын Снайдер ойл-Тамсаг Монголиа Инк нарын хооронд байгуулсан	Бүтээгдэхүүн хуваах гэрээ нь 25 зүйл, А, В, С, Д, Е гэсэн 5 хавсралттай.
“Тосон Уул XIX” Бүтээгдэхүүн хуваах гэрээний талаарх тогтоол, шийдвэр, нэмэлт өөрчлөлт			
№	Огноо	Нэр, дугаар	Хэлэлцэж, баталсан асуудал
1	1993.04.26	“Тосон Уул XIX” гэрээт талбайн талаар Монгол газрын тос (МГТ) компани болон Медалион Монгол Ойл (ММО) компанийн хооронд байгуулсан	Бүтээгдэхүүн хуваах гэрээ нь 25 зүйл, А, В, С, Д, Е гэсэн 5 хавсралттай.
2	-	Гэрээг батламжлах хүсэлт	Гэрээг батламжлах хүсэлт, Гэрээг батламжлах, Гэрээг зөвшөөрөх ЗГ-ын тогтоолыг Ашигт малтмал, газрын тосны газар, Архивын Ерөнхий газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын архиваас авахаар албан бичгийг хүргүүлсэн боловч эдгээр байгууллагын архивд хадгалагдаагүй байна.
3	-	МУЗГ-ын тэмдэглэл	
4	-	МУЗГ-ын 253 дугаар тогтоол	
5	1993.07.01	Монгол газрын тос (МГТ) компани, Медалион Монгол Ойл (ММО) компанийн хооронд байгуулсан Бүтээгдэхүүн хуваах тухай гэрээнд оруулсан тодотгол	Бүтээгдэхүүн хуваах гэрээнд оруулсан 5 заалт бүхий тодотголыг Монгол газрын тос (МГТ) компанийн өмнөөс Ерөнхий захирал Д.Сэнгээ, Медалион Монгол Ойл (ММО) компанийн өмнөөс ерөнхийлөгч Х.С.Финкелстейн нар англи, монгол хэл дээр үйлдэж, харилцан тохиролцсон байна.
6	1997.12.10	МУЗГ-ын 239 дүгээр тогтоол	Газрын тосны хайгуул, олборлолтын явуулах гэрээт талбайг өргөтгөх тухай нэмэлт гэрээ байгуулсан байна.
“Тамсаг XXI”, “Тосон Уул XIX” Бүтээгдэхүүн хуваах гэрээний талаар Газрын тосны хэрэг эрхлэх газар, гэрээлэгчийн хооронд тохиролцсон протоколууд			
1	2004.01.31	Газрын Тосны хэрэг эрхлэх газар, Соко Тамсаг Монгол ХХК-ийн хооронд байгуулсан нэмэлт хэлэлцээр	БХГ-ний эрэл, хайгуулын ажил явуулах хугацааг ГТХЭГ-аас сунгасан хугацаа дууссанаас хойш 5 хүртэлх жилээр хугацаа сунгах, захиргааны шимтгэл төлөх, газрын түрээсийн төлбөр төлөх, гэрээлэгч БХГ-ний “А” хавсралтад зааснаас багагүй хөрөнгийг наад захын ажил үүрэгт зарцуулах тухай, энэхүү хэлэлцээр 2005 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2010 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал хүчинтэй тухай тохиролцсон байна. Энэхүү нэмэлт

			хэлэлцээр А, Б хавсралтай. 2005 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс 2010 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал хүчинтэй.
2	2004.02.16	Газрын тосны хэрэг газар, Соко Тамсаг Монгол (ХИХ) компанийн хооронд байгуулсан түүхий тос тээвэрлэх, борлуулах тухай протокол	Монголын Засгийн газарт ногдох түүхий тосыг СОКО компанид ногдох тосны хамт борлуулж байгаа үед Монголын Засгийн газар СОКО компанийн үйлчилгээ, тоног төхөөрөмжийг ашиглан олборлосон түүхий тосыг олборлолтын цэгээс тос хүлээн авах цэг хүртэл хүлээн авч, тээвэрлэж байхыг талууд хүлээн зөвшөөрсөн байна.
3	2004.02.25	Соко Тамсаг Монголиа Инк болон Хуйбей Газрын тосны Захиргааны алба хооронд байгуулсан Өрөмдлөгийн гэрээ	Өрөмдлөгийн болон бусад үйлчилгээ үзүүлэх /Талбай 19, 21, 22/
4	2005.04.01	Approval of assignment Соко Тамсаг Монгол ХХК-иас Дачин Ойлфилд Лимитед компанид эрх шилжүүлсэн гэрээ	БХГ-ний 24 дүгээр зүйлд эрх шилжүүлэлтийг МУЗГ-ын бичгээр өгсөн зөвшөөрлийн дагуу олгохоор заасан боловч Австралийн Комманд Петролеум компаниар толгойлуулсан олон улсын газрын тосны консорциум нь "СОКО Монгол Инк"-д эрхээ шилжүүлсэн тухай болон Соко Тамсаг Монгол ХХК-иас Дачин Ойлфилд Лимитед компанид эрх шилжүүлснийг МУЗГ-ын бичгээр өгсөн зөвшөөрөл зэрэг холбогдох баримт Ашигт малтмал, газрын тосны газар, Архивын Ерөнхий газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын архиваас авахаар албан бичгийг хүргүүлсэн боловч эдгээр байгууллагын архивд хадгалагдаагүй байна.
5	2011.06.24	Газрын тосны газар Петроцайна Дачин Тамсаг ХХК-ийн хооронд байгуулсан протокол	Тосон Уул XIX, Тамсаг ХХI талбайгаас олборлож буй түүхий тосыг борлуулах асуудлаар харилцан тохиролцсон байна. Газрын тосны газар, Петроцайна Дачин Тамсаг ХХК болон худалдан авагч талууд харилцан тохиролцож, газрын тосны газрын зөвшөөрлийг авсны үндсэн дээр Петроцайна Дачин Тамсаг ХХК нь худалдан авагч талтай тус гэрээг байгуулахаар тохиролцсон байна.
6	2011.06.24	Петроцайна Дачин Тамсаг ХХК болон Газрын тосны газар нь тус газрын Тамсаг дахь Төлөөлөгчийн албаны үйл ажиллагаа болон орон нутгийн хөгжлийг дэмжиж ажиллах талаарх протокол	Петроцайна Дачин Тамсаг ХХК-ийн газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж буй Тосон Уул XIX, Тамсаг ХХI талбайнууд ашиглалтад шилжиж байгаатай холбогдуулан төлөөлөгчийн албаны үйл ажиллагаанд зориулан талбай тус бүр 50.000 ам доллар төлөх тухай, орон нутгийн хөгжилд дэмжлэг болгон талбай тус бүр 50.000 ам доллар төлөх тухай, Матад болон Халх сумын нутагт тус бүр 15.000 ам доллар төлөх төлбөрүүдийг 2011 оноос эхлэн шилжүүлэх болон энэ протоколд тусгаснаас өөр хандив, тусламжийг орон нутагт төлөхгүй байхаар, дээрх төлбөрүүдийг өртөгт тосоор нөхөн төлөхгүй болохыг харилцан тохиролцсон байна. Энэхүү протокол нь XIX, ХХI талбайн талаар байгуулсан БХГ-ний салшгүй хэсэг болно гэж тохирсон байна.
7	2012.12.01	МУЗГ-ын 2012 оны 154 дүгээр тогтоол	Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахад зориулсан уурхайн эдэлбэрийн зөвшөөрөл олгох тухай
8	2013.12.31	Петроцайна Дачин Тамсаг ХХК болон Газрын тосны газрын хооронд байгуулсан протокол	Засгийн газарт ногдох түүхий тосны хэмжилтийн цэгийг тодорхойлох, Засгийн газарт ногдох түүхий тосны борлуулалтын орлогыг тооцох талаар тохиролцсон байна.
9	2013.12.31	Петроцайна Дачин Тамсаг ХХК болон Газрын тосны газрын хооронд байгуулсан протокол /чиглэл тус бүрээр/	1. Тосон Уул XIX-Баянхошуу-СУ1 ОИБ 2. Тосон Уул XIX-Бичигт Рашаант 3. Тосон Уул XIX (ТА-1 ОИБ)- Бичигт Рашаант 4. Тамсаг ХХI-Баянхошуу-СУ1 ОИБ 5. Тамсаг ХХI- Бичигт Рашаант гэсэн чиглэлүүдээр экспортолж буй түүхий тосны хэмжилт болон МУЗГ-т ногдох түүхий тосны борлуулалтын орлогыг тооцох, XIX, ХХI талбайн хооронд дотоод тээвэр зэрэг асуудлаар харилцан тохиролцсон байна.
10	2014.01.06	Петроцайна Дачин Тамсаг ХХК болон Газрын тосны газрын хооронд байгуулсан протокол	Газрын тосны газар болон Петроцайна Дачин тамсаг ХХК хамтран жилийн уулзалтыг зохион байгуулж, Тосон Уул XIX, Тамсаг ХХI талбайд өмнөх оны төлөвлөсөн ажлын хэрэгжилт, дараагийн онд хийгдэх ажлын хөтөлбөр төсвийг хэлэлцэж, талууд БХГ-ний заалтуудыг үргэлжлүүлэн тогтвортой хэрэгжүүлэх үндсэн зарчим болгож харилцан тохиролцдог.
11	2015.04.28 2016.04.03 2017.03.17 2018.08.21 2019.01.06	Ашигт малтмал, газрын тосны газрын хэлтсийн мэргэжилтэн, Петроцайна Дачин Тамсаг ХХК-ийн Тосон Уул XIX, Тамсаг ХХI талбайн дэд захирал	МУЗГ-ын баталсан БХГ-т Тосон Уул XIX, Тамсаг ХХI талбайгаас 2014-2018 онд олборлосон хий, тос, усны тооцоог Ашигт малтмал, газрын тосны газар, Петроцайна Дачин Тамсаг ХХК-тай жил болгон талбай тус бүрээр нийлж баталгаажуулсан байна.
12	2013.12.11	Түүхий газрын тос борлуулах гэрээ	Энэ дагуу гэрээлэгч 2014-2018 онд Хятадын үндэсний газрын тосны нэгдсэн корпорац /China national united oil corporation/, Петроцайна олон улсын /Хонг Конг/ корпорац /PetroChina International /Hong

			Kong/ Corporation Limeted/-тай газрын тос борлуулах нийт 3 гэрээг 2014-2018 онд жил бүр сунгаж ирсэн байна. Үүнд: №14CBJCR0011E- БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хайлаар газрын тосны талбайд байрлах SU131 блокийн буулгах станц; №14CBJPRB0011- БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн газрын тосны талбайд байрлах Aershan буулгах станц; №IN14CODO11S - БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн газрын тосны талбайд байрлах Aershan буулгах станц;
--	--	--	--



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 09 дугаар сарын 26 № 980/А0110001

Улаанбаатар хот

АХГ-2021/16-НАА-СА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Газрын тосны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2-т заасны дагуу газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж буй Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн 2014-2018 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн Тосон Уул XIX, Тамсаг XXI гэрээт талбайн талаар 1993, 1995 онд байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээг Газрын тосны тухай хуульд нийцүүлэн шинэчлээгүй байна.

Энэ нь Газрын тосны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2. "газрын тосны тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газраас гаргасан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах" мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1. "газрын тосны тухай хууль тогтоомж, Засгийн газар болон төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан шийдвэрийн биелэлтийг хангах" гэж заасантай тус тус нийцээгүй, мөн Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 130 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1. "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тосон Уул XIX гэрээт талбайн талаар 1993 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр байгуулсан болон Тамсаг XXI гэрээт талбайн талаар 1995 оны 12 дугаар сарын 11-ний өдөр байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх;
2. Цаашид хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Л.Баярмандал, Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн ерөнхийлөгч Жу Да Ли нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАНДАНБАТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2022 оны 09 дугаар сарын 26 № 199/АД150053
АХГ-2021/16-НАА-СА

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Газрын тосны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2-т заасны дагуу газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж буй Петровича Дачин Тамсаг ХХК-ийн 2014-2018 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Газрын тосны борлуулалтын орлогыг дутуу тайлагнасан, борлуулалттай холбогдон гарах зардлыг илүү тооцсон, мөн Тосон Уул XIX талбайд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулаагүй зэргээс шалтгаалан Монгол Улсын Засгийн газарт 30,438,708.94 ам.доллар буюу 66,727,588,846.38 төгрөгийг дутуу тооцож төвлөрүүлсэн байна.

Энэ нь бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулж байх үед мөрдөж байсан БНМАУ-ын Газрын тосны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 "Гэрээлэгч нь газрын тос олборлосны төлбөрийг улсад төлнө. Төлбөрийн хэмжээг Монгол Улсын Засгийн газар тогтооно", мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 "Гэрээлэгч нь газрын тос олборлосны төлбөр болон зардлаа нөхөх хэсгийг нийт олборлолтоос хасаад үлдсэн бүтээгдэхүүнийг газрын тосны хэрэг эрхлэх байгууллагатай хуваана", Тосон Уул XIX гэрээт талбайн талаар байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээний 2 дугаар зүйл "Төлбөр (роялти) гэж Монгол Улсын Газрын хэвлийн тухай болон Газрын тосны тухай хуулийн дагуу байгалийн дахин сэргээгдэхгүй нөөц баялгийг ашигласны төлбөрийг хэлнэ. Энэ төлбөрийг олборлосон нийт бүтээгдэхүүнд ногдуулж, өртөгт тосыг хуваарилахаас өмнө төлнө", Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон Гэрээлэгч хооронд 2014-2018 онд экспортолсон тосны хэмжээг харилцан тохиролцож баталгаажуулсан Протоколууд, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 14 дүгээр зүйлийн 14.3.1 "анхан шатны баримт бүрдүүлэх" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан

шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-т заасныг үндэслэн
ТОГТООХ нь:

1. Петрочайна Дачин Тамсаг ХХК-иас 30,438,708.94 (гучин сая дөрвөн зуун гучин найман мянга долоон зуун найман ам.доллар ерэн дөрвөн цент) буюу 66,727,588,846.38 (жаран зургаан тэрбум долоон зуун хорин долоон сая таван зуун наян найман мянга найман зуун дөчин зургаан төгрөг гучин найман мөнгө)-ийг нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Л.Баярмандал, Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн ерөнхийлөгч Жу Да Ли нарт хариуцуулав.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

АКТ ТОГТООСОН:

Ц.НАРАНЧИМЭГ

Д.ЭНХДАЛАЙ

Л.НЯМТӨМӨР

Б.ЭРДЭНЭЗУЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 26 № 982/А0150053
АХГ-2021/16-НАР-СЯ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Газрын тосны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2-т заасны дагуу газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж буй Петровича Дачин Тамсаг ХХК-ийн 2014-2018 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон гэрээлэгч хооронд газрын тос экспортлох үйл ажиллагааны үед гарах технологийн хорогдлын хэмжээг харилцан тохиролцож баталгаажуулаагүйгээс талууд 2014-2018 онд борлуулсан газрын тосны хэмжээг 175,419.17 баррелиар, борлуулалтын орлогыг 8,298,497.07 ам.доллар буюу 20,791,315,800.15 төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Газрын тосны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.8 "гэрээлэгчийн тухайн жилийн хөрөнгө оруулалт, зардал, нөөц ашигласны төлбөр, олборлосон болон борлуулсан газрын тосны тайланг хянаж нэгтгэх", 11 дүгээр зүйлийн 11.2.14 "санхүүгийн тайлан, өртөг нөхөгдөх зардлын тайлан, газрын тос хуваах тооцоог ... үнэн зөв гаргаж, төрийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгөх", Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон Гэрээлэгч хооронд 2014-2018 онд экспортолсон тосны хэмжээг харилцан тохиролцож баталгаажуулсан Протоколуудтай зөрчилдөж байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Газрын тос экспортлох үйл ажиллагааны үед гарах технологийн хорогдлын хэмжээг бодит тооцоо судалгаанд үндэслэн тогтоож эрх зүйн актаар баталгаажуулах, хэрэгжилтийг хангах арга хэмжээг авч биелэлтийг 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй ажиллахыг Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Л.Баярмандал, Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн ерөнхийлөгч Жу Да Ли нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР


АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Д.ЭНХДАЛАЙ

Л.НЯМТӨМӨР

Б.ЭРДЭНЭЗУЛ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 09 дугаар сарын 26 № 983/АО/50053
АХГ- 2021/16-КАА-СА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Газрын тосны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2-т заасны дагуу газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн 2014-2018 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

а) Бүтээгдэхүүн хуваах гэрээнд Монгол Улсын хууль тогтоомжтой нийцээгүй заалтууд байна. Үүнд:

1. БХГ-ний 17.2 “Гэрээлэгч нь Монгол Улсын хилийн чанадад гадаадын банкуудад аливаа валютаар данс нээх, хадгалах, хянах, гүйлгээнд ашиглах, мөн эдгээр дансыг бүрэн хяналтандаа байлгах, ийм дансанд байгаа мөнгөн хөрөнгөө чөлөөтэй ашиглах болон гадаадад байлгах эрхтэй” гэсэн нь Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.6 “Хөрөнгө оруулалт, борлуулалтын орлоготой холбоотой гүйлгээг Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэх бөгөөд уг гүйлгээг санхүүгийн тайланд ил тод, нээлттэй бүрэн тусгах” гэсэнтэй нийцээгүйгээс тайлант онд (Hong Kong)-ын Bank of China банкаар Хөрөнгө оруулалт, борлуулалтын орлоготой холбоотой нийт 501.9 сая ам.долларын гүйлгээ хийсэн байна;
2. БХГ-ний С хавсралтын 2 дугаар зүйлийн “О” “Эх компанийн захиргааны нэмэгдэл зардлыг “Гэрээний дагуу газрын тостой холбогдсон үйл ажиллагааны явцад Монгол Улсын хилийн чанадад гэрээлэгчийн эх компанийн (үүний дотор хувь нийлүүлэгч багтана) ажиллагсдын гүйцэтгэх ажил үйлчилгээ болон конторын ажилд хамаарах захиргааны нэмэгдэл зардал нь газрын тостой холбоотой гэрээлэгчийн жилийн зардлын 10 хувь байна” гэсэн нь Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.6 “гэрээлэгчийн захиргааны зардал нь тухайн жилийн өртөг нөхөх зардлын тав хүртэл хувь байх” гэсэн хэсэгтэй нийцээгүйгээс Эх компанийн захиргааны нэмэгдэл зардлыг 10 хувиар тооцож байна;
3. БХГ-ний 10 дугаар зүйлийн 10.4.ж “Гэрээлэгчийн болон оролцон гүйцэтгэгчийн гадаадын ажиллагсад нь Монгол Улсын Засгийн газар, тухайлбал түүний аль нэг улс төрийн байгууллагаас ногдуулах орлогын бүх татвар, нийгмийн даатгалаас чөлөөлөгдөнө” гэсэн нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2, 16 дугаар зүйлийн 16.1, 16.3, 17 дугаар зүйлийн 17.1.1, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2 дахь заалттай тус тус нийцээгүйгээс Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас авч ажиллуулсан 2014 онд 169, 2015 онд 180, 2016 онд 185, 2017 онд 120, 2018 онд 118 гадаад ажилтанд олгосон цалин, урамшууллаас нийт 2.0 сая ам.долларын нийгмийн

даатгалын шимтгэлийг суутган аваагүй, ажил олгогчоос төлөх 4.0 сая ам.доллар нийт 6.0 сая ам.долларыг Нийгмийн даатгалын санд төвлөрүүлээгүй байна;

4. Дээрх ажилтнуудад олгосон цалин, урамшууллаас 2014-2018 онд нийт 2.9 сая ам.долларын хувь хүний орлогын албан татварыг суутган авч төсөвт төвлөрүүлээгүй нь Хувь хүний орлогын албан татварын тухай хууль (хуучнаар)-ийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д заасантай нийцэхгүй байна.

б) Хууль тогтоомж БХГ-ээр зохицуулахаар заасан зарим заалт огт хэрэгжээгүй байна.Үүнд:

1. Гэрээлэгч тусгай зөвшөөрөлтэй талбайд хийж байгаа газрын тостой холбогдсон бүх үйл ажиллагааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу бүртгэлд бүрэн тусгаж, тайлагнахгүй байгаа нь Газрын тосны тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 36 дугаар зүйлийн 36.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг;
2. Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.9 “байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ бүрэн гүйцэд биелүүлэх, хайгуул, ашиглалтын барилга байгууламжийг татан буулгах баталгаа болгон тухайн жилийн хайгуулын ажлын хөрөнгө оруулалтын гурван хувь, ашиглалтын үед гэрээлэгчид ногдох ашигт газрын тосны нэг хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгийг жил бүр төлөвлөгөө батлагдсанаас хойш 60 хоногийн дотор Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг банкны эскроу дансанд байршуулах” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.
3. Мөн хөрөнгө оруулалт, ӨНЗ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тайланг англи хэл дээр бүртгэн тайлагнаж, анхан шатны баримтуудыг хятад хэл дээр үйлдсэнийг газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас монгол хэлээр хөрвүүлж хүлээн аваагүй нь Монгол хэлний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 “Монгол Улсын нутаг дэвсгэрт дараах үйл ажиллагаа, албан хэргийг монгол хэлээр хөтлөн явуулна, 6.1.1 “төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагаа, албан хэрэг хөтлөлт” болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 “Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагын төлөөний газар нь нягтлан бодох бүртгэлээ монгол хэлээр хөтөлнө” гэж заасантай нийцэхгүй байна.

Энэ нь Газрын тосны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 “газрын тосны тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газраас гаргасан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах” мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 “газрын тосны тухай хууль тогтоомж, Засгийн газар болон төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан шийдвэрийн биелэлтийг хангах” гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нийгмийн даатгалын шимтгэл болон хувь хүний орлогын албан татвартай холбоотой тооцооллыг дахин хийж, холбогдох байгууллагуудаар баталгаажуулах;
2. Газрын тос олборлох үйл ажиллагаанд Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөж ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
3. Цаашид хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Л.Баярмандал, Петровича Дачин Тамсаг ХХК-ийн ерөнхийлөгч Жу Да Ли нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Д.ЭНХДАЛАЙ

Л.НЯМТӨМӨР

Б.ЭРДЭНЭЗУЛ